



Түмэнбаярын  
БУМ-ЭРДЭНЭ

**ҮР  
ХАГАМ**

## ҮР ХАРАМ.

Хүмүүсийн хашгичих, машин техникийн хяхтнах чимээ намайг сэрээлээ. Эргэж унтахыгхичээсэн ч нойр хүрэхгүй юм. Өглөө болгон эрт сэрээд сурчихсан бололтой. Босох гэжөндийв. “Юундаа ч яарах билээ” гэж бодогдоно. Буцаж хэвтэв. Тэгсээр байтал нойр бүрэнсэргэх нь тэр. Тэтгэвэртээ гарах гэдэг сонин мэдрэмж. Өчигдөрхөн манай эмнэлэг, манайтасгийнхан намайг тэтгэвэрт гаргасан гэхээр хаашаа юм дээ, өтөл нас руу минь үдэж өгсөнгэвэл болох юм уу. Түүнийгээ бас гавьяаныхаа амралт гэчихжээ. За даа, тэдни йг чхэлэлтгүй, өдий болтол ажиллах хугацаанд олон ч хүн тэтгэвэрт гарч байсан даа. Тэр үедийм өдөр надад ирэхгүй юм шиг л бодож явж. Цаг хугацаа гэж . . . Хүн болгон л хэзээнэгэн цагт над шиг ингэж санаа алдацгаадаг байх даа. Би элдвийг бодож хэзээ ч юм хагарсан, бас хэзээ ч юм хэн нэг нь битүүлж шавардсан адарширтэн хэвглээ. Адарын тэр хагархай гүрэлзэж гүрдийн, хөгшин хүний судас шигсанагдана. Яагаад ч юм “Ийм судсанд тариа хийвэл мөн амархан олодоо доо” гэж бодлоо. Ёстой л нөгөө мэргэжлийн өвчин гэж иймэрхүү юмыг хэлдэг байх даа гэж санахаар инээдч хүрэх шиг. Намайг сэрвэлзээд унахаар тэгсэн үү, өвгөн маань яраглан тамшаалаад дээшхаран хэвглээ. Хажуудаа хүн байгааг гэнэт санасан мэт би түүнийг тогтуун харав. Цавцагаан толгойтой ёнхигор өвгөн л нойрсоно. Сайхан өвгөн. Тиймээ, сайхан ч өвгөн, сайханч хүн. Миний хань. Тэр унтаж байгаа хэдий ч бие цогцос нь сэрж байгаа. Одоо мөдхөн нүдээ нээнэ. Би мэдэжбайнаа. Би чинь насаараа эмч хийсэн хүн шүү дээ. Миний бодлыг батлах мэт өвгөн нүдээалгуурхан нээлээ. Тэгснээ- Яасан бэ дээ хөгшөөн? Нойр нь хүрдэггүй юү? Тэгдгийм даа тэгдгийм. Хэд хоногоосдаснаа хө гэлээ. Би түүний сэрэхийг мэдэж байсан шиг тэр миний нойр сэрвэлзсэнийучрыг мэдэж байгаа бололтой. Аргагүй дээ, өвгөн маань цэргийн хүн тул надаас аль эрт, бараг үсэнд нь сор унав уу, үгүй юү тэтгэвэртээ гарсан хүн. Тэгээд л тэтгэвэртээ гарсанэхний өглөө ямар байдгийг мэдэрч байгаа хэрэг. Хөөрхий дөө, яг тэр үедээ над шиг, бүрнадаас ч хэцүү байсан биз. Би тэр үед нь юун ингэж ойлгохтой манатай. Харин ч бүр “Затэтгэвэрийн өвгөн минь хоол цайгаа хийгээд, хог шороогоо цэвэрлээд олигтойхонбайгаарай. Битгий хов жив ярьж, хавь ойрын эмгэчүүл рүү сэлбэлзээд байгаарай” гэжирээд л цаашлуулж байж билээ. “Ээ дээ, хүн гэдэг ер нь өөр дээр нь ирэхгүй л бол юу чойлгохгүй, мэдрэхгүй сонин амьтан байдаг юм байна даа” гэж ёнхигор шар өвгөний өндөрхамрыг ширтэн хэвтэхдээ бодож байлаа. Тэгтэл өвгөн маань- Энэ улс одоо хүн амьтан амарч байгаа гэж огт боддоггүй л юм байх даа гэж үглэв. Нээрээ л намайг сэрээсэн нөгөө чихэнд чийртэй чимээ үргэлжилсээр л байлаа. Манай энэхавийн хуучин байшингуудыг нурааж оронд нь цоо шинэ өндөр, өндөр барилг ууд барьжбайгаа юм. Хэзээ мөдгүй манай байрыг ч нураах л юм гэсэн. Хэдийгээр оронд нь орд харшшиг сайхан өргөө барина гэх боловч бараг энэ насны амьдралаа өнгөрүүлсэн байрыг миньнураана гэхээр сэтгэл өвдөх ч шиг. Миний бодлыг тасалж өвгөн- Хөгшөөн, босч цайгаа чанавал яасын? Одоо унтах ч бүр өнгөрөв бололтой гэж хүнгэнэв.- За за тэгье дээ, тэгье гээд өндийж цаг харвал 5:45. Цагны хажууд өнгө зүсээ алдаж, үмхэрч ноорсон “Бүжин” хэвтэх суухын завсар өөөлдөж харагдана. Харин гадаа, ирж буйцаг гэсэндээ нар аль хэдийн манджээ. Унтлагын өрөөнөөсөө шууд л гал тогоо руучиглэлээ. Өглөө эрт болохоор манай цонхон доогуур шахуу өнгөрөх зам чөлөөтэйхарагдана. Төд удалгүй үүгээр тоо тоймшгүй олон машин юунд ч юм яаран давхилда х

болно.Өчигдөр манайхны өгсөн цэцэгнүүд ширээн дээр хөглөрч харагдана. Баяр хүргэхэд цэцэгөгөх нь нэг ёсны соёл гэх боловч хэдхэн хоноод үхчихдэг болохоор өнөөх хүргэсэн баярнь тэгэсгээд дуусчихна гэж боддоггүй л юм байх даа. Миний энэ бодол мэдээж орчинцагийн залууст таалагдахгүй нь лавтай. Гэхдээ нэгэнт ороод ирсэн бодлыг одоо яалтай.Цайгаа гал дээр тавьчихаад, одоо ингээд усанд ороод шууд л ажилдаа гарах ёстой мэтбодогдоод болох биш. “Өнөөдөр тэгээд юугаа хийх вэ?” Энэ бас л сонин бодол. Урд ньингэж бодож байснаа санахгүй юм даа. Хийх ажил тодорхой байсан болоод тэр байх.Эмнэлэгтээ асрагч, нярав гээд юүхэн хээхэн хийе гэж даргаасаа гуйдаг ч юм бил үү. Үгүйээ, тэр ажлыг ч гэсэн хэн нэгэн хүн хийж л байгаа шүү дээ. Тэгэхээр яалаа гэж надад өгөвгэж. За, за олон юм бодож байхаар өнөөдөр гэрээ нэг сайхан цэвэрлэе. Эмэгтэй хүн гэдэгсонин шүү дээ. Гэрээ цэвэрлэж хүртэл жаргаж чаддаг.Гэрээ тойруулж харлаа. Сэтгэл санаа маань уйтайхан байгаа болохоор тэр үү гэр ч гэсэнгундуухан, бүрэнхий дүү. Хананд өлгөөтэй зурагнууд дунд Сувдаагийн маань зураг альтэртээ олон жилийн өмнөх шигээ инээмсэглэсэн хэвээрээ ч сэтгэл дагаад тэр үү нүдэнд ньгуниг хурсан ч юм шиг. Гараараа нүүрний шилийг нь арчлаа. Тоос дарчихаж. Ойрдцэвэрлээгүйн дээр хажууханд барилгын ажил хийгдэж байгаа болохоор нэг давхрын цонхонгойлгохгүйг хичээх ч яаж ийж байгаад л шороо дараад болж өгөхгүй юм. Түүнийзургийг ширтжээ зогстол нэгэн гар мөрөн дээр м инь зөөлхөн хүрлээ. Өвгөн мааньбосчихож.- Энэ зургийг харахаар яг л тэр үеийнх шигээ байгаа юм шиг санагддаг гэж тэр маань хэлжбайна. “Тиймээ, яг л тэр үеийнх шигээ” гэж бодсон ч түүнд юм хэлсэнгүй, толгой лдохилоо. Өвгөн хэсэг харж зогссоноо цааш эргэн явав. Бодвол угаалгын өрөө рүү биз.Өвгөнтэйгээ хоёул цайгаа уучихаад гэрээ цэвэрлэлээ. Цаг өнгөрөөд аятайхан ч юм шиг.Гэтэл гэнэтхэн “Өнөөдөр дуусчихвал маргааш юугаа хийнээ” гэсэн бодол харвав.- Өвгөөн! Өнөөдөр ч яахав. Маргааш юугаа хийнээ гэтэл- Хийх юм аяндаа олддог юмаа. Ер нь тэгээд тэгж, ингэжээ байтал өдөр өнгөрчихнө шүүдээ гэж өнөөх чинь их л туршлагатай цаг өнгөрөөгчийн дүрд хувилав.- Анхмаагийнд очдог юм билүү? гэтэл- Хаа байсан Дархан руу яаж явах вэ. Тэгээд ч тэр чинь чи бид хоёрыг бодвол залуу хүншүү дээ гэнэ.“Нээрээ ч тийм дээ. Биднээс залуу юм болохоор тэтгэвэртээ гараагүй байж таарна даа” гэжбодохтой зэрэг атаа төрөх ч шиг. Өвгөн миний сэтгэлийг ойлгов бололтой- Хөгшөөн! Санаа зоволтгүй дээ. Маргаашнаас бага охины банди нар шуугилдаад л ирнэ.Чи ч хэрдээ таарсан ажилтай болно гэсэн үг гэлээ. Бид хоёр охинтой, таван зээтэй хүмүүсл дээ. Том охиноос минь хоёр охин, бага охиноос минь гурван банди төрсөн юм.Нээрээ л өвгөний хэлснээр маргааш гэлтгүй оройдоо охид, хүргэдүүд бөөнө өрөөирцгээлээ. Намайг тэтгэвэрт гарлаа гэж баярлацгааж байна гэх үү, эсвэл эмзэглэж байнагэх үү ямартаа ч бид сайхан хоол хийж, бөөнөөрөө бужигнацгаалаа даа. Манай бага хүргэнийх гярхай. Намайг юу бодож байгааг гадарласан бололтой- Ээж, тэгээд одоо юу хийе гэж бодож байна даа гэхэд Сувдаа- Ажил нь бэлэн ш дээ. Манай гурав байна гэх нь хүүхэд хар л гэсэн үг бололтой. Харинтом охин маань- Цаг сайхан дулаарч байгаа юм чинь аав ээж хоёр амралтанд явна байгаа. Одоо мөдхөнзуны эхэн сар гарлаа гэхэд Сувдаа- Өө, дэмий, дэмий, хаврын хавсарганд жиндчихнэ. Тэгснээс зунаас болсон нь дээр гэхэд

өвгөн- Хэ, зун ч мэдэхгүй ээ. Хүүхдүүд амраад ирэхээр биднийг ер нь гэрээс гаргах уу? гэхэд том хүргэн- Харин тийм. Эдний гурав, дээр нь манай хоёр нэмэгдчихээр мөн ч бужигнана даа гэх нь бас л хоёр охиноо харуулах бололтой. Тэгтэл бага хүргэн маань- Ээж одоо завтай болсон юм чинь ном бичээч гэхэд бид бүгдээрээ гайхацгаалаа. Би ч гэсэн бүр мэлэрч гүйцэв. Сувдаа- Чи юу яриад байгаа юм бэ? Насаараа эмч хийсэн хүн яаж ном бичих юм? Манай энэ ихсонион гээд толгойгоо түүн рүү сэжихэд хүргэн- Юу хийж явсан нь ямар хамаатай юм. Насаараа амьдарна гэдэг чинь л өөрөө ном байхгүй юу. Тэгээд ч аав ээж хоёрын амьдрал сонин ш дээ. Сувдаа- Юу нь сонин гэж? Чи одоо өөлөөд байгаа юм уу хаашаа юм гэж шарвалзахад том хүргэндэмжих өнгөөр- Харин. . .? Би ер ойлгосонгүй гэхэд том охин нилээн бодож сууснаа- Дүүгийн зөв юм байна гэхэд Сувдаа өөрийгөө гэж бодов бололтой царайд нь итгэлтодров. Тэгтэл том охин цааш нь- Та дурсамжаа бич. Хажууд чинь аав байна. Мартсаныг чинь сануулах болно. Бидний амьдрал нээрээ л сонин, гоё ш дээ. Хүмүүст сонирхолтой. Харин бичээд дуусахад нь бихүнд үзүүлж хэл, найруулга дээр нь засаж янзлуулъя гэхэд Сувдаа- Өө, тэгээд энэ олон мангаруудыг яах юм бэ? г ээд уруулаа унжуулав. Олон мангарууд гэдэг нь гурван хүүгээ хэлж байгаа юм. Бага хүргэн эхнэрээ хараад инээж л суух. Эгч нь- Чи одоо битгий урваганаад бай л даа. Одоо яаж болоод байгаа юм түүгээрээ л болно бизгэлээ. Түүрүүнээс хойш дуугуйхан сууж байсан өвгөн маань- Миний охидууд том ээжүүд болчихоод битгий ингэж муудалцаж бай. Өнгөрч буй өдөрхоног бүхэн биднээс явж байгаа шүү дээ. Хүүхдүүдээ зүгээр л аав ээждээ аваад ир. Эдяахав жаахан шуугилдана л биз. Гараас гарчихсан амьтад яав л гэж гэснээ надад ха ндан- Миний хөгшин ч гэсэн бич. Хүүхдүүдийн хэлж байгаа зөв шүү. Би ч гэсэн мартсан санаснаа сэргээе. Ер нь тэгээд их сайхан санаа байна шүү гэж бид бүгдийн эвийг оллоо. Угаасаа л ингэдэг юм даа, зайлуул. Сувдаагийн маань хошуу цаашилж, том хүргэний маань ч санаа амрах шиг болов. Сонин шүү. Манай Сувдаа, том хүргэн хоёрын зан авиртөстэй. Харин том охин бага хүргэн хоёрын санаа дандаа нийлнэ. Эсрэг тэсрэгийн хуульгэдэг л энэ юм байх даа. Хүүхдүүд маань хэсэг бужигнаад явцгаалаа.- Багачуулаа үлдээхгүй юм уу? гэж намайг хэлэхэд- Маргаашнаас больё гэцгээв. Тэднийг явсны дараа миний сэтгэл гэгэлзэж орхилоо. Байн, байн түүний зураг рууширтэнэ. Хажууд нь хоёр туулай тэвэрсэн охины зураг байна. Жинхэнэ туулай биш л дээ, чихмэл. Өвгөн маань намайг ажиглаад байгаа бололтой. Тэгэхээр нь- Би бичиж чадах болов уу? гэж итгэл муутайхан асуув.- Бүгдийг нь биш юмаа гэхэд хамгийн сэтгэлд хоногшсон хэсгийг нь бичихэд л болно шүүдээ гэлээ. Бодоод үзэхэд бас тийм юм.- Заавал тэр ном нь ч юув. Зүгээр л дурсамж, тэмдэглэл байж болно биз дээ? Түүнээс илүүг би чадахгүй байх гэтэл- Бололгүй дээ. Их том юм бодоод юүхэв гэлээ. Тэр шөнө би бас л хөрвөөж хонолоо. Шөнө дунд арай ч барилгын ажил хийхгүй тул намгүмхэн. Хажууд, өвгөний жигдхэн амьсгаа сонсогдоно. Гадуур хаа н эг машин өнгөрч

байгаа бололтой үе үе өрөөгөөр нэг цагаан гэрэл цацраад алга болно. Орны хажуугийншүүгээн дээрх “Бүжин” гэрэлд учиргүй тодорч ирснээ бүдгэрнэ. “Энэ туулай бид хоёрт ихтүүх бий” гэж бодохтой зэрэг энэ хавиас л дурсамжаа эхлэх юм байна даа гэж санагдаадбаяр ч хүрэх шиг болж “Бүжин” - гээ авч үнслээ. Түүнээс тоос үнэртэж байна. Өвгөн мааньунтаж байсан хэрнээ гараа явуулж миний гарыг атгалаа. Би тэгсгээд нам унтсан юм байж. Дахиад л нөгөө барилгачдын дуу чимээ түжигнэж сэрлээ. Хорвоогийн дахи ад нэг өглөөэхэлж байгаа нь энэ. Яг энэ өглөөнөөс эхэлж би орчноо мартаж эхлэв. За, юун сүртэй юм. Гэнэтхэн зохиолчболчихлоо гэх гэж байгаа юм биш биз дээ гэж хэн нэг нь бодох л байх. Гэхдээ л би өнгөрсөндөө умбасан хэрэг. Нэгэнт би “Бүжин” буюу өөрт ми нь өдий хүртэл хадгалагдажбайгаа туулайн чихмэлээсээ эхэлнэ гэсэн болохоор тэндээсээ л эхлэхээс өөр арга алга. Энэтуулайг надад миний анхны хайрын эзэн, бүтэлгүй дурлалын учиг, энэ дэлхийд мэндлэ ххувьгүй тэр нэгэн хүний эцэг эцсийн удаа уулзахдаа өгсөн юм. Чухам яагаад өгсөнийг би ойлгодоггүй. Гэхдээ яагаад өдий болтол хадгалж, бүр чин сэтгэлээсээ хайрлаж явдагаабол ухаардаг.

\*

\*

\*

Тэр шар хөвгүүн бид хоёр нэг байранд, бүр нэг о рцонд байдаг байлаа. Түүнийг Сүхээ гэнэ. Тэднийх нэг давхарт. Манайх гурван давхарт. Манай байр хотын төвийн, төв зам дагуухягаан байшингуудын нэг л дээ. Энэ хавийг тавин мянгат гэдэг. Цагтаа монголын гайгүйсэхээтэн, одооны хэлээр бол элит гэмээр айлууд амьдрана. Үнэндээ бол хөдөөнөөс анх лирж хотожсон хэсэг нь гэсэн үг юм даа. Манай дээд талд Анхмаа гэдэг охинтой айл байв. Надаас нилээн хэд дүү. Тэр үед намайг эгчээ, эгчээ гээд гүйдэг байснаа сүүлдээ чи, чиболж хувирсан юмдаг. Бодвол найз болж байсан нь тэр байх. Манай доод талын Сүхээгийнх нилээн сүүлд нүүж ирсэн юм. Сүхээ бид хоёр маш сайхан, дэндүү сайхан үерхэж байлаа. Тэр үеийн хүүхдүүд байраараа их нийлнэ. Манай байранд олон л хүүхэд байсан ч шинээр нүүж ирсэн гэдэг утгаараа ганцхан би ч биш бүх хүүхдүүд, тэр дундаа охидууд Сүхээг их сонирхож байсан юм. Тэр орос сургуульд явна. Энэ нь түүний цараймуутай гэдэг үзүүлэлтийг дарж байв. Гэтэл тэр банди гитарыг гайхалтай гоё тоглоно. Бас болоогүй ээ, сагсан бөмбөгт хачин эвсэлтэй. Түүнийхээ хажуугаар нэг их сонин инээнэ. Нэг тийм юу гэмээр юм дээ. Түүнийг инээхээр ганцхан би ч биш манай байрны бүх охидууд хачин болчихдог байж билээ. Магадгүй бидний бяцхан зүрхэнд анхны хайр эсвэл эсрэг хүйстнээ сонирхох анхны мэдрэмж ирж байсан ч байж болох юм. Тэрийг мэдсэн юмшиг Сүхээ сонин инээмсэглэлээ зөвхөн над руу л өгөөд байх шиг. Бид хоёр нэг орцных болохоор тэр үү цуг байх нь элбэг. Тухайн үеийн хүүхдүүд орцондоо, эсвэл орцныхоо өмнө гитар тоглож эсвэл буу халж (худлаа ярьж) ихэнх цагаа өнгөрөөдөгсөн. Эцэг эх г эжяасан ч их ажилтай улс байсан юм. Хар өглөө гараад л харуй бүрийгээр ирэх. Тэдний горой ирэхэд нь гэр цэвэрхэн, аяга хоол бэлэн байвал болдог байлаа. Ер нь ийм байлгаж чадвал ажилтай, сайн охиндоо орно шүү. Тэгээд л бусад цаг биднийх. Удалгүй Сүхээ бид хоёр үерхсэн юмаа. Байрныхан байтугай сургууль даяараа мэддэг боллоо. Манай ангийнхан, чи орос сургуулийн тэрэнтэй үерхэж байгаа юм уу? гээд л. Сүхээ ч гэсэн намайг хэрээрээ л хайрлана. Хорин дөрвийн чихэр, жаран мөнгөний мөхөөлдөс идэхгүй өдөр надад байсангүй. Хааяа кино үзнэ. Тэр үеийн үерхэл харьцангуй энгийн, харьцангуй даруухан

байсан санагддаг юм. Магадгүй, үе үеийн үерхэл тухайнцагтаа тийм байдаг байж болох л юм.

Бидний үерхэл даамжирсаар нэг л өдөр том хүний хэмжээнд очсым даа. Итгэмээргүй. Ягэхэндээ бол юу болоод байгааг ухаараагүй байтал нэг мэдэхэд би нус нулимстайгаа холилчихсон тэдний жижиг өрөөнд байж байсан юм. Гэхдээ надад тийм ч муухай санагдаагүй. Харин юунаас ч юм их айж байлаа. Айсан ичсэнээ ч ялгахгүй тэднийхээсгараад дээшээ, гэр лүүгээ гүйж билээ. Өдөр болохоор л Сүхээ манай хаалгыг тогшино. Бионгойлгож өгөхгүй. Лав л гурав хоног түүнтэй уулзаагүй юмдаг. Гээд яахав дээ нэг л өдөргарч, тэр өдрөөс эхлэн түүнийхээ гараас хөтлөн энэ хорвоо зөвхөн бид хоёрынх юм шигявцгаасансан. Тэр үе яг одоогийнх шиг хавар цаг байлаа. Тэр ч, би ч төгсөх анги. Гэтэл . . . гэтэл нэг л өдөр болохоо байлаа. Би жирэмсэн болчих нь тэр. Айсан гэж юүхэв. Тэр үед ямар одооных шиг тест энэ тэр гэж байсан биш. Биений юм ирэхээ байчихлаа. Гайхсандаа тэнэг юм шиг ээждээ хэлж орхив. Хүүхэд байж дээ. Ээж гэдэг хүн манараадявчих нь тэр.- Арваа ч төгсөөгүй байж заваан, замбараагүй юу юу гэнэ вээ мэдэхгүй. Ээж, аавынзагнахаас айх, тэдний яриад байгаа ирээдүй гээч нь ингээд өнгөрч байгаа юм байх гээд л дотор харанхуйлна. Арга барахдаа Сүхээд хэллээ. Гэтэл өнөө мангар чинь- Ямар гоё вэ? гэдэг байгаа. Надад хэлэх үг олдсонгүй.- Бид хоёр чинь арваа ч төгсөөгүй байна ш дээ гэтэл- Тэр ямар хамаатай юм. Би төгсөөд шууд үйлдвэрт ачигч болж та хоёрыгоо тэжээнэ лгэнэ. Мөн их романтик юм ярьж байнаа. За тэгэх л юм байх гэж бодов. Гэтэл хэд хоногоос нэг л бишээ. Ээж нь загнасан, аав нь зодсон л гэнэ. Нөгөө их оргилсонхайр сэтгэл нь алга болчихлоо. Яг энэ үеэр манай ээж намайг хүүхдээ авхуулахыг ятгажээ. Миний ирээдүйд энэ хүүхэд маш их гай тотгор болох юм байх. Эх хүн гэдэгхүүхдээ яаж загнах, яаж үгэндээ оруулахаа мэддэг юм шиг байгаа юм. Хувь тавилан гэдэг юмыг үнэхээр хэлж болдоггүй юм билээ. Нэг өдөр ээж маань- Өнөө орой манайд хүн ирнэ. Чиний хүүхдийг авхуулах б оллоо гэдэг байгаа. Дотор харанхуйлаад нэг л биш. Ямар ч байсан эцэг нь болох нөгөө хүүдээ хэлмээр санагдаад болдоггүй. Ээжийг арай гэж аргалаад хог асгах гэж буй хүн болон хогийн сав бариадгарлаа. Нэг давхрын хаалгыг тогшив. Харамсалтай нь Сүхээ гэртээ б айдаггүй. Аргагүйнэрхэнд абортонд орлоо. Тэр үед абартыг зөвшөөрдөггүй. Хийвэл нууцаар хийдэг байв. Угнь бол эмч ч тэр, ээж ч тэр маш аюултай юм хийж байна гэсэн үг л дээ. Би тэр хүний царайг одоо болтол санадаггүй юм. Орж ирснээс нь хойш айгаад эгцэлж х араагүй. Сүүлд нь нүүрэндээ маск зүүчихсэн болохоор харах ч аргагүй. Тэгээд ч юун царай харахтай манатай. Эхэндээ шал танихгүй эрэгтэй хүнд хамаг юмаа дэлгээд үзүүлж байгаадаа туйлгүй их ичиж, айж байж билээ. Харин сүүлдээ юун ичих, голоос нэг юм зулгаагаа дшархиран өвдөж өөрийн эрхгүй нулимс урсаад л . . . Ээж маань харин их хатуу чанга, надад бүр хайргүй ч юм шиг санагдсан даа.- Дахиад тэр нэг юмтайгаа заваараад үзээрэй гэж хэлсэн нь чихэнд бүх амьдралын минь туршид, заримдаа бүр одоо ч гэсэн сонсогдсоо р байдаг юм. Хэдийгээр ээж минь намайг, миний ирээдүйг бодсон гэж ярьдаг боловч тухайн үеийн нийгэм, хүн амьтны хэл амнаас лөөрийгөө хаацайлах гэсэндээ ингэсэн байж магадгүй гэж хааяахан боддог. Би үнэхээр хүүхдээрээ байсан болохоор ээжээсээ, ааваасаа айж тэдний өмнө буруу юм хийчихсэн юмшиг л байдаг байлаа. Ээж маань сургууль соёлоор их далайлгасан. Тэр үед сургуулийнхүүхэд жирэмсэн болвол одоогийнхоор хамгийн айхтар бас ичгэвтэр шуугиан болж

сургуулиас хөөгдөх байлаа. Аав ээж нь асуудалд орно. Магадгүй, манай сургууль ч гэсэнхот дүүргийн хэмжээнд асуудалд ордог байсан байж болох юм. За тэгээд би гэж нэг амьтан ямартаа ч гэсэн гэмээ цайтгаж, ээжийн санаа амарснаар энэявдал өнгөрөв. Хаврын шалгалт шүүлэг гэж сургууль руу явахаас өөрөөр гэрээс гарсангүй. Сүхээ намайг асуугаад л байх. Тэгж, тэгж нэг өдөр Сүхээгийн хүсэлтээр гарлаа. Хүлээжбайгаарай гэсэн сандал дээр нь сууж байтал нэг туулайн чихмэл барьчихсан гүйгээд ирлээ. Би дотроо бол их л хүнд бэрхийг туулаад, даваад ирчихсэн хүн. Өнөөхдөө эрхэлмээр чиг, тунирхмаар чиг болоод болдоггүй. Тэгсэн хэрнээ яагаад ч юм Сүхээ намайг тэвэрч аваадүнсэх юм шиг. Магадгүй бүр өнөөх энхрийллээ дахиад хийх юм шиг санагдаад яажтатгалздаг юм билээ гэсэн шүү юм бодон суув. Харин тэгтэл авчирсан туулайгаа өгөөд- Болороо, би чамд нэг юм хэлэх гэсэн юм. Чи бид хоёр их сайхан үерхсэн. Би чамдхайртай байсан. Гэвч бид цуг байж чадахгүй боллоо. Манай аав ээж нар намайг Оросодявуулах гэнэ. Би тэнд дунд сургууль дүүргээд тэндээ үлдэх байх гэв. Түүнийг ийм юмхэлнэ чинээ санаагүйдээ тэр үү дотор харанхуйлаад явчихлаа. Юун яасан намайгэрхлүүлэх. Энэ хүртэлх хугацаанд миний юутай ч юм тэмцсэн тэр сэтгэл, түүнийгээ давангарч ирсэн итгэл, урьдын сайхан үерхлээ үргэлжлүүлнэ гэсэн хүсэл тэр чигээрээ түүнийөлмий дор зүгээр л хөсөр уначих нь тэр. Миний нулимс сул асгарч эхлэв.- Чи тэгээд зүгээр л ингэж хэлээд яваад өгч болно гэж яаж бодоо вэ? Намайг яасан гэжингэж байгаа юм бэ?- Би чамд дургүйдээ бишээ Болороо. Аргагүйдээ л энэ. Тэгээд ч бидэн дунд байсан хамагнандин бүхэн тасарчихлаа. Бид цаашдаа хамт байж чадахгүй нь гээд миний гарыг нэгатгасан болчихоод яваад өгөх нь тэр. Хорвоо гэдэг, амьдрал гэдэг ийм амархан хувирчболдог гэдгийг би тэрхэн үедээ яахан ойлгох билээ. Араас нь юм хэлж ч чадалгүйнулимсаа залгиад л үлдлээ. Нээрээ ч удалгүй Сүхээ харагдахаа байчихсан. Гэсэн ч гэсэнби гарч орох тоолондоо хаа нэгтэй тааралдчих юм шиг санагдаад орц руугаа орохдоо чхалширч, тэдний цонх руу харахгүй юмсан гэж хичээдэг байж. Тэдний эцэг эхтэйтаарчихвий гэхээс эмээнэ. Сүүлдээ манайх энэ байрнаас нүүчихээсэй гэж хүртэл боддогбайж билээ. Тэгсэн хэрнээ харцаараа, сэтгэлээрээ түүнийг бас үе үехэн хайна. Сургууль төгсөх хоёрхон сарын хооронд миний зан авир, царай төрх, нүдний харц ер ньтэр чигээрээ хачин өөрчлөгдсөн байлаа. Би том хүүхэн болсон байв. Сэтгэл санаа чөөрчлөгдсөн. Үе үехэн тэр масктай хүнийг зүүдэлдэг болсон. Зүүдэнд, тэр масктай хүнминий дээр гарчихаад бэлгийн ажил хийх гээд дайраад болох биш. Би ямар ч байсан хэдхэдэн удаа тэгж зүүдэлсэн юм. Сүүлдээ бүр хүсэх аястай. Мэдээж энэ бодлоосоо айна, басзэвүүцнэ. Одоогоор бол сэтгэцийн асуудал үүсэж байна гэсэн үг л дээ. Аав гэдэг хүн дуугай хэрнээ их сонин хүмүүс байдаг шүү дээ. Нэг өдөр намайг тэвэрчбуйдан дээр суугаад ихээ олон юм ярьсан санагдана. Яагаад ч юм надад, м иний сэтгэлдүгүйлэгдээд байсан зүйлсийг зөөлхөн аядуухан хэрнээ эр хонгор дуугаар- Миний охин өглөө болгоны нарыг харж, өдөр бүр чамд шинэ амьдрал, шинэ хайр ирнэгэж итгэж амьдарч яв. Залуу хүний үзэж өнгөрүүлж буй бүхэн “залуу” л байдаг юм даагэж хэлээд духан дээр минь үнсэж, намайг бага байхад яг л ингэж бүүвэйлж унтуулдаг



байсан болов уу гэмээр намайг тэвэрсэн чигтээ их л удаан ганхаж суусан юмдаг. Залуухүнд тохиолдож буй бүхэн бага байдаг гэсэн санаа байсныг би сүүлд ойлгосон юм. Намайгбага байхад халуурахаар тас тэвэрч хэвтгээд хамаг халууныг авчихдаг шигээ аав мааньнамайг тэвэрч удаан суугаад сэтгэлд байсан хамаг л гуниг шаналалыг алга болгочихсон. Сүүлд нь бодоход аав өөртөө авчихсан ч байж магадгүй. Яагаад гэвэл нэг хэсэг ихгуниглаж, уцаарлаж, сүүлдээ архи хүртэл балгасан юмдаг. Би одоо тэр ярианаас “Засч болдоггүй алдааг л алдаа гэдэг юм шүү дээ, охин минь” гэсэн үгийг огт мартдаггүй юм. Харин би аавдаа тэврүүлсэн тэр өдрөөс хойш хачин илт сэргэсэн дээ. Шалгалтуудаа сайнөгч, оноогоороо улаан шугамнаас дээш гарлаа. Химийн хичээлдээ сайн байсан болохоортэрэндээ дулдуйдаад анагаахын их сургуульд шалгалт өгч, орлоо. Сүхээгээ ч тэгэсгээдмартаж эхлэв. Миний анхны хайр тэр байранд өнгөрч, анхны эр хүнтэйгээ тэдний жижигөрөөнд учирч, бас анхны хүүхдээ тэдний жижиг өрөөний харалдаа дээр гурван давхрынбас яг тийм жижиг өрөөнд устгасан юм. Энэ бол миний анхны хайраас үлдсэн дурсамж. Харин тэр хүүгийн үлдээсэн туулай нь одоо энэ “Бүжин” юм шүү дээ. Түүнээс хойшамьдралын минь бүхий л мөчид надтай хамт байж, миний жаргал зовлонг хуваалцаж явааюм. Надад мөн ч олон удаа загнуулсандаа, зайлуул. Анхмаагийн тухай би түрүүн цухасхан дурдсан. Бид хоёрын ойртох шалтгаан бол тэрСүхээ бид хоёрын хооронд тэр нэг хэсэг холбоо барьсан юм. Тэднийх их зарчимч мөрт лөөхалуун дулаан айл байлаа. Нэг өдөр Анхмаа- Би тань шиг найзтай болох юмсан гэхээр нь- Удахгүй дээ. Чи мөдхөн үерхдэг хүнтэй болно гэж хэлсийм. Надад туулай тэврүүлээд одсон тэр өдөр Анхмааг би их л том хүн шиг санан, тэр хүүгийнтухай хамаг л бүхнээ ярьчихаж билээ. Бодвол Сүхээд гомдсон гомдолдоо л тэр байх. Тэгээд хэнд ч хэлэх ёсгүй зүйлээ ярьчихсандаа учиргүй санаа зовсон. Учир нь тэр үед боласар том нууц шүү дээ.- Хэнд ч битгий хэлээрэй, энэ бид хоёрын нууц шүү гэхэд тэр толгой дохисноос цаашг үй. “Одоо ч энэ газар сайгүй ярих байхдаа” гэсэн чинь харин тэр нэг ч үг унагаагүй юм. Магадгүй, энэ ч бидний үерхэлийн итгэлцүүр байсан байж мэднэ. Нилээн сүүлд, намайговоо сэргэчихсэн шалгалт шүүлгээ өгөөд гүйж явахад Анхмаа надад- Чамайг нэг хэсэг харагдахгүй болохоор чинь айх шиг болсон. Ер нь би том болтлоохүүхэдтэй үерхэхгүй гэхээр нь- Үерхэж болно ш дээ. Харин над шиг л алдаж болохгүй. Би бол хөвгүүдийг үзэн яддаг гэжхэллээ.

\*

\*

\*

Бодолдоо ороогдон хэвтсээр өглөө болж нар мандахыг, тэр байтуг ай гадаах барилгачидажлаа хэзээ эхэлснийг ч анзаарсангүй. Өвгөн маань сэргж байгаа бололтой хөрвөөж байна. Би босож цайгаа гал дээр тавиад, гар нүүрээ угаалаа. Гэлээ гээд би нөгөө их хөвөрсөн

бодлоосоо салахгүй л байлаа. Ёстой нөгөө онгод монгод гэдэг нь э нэ юм байхаа даа. Өвгөнмаань хаанаас ч юм дэвтэр үзэг барьж ирээд- Хөгшөөн, үүн дээр бич. Урд шөнө муухан унтах шиг болох юм. Их л юм бодоо байлгүй. Тэмдэглээд явахгүй бол эргээд мартчихна. Харин би сүүнд гараад ирье. Булангийн дэлгүүрт өнөөдөр шинэ задгай сүү ирдэг юм гэх нь миний мэдэхгүй хэр нь цаашдаа мэдэ хёстой зүйлийг хэлж байв. Хөөрхий минь намайг шөнөжингөө хөрвөөж хонолоо гэж байхыг бодоход би бас түүнийг унтуулаагүй бололтой. Өвгөн ч гараад явлаа. Би түүний өгсөн дэвтэр цаасыг авч том ширээн дээр суув. Угаасаа тасгийн эрхлэгч олон жил хийсэннадад үзэг цаас нийлүүлээд суух нь тийм ч төвөгтэй биш. Харин өнгөрсөн амьдралаа хөврүүлэн бодож, бодсоноо тэмдэглэн цааш нь үргэлжлүүлнэ гэдэг тун сонин байлаа. Үнэндээ бол ингээд цааш нь бичихээр бүрэн ший дэж байна гэсэн үг л дээ. “За байз, түрүүн чинь юу бодож байгаад тасарлаа даа” Аа тийм. Үзэн ядах тухай . . .

\* \* \*- Би хөвгүүдийг үзэн яддаг гэж Анхмаад хэлсэн. Гэхдээ би сэтгэлийнхээ гүнд хөвгүүдийг үзэн яддаг уу гэвэл үгүй юм шиг байгаа юм. Би чинь хүүхэд байхын л нуруу туруу өндөр, царай зүсээр ч тийм мууд орохгүй охин байв даа. Оюутны зургаан жил чухам тэгсхийгээд өнгөрсөн. Хоёр ч залуутай холбоотой байлаа. Гэхдээ би тэдэнд хайртай байсангүй. Хайрлах нь байтугай тэднийг ашиглан зовоож, нааш цааш нь гүйлгээд тэднийг ер жаргаасангүй. Урвайж унжийгаад гүйгээд ирэхээр нь арай аядуу зөөлөн болно. Тэгээд, өөртөө нилээн итгэлтэй болоод ирэхийн багцаанд нь зайгаа барина. Би хэзээ ч тэднийг бодож, хайрлаж байгаагүй. Яагаадыг өөрөө ч сайн ойлгохгүй байв. Магадгүй, би тэднээс Сүхээгийн орхиод явсны горьг авч байсан ч байж болох юм. Гэхдээ би тэгж бодож, занаж, шүдээ зууж байгаагүй болохоор магадгүй гэж байгаа юм. Энэ бол зүгээр л одоо бодож буй бодол. Харин надад нэг сонин мэдрэмж бий болоод байгаа нь анзаарагдаж байлаа. Анагаахыно оюутнууд бид эмнэлэгүүдэд хичээл заалгана, дадлага хийнэ. Тэр үед эмнэлэгээр дүүрэн маск зүүсэн эрэгтэй хүн зөрөлдөхийг харахаар эхлээд айдас төрдөг байв. Бодвол нөгөө үрхэндүүлсэнтэй холбоотой байх. Сүүлдээ айдас маань “Маскны цаана ямар хүн байгаа бол” гэсэн сониуч бодлоор солигдов. Хүний маскыг авч хармаар санагдаад байж сууж чадахгүй үе ч таарна. Яагаадыг би ер ойлгоогүй. Магадгүй, ээжтэй ирсэн тэр хүнийг битүүдээ хайгаад байсан ч байж болох юм. Аль эмнэлэгт ажилладаг хүн болохыг ээжээс нэг удаа суусан боловч надад юу боллоо гэж хэлэхэв дээ. Түүний дуу хоолойг эргэж санах гээд ч бүтсэнгүй. Яаж ч санаж гэж. Тэгээд л эрэл мухардсан боловч масктай хүн харахаар биеэр вэгнэж, хамаг л нандин бүхнээр минь оролдоод ч байх шиг, ер нь их сонин болдог болов. Хамгийн хэцүү нь миний эргэн тойронд масктай хүн маш олон байсан даа. Би тэрнэг шөнийг одоо гэнэтхэн санаж байна. Энэ явдал түрүүний ярьдаг хоёр залуугаас жилийн өмнө болсо н юм. Дөнгөж л оюутан болоод дадлага эхэлж байсан үе. Шөнийн ээлжинд гарах болов. Тэр шөнө гарсан эмчнамайг сонирхоод байгаа нь илхэн. Эрчүүд чинь яг ийм үе дээрээ өөрийгөө хянахдаа

жаахан

муу

ш

дээ

\*

.

.

\*

.

\*

Ингэхэд би үүнийг бичиж болж байгаа юм болов уу? гэж гэнэтхэн өөрөөсөө асуун сэхээавлаа. Яг үүнийг мэдсэн юм шиг өвгөн маань сүү барьсаар орж ирлээ. “Наашаа ирж, бичиж

байгааг тонгойж харах вий дээ” гэж санаа зовохдоо түүн рүү сэмхэн хялмалзаад байлаа. Ямарирэнгүүт нь жаахан охин шиг хамаг юмаа хумиад, нуугаад уналтай биш. Тэгэхгүй гэхээр хөгшин улсбие биенийхээ сэтгэлд юм хийчихвэл үхтлээ юугаа ярьж суух билээ. Би чухам ямархуу царайтайболсноо анзаарсангүй. Өвгөн маань- Бичээд бай, бичээд бай өвгөн нь ойрхон гараад ирье гээд нүдээ нэг хөөрхөн ирмээд, нэг их халуундулаахан харлаа. Энэ хүн надад үнэхээр хайртай юм гэдгийг мэдээд мөн ч олон жил болж байна. Би ч азтай л хүн. Гэхдээ яг одоо бол “хурдхан гараасай” гэж бодож байв. Хүн гэж муухай шүү. Өвгөнгэрч хаалганы түгжээ торхийхэд би цааш нь үргэлжлүүлэх гэснээ нэг их сонин санагдчихав. Бодволөөрөөсөө л ичээд байгаа бололтой. Яаж яваад энэ сэдэв рүү орчихов доо. Санаа зовмоор юм. Энэзохиолч нар ер нь яаж болж байдаг юм бол? Магадгүй, тэдэнд өөрсдөд нь хамаагүй байдагболохоор тэр юм болов уу? Харин энэ бол миний амьдрал учраас үр хүүхэд, хань ижил гээд бүгдуншина гэж бодоод санаа зовоод байж болох л юм. Ямартай ч гэсэн нэг хэсэг сууснаа үзэг цаасаацааш нь түлхэж, энэ сонихон хэсгийг зүгээр л дурсаж бодъё гэж санаад гэрээ цэвэрлэж гарлаа. Тэгэвч бодол санаа минь аль тэртээх халуун залуу насандаа очсон байлаа.

\*

\*

\*

Тэр эмч намайг тэр шөнөдөө эзэмдлээ. Яагаад эзэмдүүлсэн гэхээр Сүхээгээс хойш орь тасорхигдсон тэр сэрэл мэдрэмжийг би битүүдээ хүсч байсан юм билээ. Тархи толгой манараад лдоошоогоо халуу шатаад л явчихсан. Би хүний бие физиологи судалж байгаа хүний хувьд өөртөөчухам ямархан үзэгдэл явагдаж байгааг анзааралгүй яахав. Харин сэтгэл санааны хувьд маш сонинмэдрэмжинд байв. Би түүнд- Та маскаа зүүчих тэгэх үү? гэсэн чинь тэр ихэд

гайхан- Би тийм царай муутай байна уу? гэсэн хэдий ч надаас хариу сонсолгүйгээр хурдхан шиг маскаазуув. Яагаад гэвэл тэр хүсэл тачаалдаа дийлдэж юу ч хэлсэн зөвшөөрөхөөр байснаас гадна маскгэдэг чинь эмнэлгийнхний эрүүн доор л байдаг болохоор нэг их төвөг болоогүй байх. Би тэр хүнээс харц салгасангүй. Өрөө харанхуй ч сарны гэрэл түүнийг харахад хангалттай байлаа. Хэсэг аахилжуухилаад намайг яг сайхан болж байтал тэр дуусчих нь тэр. Тэр юу ч юм яриад л, уучлалт гуйгаад л . . . эрчүүд чинь ер нь тиймэрхүү амиа бодсон чанартай ш дээ. Хэсэг хугацааны дараа тэр дахинхүсэж эхлэв. Энэ удаа би өөрийгөө л бодохыг хичээж, дахиад маскыг нь зүүлгэж байгаад дээр ньгараад авлаа. Миний сэтгэлд би түүнтэй биш, миний хүүхдийг устгасан тэр масктай хүнтэй л байгааюм шиг төсөөлөгдөөд байх нь тэр. Гэхдээ би түүнтэй бэлгийн ажил хийгээд байгаа юм уу эсвэл тэрминий доотохыг ухаад хамаг юм гаргаж шидээд байгаа юм уу бүү мэд. Би ялгасангүй. Нэг мэдсэнчинь би эмчийн дээр маш хүчтэй, эрчтэй хөдөлж байснаа л санаж байна. Энэ бүх хугацаанд тэрмасктай нүүрнээс харцаа бас л салгаагүй. Бүх зүйл дууслаа.

- Чи ч галзуу охин юмаа гэж баярласан гэхээсээ илүү гайхсан өнгөөр хэлж байлаа. Надад тэгжсанагдсангүй. Байх л ёстой мэт.- Яагаад надад маск зүүлгэж байгаа юм бэ? Би тийм царай муутай юм уу гэж түрүүнийхээ асуултыгасууж байна. Би бас л хариулаагүй. Ер нь ганцхан тэр эмч ч биш түүнээс хойш н адтай учирсан бүхэрчүүл ингэж асуудаг байлаа. Би хөндий хоосон өнгөөр “үгүй” л гэнэ. Зарим нэг шалчигнасаннэгэнд нь бол “тийм” л гэчихнэ. Надад тэдний гомдох баярлах хийгээд сэтгэл зүрх нь огт хамаагүйбайсан юм.Би сургуулиа төгсөөд эмч болсон. Ингэж т эгсээр нэг мэдэхэд нас ч гуч гарчихав. Олон ч оюутанбанди нар надтай жижүүрт хонодог байсан. Мөн ч олон удаа жижүүрт гарсандаа. Мэдээж бүгдтэйн биш гэхэд надтай унтдаг хөвгүүд байдаг л байлаа. Тэдэнд бүгдэд нь маск зүүлгэдэг байсан юм.Би чухам хэдэн хүнтэй унтсанаа мэдэхгүй. Гэлээ гээд намайг учир замбараагүй амьтан гэжбодохгүй байх. Учир нь хүний амьдрал гэдэг ихээ урт. Дамаа бүр ганц бие бүсгүй хүний амьдралтүүнээс ч урт байдаг юм.

\*

\*

\*

Энэ мэтийг бодсоор гэрээ цэвэрлэхэд өнөөдөр яагаад ч хийж амжихгүй дээ гэсэн ажлаа бүгдийг ньамжуулчихав. Өвгөн ч ороод ирлээ. Гадаа өвгөчүүлтэй шатар тоглож гэнэ. Бас хожиж гэнэ. Тэрийгээихэд хөөр бахдал болгон ярих аж. “Тэтгэврийн хүмүүс ээ гэж иймэрхүү янзтай л өдөр хоногийг өнгөрөөдөг улс байдаг бололтой” гэжөвгөнийгөө ярих зуур бодож байлаа. Удахгүй би ч гэсэн сэтгэл зүйгээрээ эдэнтэй адилхан болно.Харин өнөө маргаашдаа арай л үгүй болов уу. Хүүхдүүд маань ирнэ гэсэн алга. Ажил нь болсонгүйюм байхаа даа. Оройдоо тэгэс, ингэсгээд зурагт харж өнгөрөөлөө. Хэвтэхийн алдад өвгөн маань- За өнөөдөр хэр их юм бичив дээ? гэнэ- Нэг их шальсангүй ээ- Ганц суугаад л биччих тийм амар юм гэж хаа байхав дээ. Жаал бодохгүй юү дээ. Зураг, хөрөг гээддурсамж сэдрээх юу байна, түүнийгээ үз гэж байна. Тэр зөв л юм хэлж байлаа.Маргаашнаас нь эхлэн овоо суулаа. Хананд Сувдаагийн зураг инээмсэглэнэ. Өчигдөрхөн арчсанболохоор өнгөлөг харагдана.

\*

\*

\*

Энэ манай охин Сувдаа биш шүү дээ. Миний найз Сувдаа юмаа. Хүүхэд байхад эднийх манай доор,нэг давхарт байдаг байлаа. Тэнд чинь нөгөө бандийх байгаагүй билүү? гэж гайхаж магадгүй.Тэднийхийг нүүж ирэхээс өмнө энэ Сувдаагийнх байсан юм. Айлын ганц охин. Надаас ганц хоёрдүү. Гэхдээ бид бараг ухаан орсон цагаасаа л хамт тоглож өссөн найзууд. Тэдний аав ээж Хөдөө ажахуйн яаманд ч билүү ажилладаг. Ямар ч байсан байнга л хөдөө явсан гэдэгсэн. Охидууд л болсонхойно орцныхоо өмнө элдвийн зураг зурж, чарта хэмээх үсэрдэг тоглоом тоглоно. Сувдаа их адтай.Хэзээний л биднийг бүгдийг нь хожно.Намайг найм төгссөн зун манайх зуслан нүүлээ. Ер нь жил болгон ингэдэг л дээ. Эргээд намарирсэн чинь Сувдаагийнх байхгүй болчихсон байсан. Аймаар. Аав ээжийн яриагаар бол Сувдаагийн аав ээж нь хөдөө явж байгаад осолд орж нас барцгаасан байв. Харин Сувдааг асран хамгаалах хүн

байхгүй тул асрамжийн газар аваад явсан байлаа. Би Сувдаагаа хичнээн их өрөвдсөн гээч. Гэвч түүндээр очиж чадахгүй нэг хэсэг удсан. Яагаад гэвэл асрах газар гэхээр л нэг сонин бие зарайгаад, хөндий хүйтэн, айдас төрмөөр төсөөлөгдөнө. Тэгж, тэгж нэг удаа хүнээс асууж байгаад очлоо. Хөөрхий Сувдаа маань намайг хараад л уйлж гарав. Ээж аавыгаа алдсан амьтан тэгэлгүй яахав. Түүний ярьснаар бол гэр орноо, аав ээжийгээ, байраа, сургуулиа, намайг хүртэл санадаг гэнэ. Байрных нь охидууд дээрэлхдэг гээд ер нь хэцүү байдгаа ярив. Би гэрийнхэндээ хэлж түүнийг авчрах юмсан гэж мөрөөдсөн боловч хэлж чадаагүй юм. Тэгээд сарын дараа ч билүү дахиж очиход Сувдаа тэндээ дасчихсан, уйлж унжихаа больсон байлаа. Миний их өрөвдөл ч түүнд хэрэггүй байв. Харин намайг түүн дээр гурав дахь удаагаа очиход тэр бүр тэс өмнөө охин болжээ. Байж байгаа байдал, хэл яриа, тэр ч бүү хэл харж байгаа харц нь хүртэл өөрчлөгдсөн санагдана. Өдөр хоног өнгөрөх тусам Сувдаа миний сэтгэлээс холдож байлаа. Барагтай бол түүнийг санахгүй. Хаа нэг бодогдсон ч тэгэсгээд мартагдана. Тэгээд ч тэдний оронд нүүж ирсэн өнөө шар хүүтэй хайрын романс зохиогоод завгүй ч болсон байж мэднэ. Хүүхдийн сэтгэл гэдэг хөнгөндөө. Тэр үеэс хойш Сувдаатай уулзаагүй юм. Харин Анхмаа бид хоёр их ойртсоныг урд хэлсэн билээ. Тийм л юм бол яагаад Анхмаагийн бишгүүний зураг манайд байгааг гайхаж магадгүй л юм. Энэ зураг чинь түүний гуч гарсан үеийнх нь зураг л даа. Анхмаа маань сургуулиа төгсөөд гадаад хэлний сургуульд орсон байлаа. Намайг эмч болсон хойно над дээр хааяа ирнэ. Хүүхэд байсан тухайгаа жаал хуучлана. Овоо холбоотой байснаа нэг хэсэг алга болчихов. Тэгтэл харин хүнтэй суугаад хоёр ч хүүхэд ойрхон гаргасан гэж нэг удаа ирэхдээ ярьлаа. - Үгүй чи тэгээд яагаад надад хэлж ярьдаггүй ямар сонин хүн бэ? гэхэд хэсэг түгдэрснээ - Сюрприз барих гэж булзааруулав. Анхмаа маань ярьж байнаа. Оюутан байхдаа нэг залуудурласан боловч тэр нь бүтэлтэй болоогүй юм байх. Тэр үедээ ми ний анхны хайрыг санаж, тийм жаахан охин яаж зовж, шаналж байсан бол гэж хүртэл бодсон гэнэ. Харин сүүлд өөрөөсөө нилээн ахимаг насны хүнтэй сууж, хоёр хүүтэй болж гэнэ. - Сайхан л амьдарч байгаа юм байна ш дээ гэвэл - Сайхаан, сайхан гээд дуу нь цаашлах янзтай. Бодвол бас л нэг асуудал байдаг бололтой. За тэгээд аль хүний амьдралын нарийн ширийнийг тэр гэхэв дээ. Ажиглаад байхад нөхөртэй хүүхнүүд заавал нэг сэтгэл дундуур явдаг хойно. Нэг үеэ бодвол бид чинь гуч гарчихлаа. Өөрсдийн л шийдэх асуудал гээд л надаас юм асуучихсан юм аятай зайлуулж бодлоо. Харин Анхмааг гарсны дараа надад анх удаа "Ингэхэд надад ингээд ярих хань ижил байгаа билүү" гэж гэнэтхэн бодогдсон юм. Би өдий хүртэл хүүхэд олохгүй байв. "Хань ижлээ байг гэхэд ганц хүүхэдтэй болох юмсан" гэж анх удаа бодсондоо. Тэрнээс хойш бараг өдөр бүр шахуу бодсон гэвэл болно. Юун төлөө эмч хүн билээ элдвийн шинжилгээ өгч, эмчилгээ хүртэл хийлгэлээ. Тэр үед би өөрөөсөө нилээн хэд дүүмэд нэг залуутай болздог байлаа. Болзох ч юу байхав дээ. Тэр оюутан. Түүнийг би "Хөөрхөн хүү" хэмээн өхөөрдөнө. Хааяа ч бас эгдүү хүрмээр. Юмаа нууна гэж байхгүй. Надад мөнгө хэрэг болоод байна л гэнэ. Мөнгө төгрөгний хэрэгцээ хааяа гардаг байсан юм шиг байгаа юм. Утас дуугарч "Нүүрхун хүү" гэсэн нэргарах юм бол тэр ирэхийг хүсэж байнаа л гэсэн үг. Би ч ирэх тоолонд нь хэдэн төгрөг өгнө. Хөндлөнгийн хүн харах юм бол би нэг биеэ үнэлэгч залууг аваад байгаа юм шиг л харагдана. Мөн л нөгөө маскаа зүүлгэчихнэ. Түүнээс хүүхэдтэй болъё гэж бодоод аргаа барахдаа масканд учир байна гэж санан авахыг нь ч зөвшөөрсөн. Яаж ч хичээгээд олсонгүй. Анхны хүүхдээ авхуулсан тэр

аборт л нөлөөлсөн байж таарав. Ийм үед ээждээ л их гомддог юм билээ дээ. Өөрсдийнхөө нэрнүүрийг авч гарах гэсэндээ миний хүүхдийг устгасан гэж бодогдоно. Гэтэл ганц охин нь бүхнасаараа хүүхэдгүй болох бараан тавиланд уначихдаг гэж бодоод ээждээ насан эцэс болтол ньгомдсондоо. Нэг удаа ажлаа тараад алхаж явлаа. Хүмүүс хос хосоороо, зарим нь хүүхдээ хөтөлчихсөнийнээмсэглэн зөрнө. Гадаа тэнгэр цэлмэг, салхи шороогүй тог туун байсан хэрнээ сэтгэл учиргүйгэгэлзээд, хачин гуниг төрчихөв. Хуучин байрныхаа тэрүүгээр очлоо. Хүүхэд ахуйн тоглож байсангазраараа явлаа. Хотын төвийн байр юм болохоороо нэг давхар нь тэр чигээрээ өргөтгөл хийгээд янз бүрийн үйлчилгээний газар болсон байв. Сүхээгийн байрыг хүртэл урагш нь сунгаад “Ганцсүвд” гэдэг кафе болсон байлаа. Надад яагаад ч юм сонин санагдаад орлоо. Их цэвэрхэн аятайхангазар юм. Үйлчлэгч нар нь хүртэл учиргүй нахилзаад хоол захиалахгүй байхын арга алга. Хоол идэхгэхээр ганцаардаад тэгээд бас зүгээр байж болохгүй аяга ногоон цай аваад сууж байтал цаадөрөөнөөс хэн гарч ирсэн гээч.

\*

\*

\*

Хаалганы хонх дуугарах шиг болов. Дахиад дуугарах болов уу гэсэн таг. Үгүй, тэгээд цааш нь бичихгэсэн чинь хамаг анхаарал хаалга руу сортолзоод болдоггүй. Арга ядаад очиж онгойлголоо. Хэн чбайдаггүй. Бүтэн цээжээ гаргаж, гадаах хонгил руу харсан боловч хүн алга. Заримдаа хий юмсонсох, хааяадаа ямар нэгэн үйл явдал яг давтагдаж байгаа юм шиг санагдах энэ тэр бол хүндбайдаг л даа. Гэхдээ энэ нэг л сонин. Эргэлзсэндээ эргэн, эргэн харсаар ширээндээ ирж суулаа . . .

\*

\*

\*

Эгээтэй л хашгирсангүй. түүнийг дагуулаад л хараад байлаа.- Миний дүү хүн багатай үед үүгээр түүгээрх юмаа байнга тэгшилж, янзалж бай. Хүн орж ирэхэдсэтгэлд дулаахан байдаг юм гэж хэлчихээд намайг хараад зогсчихлоо. Би түүнийг түрүүлж харсанболохоороо инээмсэглэв. Тэр бүсгүй бол Сувдаа байсан юм. Жаахан байрагшсан л болохоос

ерөнхий төрөх нь яг л хэвээрээ.

- Хүүе ээ! Ямар сонин хүн бэ? гэж хашгираад тэр намайг тэвэрлээ. Надад ч сайхансанагдав. Бүр худалч хүнд сормуус ч норох шиг.- За тэгээд, сонин сайхан юу байна даа? Завтай бол хоёулаа хэсэ г ярьж сууя л даа гэжбайна. Мэдээж би зөвшөөрөлгүй яахав. Бидний яриа хэдэн цаг үргэлжилснийг одоо барагсанах юм алга. Их л удсан санагдана. Би түүнийг их удаан харж суув. Миний мэдэхийнасрах газрын жаахан танхайвгар охин биш болсон байлаа. Сувдаа маань ер нь элдвийг л үзсэн юм байх. Асрах газраасаа гараад сургууль соёл чгэсэнгүй. Сурлага нь ч хүрээгүй гэнэ. Тэгээд нэг найзыгаа даган наашаа цаашаа явдагнаймаанд явж гэнэ. Угаасаа өөрийн гэсэн мөнгөгүй учир өдөр хоногоо л аргацаасан юмболж. Тэгтэл нэг боломж гараад Солонгос явсан байна. Тэр үеэр манайхан бараг

явдаггүй. Монгол хүн тэнд их нэр хүндтэй байсан гэнэ. Солонгосын виз ердөө л хорин ногоон лбайлаа шүү дээ гэнэ. Тэгэхээр эрт явсан бололтой. Миний анагаах төгсөж байсан үетэй давхцаж байв. Тэнд о чоод хоолны газар ажилд орж, солонгос хоолыг харин чамгүй сайн



хийж сурсан гэнэ. Тэгээд хэдэн жилийн өмнө ирээд энэ байрыг түрээслэн ажиллуулжбайгаа гэнэ.- Энд чинь танайх байсан ш дээ гэхэд- Харин тэгээд л энд ирэхгүй юу. Би угаасаа тэндээс ирэнгүүтээ ийм кафе нээнэ гээд лбайр хайж эхэлсэн. Тэгээд л хотын төвд гээд хуучин байраа бараадсан хэрэг. Ашгүй тэгтэлүүнийг худалдаж авсан хүн нь түрээсэлсэн юм. Сүүлдээ нөгөө эзэнтэйгээ ярилцаад, удаанхугацааны зээл авч энэ байраа худалдаж авахаар цаг наргүй з үтгэж байгаа гэв. Яриаг ньсонсож суухдаа түүнээс эрч хүч гэрэлтэж байгааг мэдэрч байлаа. Байсгээд л намайг яриач,яриач гэх. Надад ярих олигтой юм олддоггүй. Анагаах төгссөн, эмч болсон. Энэбайрнаасаа эрт нүүсэн гэхээс өөр юм байдаггүй. Магадгүй би түүни й хажууд эрчимбагатай амьдарсан бололтой. Дөнгөж уулзсан болохоор учиргүй сэтгэл доторхоо уудлаад,үр хүүхэд байдаггүй гээд яриад байж чадсангүй. Нөгөө масктай хүмүүсээ хэлэлтэй биш.Тэндээс гараад явж байхдаа түүнд атаархах шиг болов. Яг юунд атаархсана а сайнойлгосонгүй. Түүний гадаад төрхөнд гэхээр тэр эмэгтэй хүнийхээ хувьд надаас илүү гарахюм байсангүй. Намхан нуруу, махлагдуу бие, хэд нугаларсан харвин үс гээг нь гэжөөрийнх гэхээсээ хүний л гэмээр хайш яайшхан хамаад боочихсон. Гэхдээ л түүнээс г эрэлгэгээ эрч хүч цацарч байсанд л атаархаад байсан байх. Гэтэл би түүний хажууд сайханбүсгүй. Сүүлийн үед үр хүүхэд, хань ижлийн талаар хэт их бодож өөрийгөө дарамталсанбайж болох юм.“Нээрээ, дарамталсан гэснээс Сувдаа ингэхэд хань ижилтэй болсон болов уу? Би энэталаар асуугаагүй юм байна. Уг нь хүүхнүүдийн хамгийн түрүүнд асууж, хамгийн түрүүндл ярих сэдэв байдаг биз дээ? Хэрвээ тэр надаас энэ талаар асуусан бол би ярихаасцааргалах байсан. Тэгэхээр бид хоёр ойролцоо шалтгаантай юм болов уу? Магадг үй л юм” гэж бодсоор гэртээ ирлээ.Манай гэр яахав дээ, хэн ч үгүй хов хоосон, хав харанхуй. “Бүжин” маань намайг хүлээжцөхсөн мэт буйдан дээр хэвтэнэ. Анхандаа тэр уйт өдрийг санагдуулаад байдаг байсан“Бүжин” одоо миний л нэг ижил болж, олон ч жилийг н адтай хамт өнгөрөөжээ. Одоотүүнийг анхных шигээ ямар нэг буруутан мэт бодохоо больчихож. Гэхдээ хүн гэдэг адайрааштай. Юм л бол хажуудахтайгаа муудаж байдаг юм хойно хааяа “Бүжин” - тэйгээмуудчихна. Тэр надад юм хэлэхгүй ч би түүний өмнөөс надад юу хэлэхи йг нь бодоодолчихно. Тэр орой бас тиймэрхүү л өдрийн нэг таарсан юм.- Бүжин минь, чи надад ямар хэцүү байгааг төсөөлөхгүй дээ. Эмэгтэй хүнд тохиолдожболох хамгийн хэцүү үе энэ л байх. Юу гээч? Хүүхэд хүсэх. Төрөх юмсан гэж бодох ямарзовлонтойг чи мэдэх үү? гэлээ. Бүжин юугаа хариулахав дээ. Байдгаараа л бүлтийнхэвтэнэ.- Тиймээ, тийм. Чи хариулахгүй. Муу санаатай өөдгүй муу туулай. Нүдээ ч цавчихгүйхарж байгаа нь гөлийгөөд, чиний бах чинь ханаж байна уу?- . . .- Чи миний хүүхэд гаргахгүй хувь заяаны төлөөсөнд ирсэн биз дээ? Би хэзээ ч хүүхэдгаргахгүй. Хэзээ ч миний хөхөнд сүү орохгүй. Яагаад гэвэл чи хөхөж мэдэхгүй юм чинь.Чамайг л тэвэрч насаа барна. Ямар өрөвдмөөр юм бэ гэж би галзуу хүн шиг ганцааринээлээ. Тэр дуугай л намайг ширтэнэ. Би баахан бачуурч байснаа хувцасаа ч тайлалгүйбүхлээрээ хэвтлээ. “Бүжин” - г нэг авах гэснээ уур хүрээд буруу харав.

\*

\*

\*

Хаалга балбах чимээнээр өвгөн очиж тайлгал том охин хоёр охинтойгоо, нөхөртэйгээ оржирлээ. Би суугаад байж чадсангүй. Хүүхдүүдээ үнслээ. Бас ч гэж тэднийгээ ирэхээр сэтгэлүясаж орхидог юм. Том охин маань шууд л хормогч өмсөж- Аав ээж хоёртоо сайхан хоол хийж өгье. Ямар хоол идмээр байна?- Ямар ч яахав дээ. Миний охины ямар ч хоол амттай юм чинь- За тэгвэл сайхан банштай цай хийе- Тэгээ тэг.Тэр орой банштай цай ууж жаал хөөрөлдөж байгаад тэд ч явлаа. Бид хоёр ч хэвтлээ. Бидэрээ янзлах зуураа- Хөөрхий дөө охидууд маань овоо л болж байна гэхэд- Харин ээ хэлээд юүхэв. Миний охин нас ахих тусмаа эжийтэйгээ ижилхэн болж байгаагэж . . . Би ч охиноо харах тусам л хайр хүрэх болж гээд өвгөн маань миний гарыг нэг сайнатгачихаад цаашаа харан хэвтлээ. Хөөрхий дөө, надтай ханилсан цагаасаа хойш ингэсээродоо бараг зуршил бо лчихож дээ. Ингэж атгахгүй л бол унтаж чадахгүй болох шахтлаадасчихаж.Намайг барилгачдын нижигнээн биш шувуудын жиргээн сэрээлээ. Өвгөн аль эрт босоодявчихаж. Би ихээ бөх унтсан бололтой. Шууд босчих гэснээ эргээд жаахан хэвтмээр ч юмшиг. Яг залуугийнх шиг ээ.

\*

\*

\*

Тэр өглөө ч гэсэн би нам унтчихсан байсан. Бүхлээрээ хэвтсэн хэрнээ шүү дээ. Сайннойртой хоносон болоод тэр үү урд оройгоо бодвол сэтгэл ч гэсэн сэргэсэн байв.Өндийгөөд харсан чинь “Бүжин” маань газар хэвтэнэ. Өрөвдөх ч шиг болов. Надад хэн чбайхгүй шиг түүнд ч гэсэн надаас өөр хэн ч байхгүй ш дээ. Бүжингээ авч хошуун дээр ньхэд үнсчихээд угаалгын өрөө рүү явлаа.Дараагийн удаа би Сувдаагийн кафед Анхмааг дагуулж очсон юм. Бид бас л нэг байрандбайснаа ярьцгаав. Улаан эрээн даашинзтай, үсээ толгой дээрээ боочихдог жаахан охинбайсан гээд Анхмааг таньж байнаа.- Хүүе! Болороо, энд бас нөгөө Сүхээгийнх байсан биз дээ? гэж Анхмааг хэлэхэд- Тиймээ, тэднийх бас байсан гээд би санаа алдлаа.- Танай дараа нүүж ирсэн айл. Манай Болороогийн . . . гээд үгээ тасалж байна. Тэгэхээр ньби- Миний анхны бөгөөд эцсийн хайр гээд муухан мушийлаа. Тэгтэл Сувдаа- Юун эцсийнх гэж. Хүүхэд насны үерхэл чинь гоё, дурсгалтай ш дээ. Надад л лав тэр үедхүүхдүүд хоорондоо үерхэж байгааг харахад нэг л гоё санагдаад байдаг байсан.- Надад ч гэсэн. Би бүр энэ хоёрыг хараад хэн нэгэнтэй үерхэх юмсан гэж боддог байжбилээ. Тэднийг ийн ярихад би улам л дуугай болж байлаа. Надад тийм сайхан дурсамжбайхгүй юм байна гэж бодогдож байв.Тэр өдөр бид гэр бүл, үр хүүхдийн талаар ярьж таарлаа. Анхмаагийн тухай мэдэж байсанболохоор Сувдаад л сонин байсан байж магадгүй.Харин Сувдаа маань энэ тал дээр нилээн зовлон үзсэн байлаа. Солонгосоос мань хүн ёстойамьдралыг цэцэглүүлэх хүсэл эрмэлзэлтэй ирсэн байж. Тэгээд нэг залуутай танилцжээ.Анхандаа ч хачин сайхан байсан байлгүй яахав. Гэтэл өнөөх нь адгийн чөтгөр байсан ньөдөр өдрөөр мэдрэгдэж эхэлжээ. Яаж нэг юм түүнтэй суучихаагүй юм. Үе үе согтуу ирэхболсон тэр байнга л Сувдаагаас мөнгө нэхдэг болж. Өгөхгүй бол кафед нь ирээд

суучихдаг. Нэг өдрийн маргаанаас болж түүнийг зоджээ. Маргааш нь эрүүлдээ уучлалтгүйж, амлалт өгч. Гэтэл байдаггүй, хэд хоногоос дахиад л согтуу ирж “Чи надад хүүхэд төрүүлж өгсөнгүй муу сувай эм. Одоо чи төмөр замын солгой Аюуш гэжхэн болохыг үзнээ гайгүй” гээд л зодсон гэнэ. За тэгээд л ирдэгээрээ ирж, явдгаараа явсаарнэг өдөр Сувдаа жирэмсэн болжээ. Одоо л нэг гайгүй болох болов уу гэж санаад хоёрсарын дараа түүнд хэлжээ. Гэтэл нөгөө Аюуш нь хүүхдээ авхуулчих гээд салдаггүй гэнэ. Харин энэ удаа Сувдаа зөвшөөрсөнгүй. Тэгээд ч Сувдаагийн нас гуч хүрч байсан болохоор гаргая гэдгээрээ зүтгээд эсэргүүцжээ. Үүнээсээ болж бүр хэвтэрт ортлоозодуулсан байгаа юм. Харин аз болж үр нь зулбас ангүй тухай ярьлаа.- Үгүй тэгээд яваад өгдөг нь овоо доо гэхэд- Юун явах. Нэг хэсэгтээ л намайг зовоосон. Манай энэ хэдийг ч зовоосон гэж ажилчдаахэлээд. Цагдаа сэргийлэх болж байж арайхийж хөндийрсөн ш дээ. Эрс эсэргүүцээд, байнгацагдаа дуудаад байхаар нэг юм салдаг юм билээ. Тэгээгүй нэг л нүүр өгвөл тэгээд лөнгөрөө. Түүнээс хойш эр хүн гэхээр бараг худалч хүнд хамаг бие зарайдаг болсон. Дамаабүр согтуу хүн харахаар уу, ёстой алергийтэж өгнө шүү дээ гээд Сувдаа сэтгэл ханасан хүн шиг инээлээ. Сувдаа а охинтой болсон байлаа. Охиноо 24 - ийн цэцэрлэгт өгчихдөг. Баасан гаригийн орой аваад нэг дэхийн өглөө өгдөг гэнэ.- Одоо ч овоо болсоон миний охин гэж Сувдаа нүүр дүүрэн инээж байв. Санасандаа хүрчяваа хүн аргагүй дээ. Сувдаад бас нэг сонин гэмээр зурш ил байсан нь дуу хураагчид тааралдсан сонин болгонообичдэг байв. Анх надтай таарснаа, кафегаа яаж нээснээ, нөгөө Аюушд зодуулж үйлээүзсэнээ, яаж охиноо төрүүлсэнээ гээд бичээгүй юм тэнд алга. Яагаад ингэдэг гэхээр анх Солонгост хоол хийх аргаа өөрөө өөртөө бичиж авч байсан юм билээ. Учир нь хэлмэдэхгүй учир гарын авлага гэж юм байхгүй. Зүгээр л өөрийнхөө харсныг, сахар тэдэн гр, мах тэдэн кг, тэдэн градуст тэдэн минут чанана гэх мэтээр бичдэг байж. Тэгсээр байгаадүзсэн харснаа, сүүлд нь бүр өөрийнхөө бодсон дүгнэсэнээ хүртэл бичсээр байгаад зуршилболсон байгаа юм. Хэзээний л өнөөх дуу хураагчаа халаасалчихсан явах. Гаргаж ирээд лөнөөдөр тэдэн оны тэдэн сарын тэдэн гээд л урсгаж өгнө. Тэр оройноос хойш бид гурав долоо хоногт нэг орой уулзаж байхаар боллоо. Анхмаа хагасбүтэнд завгүй гэсэн тул бид даваа гариг болгонд уулздаг болсон юм. Ажилтай болохоорнадад л их сонин өдөр санагдаад байснаас тэдэнд бол болж байлаа. Ингээд нэг байрны, нэг орцны гурван охин хэзээ хойно мөн тэр байрандаа, тэр орцныхоо нэг да вхрын кафедуулздаг боллоо. Тэр нь манай Сувдаагийн гэр нь байсан байр. Бас миний анхны үерхэжбайсан хөвгүүний гэр. Бас охин насаа өгсөн унтлагын өрөө маань одоо кафены нэгээхэнбулан болчихож. Сонин л түүх юм даа. Долоо хоног гэдэг хүүхнүүдэд хов жив, сонин хачин цуглуулахад хангалттай хугацаа. Сүүлдээ Сувдаагийн кафены ажилчид биднийг андахаа байв. Бүр ямар хоол захидагхийгээд юу уудгийг ч мэддэг болсон. Орж ирээд л сууна. Захиагүй байхад л бидний уужидэхийг авчраад тавьчихна. Тэгээд л ярьж гарна. Сув даа- За та хоёр яриад байж дээ. Би ямар эндээс гарах биш л гэнэ. Энэ бол бидний уулзаад лхэлдэг анхны үг, анхны асуулт. Сувдаагийн суудал яг цонх руу харж, Анхмаа бид хоёрынхөөд өөдөөсөө харж таардаг байв. Тэгсээр энэ бидний тогтмол суудал болж хувирсан юм. Хааяа бидний хэн нэг маань ирэхгүй бол тэр суудал хоосон л байдаг байлаа. Би л лав нэгдэх өдрийг их хүлээдэг байж. Тэр хоёр яадаг байсныг мэдэхгүй юм. Бид хоёроос гадна бас нэг байнгын үйлчлүүлэгч байдаг нь тэдний хөрш юм. Кафены хажуу талын хаалганд нэг нотариатч сууна. Тэр бас үе үе орж ирнэ.

\*

\*

\*

Хонх дуугарахаар нь хаалга онгойлговол өвгөн маань Сувдаагийн гурван хүүхдийг дагуулсаар орж ирлээ.- Өвгөөн, чи юунд ингэж байдаг юм бэ? Цаад эцэг эх нь хаачаав?

- За яахав ээ, Хүүхдүүд ажилтай байгаа биз. Ингэсгээд ирцгээнэ. Хөгшин минь, нэг хоол хошны юмхийхийг бод гэж байна. Үд дунд гараад явсан хүн чинь бага охиныд очоод гурван хүүхдийг нь аваадирсэн юм байж. Би нөгөө цаас руугаа ухаан алдаад өвгөнийг хэр удсаныг анзаарсангүй. Гэнэтхэнөөрийгөө бодохоор инээд ч хүрэх шиг. Ёстой нөгөө хөгшин азарга жороо сурна гэгчээр цаг нараа чмэдэхээ байх даа яах вэ дээ? Гээд яахав дээ, үнэн л тэр хойно. Мах гаргаж битүү хоол бэлдлээ. Буузчимхэж байх зуураа өвгөн- Эртээр муу охин маань гомдчих шиг болсон юм. Өнөөдөр маажигнаад яваад очсон чинь харинбүр гайгүй шүү гэж охиндоо санаа зовсон гэхээсээ илүү эмээсэн янзтай хэлж байна.- Ишш! Тэрний төлөө тийшээ харайлгаж явдаг чи мөн залуу хүнээ. Одоо энэ хүүхдүүд бидэнтэй бидэнгүй учраа олох цаг болсон доо гэж намайг үглэхэд- Байгаа дээрээ ингэж л байя. Байхгүй хойгуур яах санж дураараа болог. Би ямар ажилтай биш. Гэртбайхаар чамайг ээрээд юмыг чинь хийлгэхгүй юм гэж охиноо өмөөрч намайг аргалж байн а. “Эвийдээ гэж. Ийм хүнтэй би ер нь ямар тавилангаар учрав даа” гэж дотроо шүүрс алдан хайр хүрэхдээхэдэн сөөвгөр цагаан хялгасыг арагш нь илэн гүн үрчлээтсэн ягаан духан дээр нь гурилдажорхилоо. Арилгах санаатай дахиад илээдэхсэн чинь бүр нэмээд цагаа руулчих нь тэр. “За, за яршиг цаашаа. Зурвас халзан өвгөн сууж л байг” гэж бодов. Удалгүй Сувдаа маань нөхрөө дагуулчихсан амьсгаадсаар орж ирлээ.- Ёох! Ядарч үхэх нь. Өнөөдрийн ажил гэж жигтэйхэн гээд л бөөн сүр. “Ажилдаа ядарсандаа биш л дээ. Бид хоёрт л эрхэлж байгаа ёоз нь тэр. Хичнээн том болж, хичнээнхүүхдийн эх болсон ч өнөөх л багын зангаараа шүү. Хэзээ хүн болох юм бүү мэд. За одоо яая гэхэв. Өвгөний хэлдгээр биднийг амьд дээр ингэцгээж л байг дээ зайлуул”. Бага охины гурван банди манайд дэжигнээд би бараг долоо хоног үзэг цаас нийлүүлж чадсангүй. Өчигдөр орой нэг юм бөөнөөрөө явцгаалаа. “За даа тусдаа амьдарч байгаа нь их юм даа” гэж бодогдов. За тэгээд тэмдэглэлээ юун дээр орхилоо доо. Аа тийм . . .

\*

\*

\*

Тэр нэг орой бид кафеда ирдгээрээ ирцгээлээ. Анхмаа бид хоёр суудалдаа сууж ойр зуурын юмьярж суутал Сувдаа удаж, удаж ардаа нэг цаас барьсаар гарч ирээд гэнэтхэн- Ци - ри - рин! Сурприз!! Энийг хардаа охидуудаа, Найз нь өнөөдөр энэ кафеныхаа жинхэнэ эзэн нь боллоо гээд кафеныхаа байрны гэрчилгээг гаргаж ирэв. Бид гурвын баярласан гэдэг учиргүй. Бүрүнэн сэтгэлээсээ баярласан юм шүү. Тэр үнэхээр чадсан байв. Сувдаа өнөөх дуу хураагчаа гарганбичнэ. Тэр гүрийсээр байж, ажилласаар байж зээлээ төлж, үл хөдлөхөөс гэрчилгээгээ авсан байлаа.- Ийм сайхан өдрийг гарч тэмдэглэе гэж намайг хэлэхэд Сувдаа- Найз нь нэг вино, нэг бялуу захисан. Ийш тийш гараад яах юм. Эндээ л сууцгаая гэлээ.



идлээ, виноогоо ч уулаа. Дахиад нэгийг задлав.- Болох ёстой юм болдгоороо болж. Энэ чинь танай гэр шүү дээ гэхэд Сувдаагийн нүдэнд нулимсцийлэгнээд- Аав ээж хоёр маань байсан бол баярлах л байсан даа. Тэгтэл Анхмаа- Манай Сувдаа нээрээ мундаг юмаа. Би бол чадахгүй ээ. Нэг л өдөр за больё, больё гээд л буугаадөгчихсөн байгаа гэхэд Сувдаа- Хүн ер нь амьдралдаа их ч юм үзэх юм даа. Аав ээж хоёр маань ослоор өнгөрөөд би орьганцаараа үлдэв. Одоо яг энэ хэсэг чинь манай том өрөө байсан юм. Би гэж амьтан уйлахаасөөрийг мэдэхгүй. Анхмаа- Тэгэхэд хэдтэй байсан юм бэ?- Арван гуравтай- Овоо л ухаан орчихсон байж дээ.- Ухаан орлоо гээд яахав дээ. Өөр хамаатан садан байгаагүй юү эсвэл гарч ирээгүй юү. Тэгээд нэг лөдөр намайг асрах газар аваачдаг юм байна. Асрах газар тэгж байгаад нэг л зэвүүн ш дээ. Гаднааснь харахад л нэг их буянтай байгууллага юм шиг атлаа дотроо шал амьдралын өөр эрэмбэтэй. Битэрэнд нь дасаж өгөхгүй. За тэр шинэ хуучны ялгаа бол байна шүү дээ. Дээр үеийн цэргүүд шиг лгэсэн үг.Нэг удаа би хичээл дундуур гараад гүйчихвээ. Өөр үед бол гадуур гаргахгүй юм чинь. Тэгээдбайрандаа ирсэн чинь ямар муухай байсан гээч. Гадаа нэг ч хүүхэд байхгүй. Ганц нэг хөгшин суужбайхаар би жигтэйхэн их баярлаад мэндэлсэн чинь нэг л хөдний дуугараад л, энэ хүүхэд энд юухийж яваа юм гэсэн янзтай хараад л . . . Гэрийнхээ хаалгыг ирээд харсан чинь сэтгэлд нэг лдулаахан. Өөрийн эрхгүй хаалгаа тогшсон гэж байгаа. Хаалганы цаана ирж байгаа хөлийн чимээ ягээж минь ирж байгаа юм шиг. Гэтэл шал өөр авгай гарч ирснээ хулгайч харж байгаа юм шиг иргэртэж, ширтэж- Юун хүүхэд хонхоор тоглоод байгаа юм? Хэнтэй уулзах гээв? гээд л нэг их муухай зангарч билээ.Би юм ч хэлж чадсангүй, нүдэнд нулимс цийлэгнээд нүүрээ дараад доошоо суучихсан. Нөгөө авгайчинь- Өвчтэй юм уу хаашаа юм гээд хаалгаа нэг их чимээтэй хаачихсан. Тэр үед амьдралын хаалгаминий өмнө тасхийтэл хаагдчихаж байгаа юм шиг санагдаж билээ. Хуучин үүдэндээ, одоо тэрхаалганы цаана гэсэн үг шүү дээ гээд Сувдаа хаалга руу харцаа шидээд- Уйлж, уйлж аваад байр луугаа буцаж билээ. Тэгэхэд л энэ хорвоо дээр орь ганцаараа болж гэдгээжинхэнээсээ мэдэрч хувь заяандаа итгэсэн шүү. Нэг бодлын шуударсан гэсэн үг юмуу даа.- Намайг дараа нь нэг очиход чи нэг л өөр ч юм шиг болчихсон байсан- Магадгүй ээ Болороо минь. Тэгэхэд хүүхэд ч байж. Тэгээд ч тэр асрамжийн газар чинь нэг үлүзэгдэх, үл ойлгогдох ухагдхуун яваад байдаг юм гэхэд Анхмаа- Яг ямар ухагдхуун? - Юу ч гэмээр юм дээ. Эцэг эхтэй хүүхдүүдэд өширхдөг.- Өширхдөгөө? Ээж аавтай хүүхдүүдэд атаархдаг хэрэг үү?- Хүүхдийн л ухаан шүү дээ. Бас тэр багш нарт их учир бий. Хүүхдийн, тийм балчир ухаанд өдөр бүрта нар бол өнчин, та нарт хэн ч байхгүй, та нар өөрөө өөрсдийгөө л авч явах ёстой гэх мэтээр яриадбайхаар бас нөлөөлдөг ч байж болох юм гэхэд нь би их гайхлаа. Тэгээд- Үгүй ээ, уг нь тэр чинь хүүхдүүдэд хайр энэрлийг үзүүлж, итгүүлж нийгэмшүүлэх ёстой биз дээ?

- Тэр чинь ном шүү дээ Болороо минь. Ном амьдрал хоёр алд дэлэм зөрөөтэйг мэднэ биз дээ?- За тийм ч юм байхаа даа.- Асрахаас буруу зам руу явсан хүүхдүүдийг алийг тэр гэхэв гэхэд Анхмаа- Хөөрхий хүүхдүүд, ямар хэцүү юм бэ? Гэхдээ зөв сайхан амьдарч байгаа нь зөндөө биз дээ? Миний найзаас авхуулаад . . . - Зөв буруугаа мэдэхгүй ч энэ байраа л авах юмсан гэдэг бодол байсан. Зорьсондоо хүрэх сайхан л юм. Үүнд чиний ч тус явж байгаа. Найз нь тэгж байгаад болгоноо гэнэ. Тэдэнд миний мэдэхгүй юмбас байгаа бололтой. Гэтэл Сувдаа- За би яахав. Болороо минь чи нэг нөхөр сүүдэртэй болооч ээ. Үгүй ядаж нэг хүүхэдтэй болохгүйбол оройтлоо шүү гэтэл Анхмаа- Нээрээ одоо хэд хүрчихэж байгаа билээ? гэхэд нь миний санаа зовсон хэдий ч бас ч гэж үнэнийортой үг тул- Нас мас битгий яриа. Бас ч гэж болоогүй байна. Муу найзад нь юу л байна, муусайн эрчүүд л байна гэж амьхандаа хөгжилтэй царайлсан боловч нэг л итгэмж муутай болж байлаа. Амнаас гарчбайгаа үгс бодлоос хамаарч гадагшилж байдаг юм билээ. Зарим хүн бодлоо зөрүүлж ярьж чаддаг байх. Гэхдээ бодлынх нь нэг цучил хэл ярианд нь заавал явж л байгаа. Би тэдэнд олон л залуубайна гэж хэлж байхдаа нэг л хүчгүй байсан юм. Тэгээд булзааруулах сана атай Сувдаа руу- За, чи ч гэсэн нөхөргүй байж гэтэл- Найз нь ч яахав гараасаа хөтлөх ганц охинтой. Тэгээд ч одоо эр хүнтэй нэг гэрт орно гэхээр сэтгэлхүрэхгүй юм. Муусайн эрчүүлийг бодохоор үнэхээр . . . гэж үгээ зуунги хэлснээ сэхээ авах мэт- Уучлаарай Анхмаа энэ танай нөхөрт хамаарахгүй шүү. Зөвхөн надтай таарсан нь шаар байсан юмгээд эртээр надад ярьсныгаа товчхон ярьлаа. Энэ зуур Анхмаагийн нүдний ухархай улайчихсанбайлаа. Сувдаагийн охины эцгийг үзэн ядаж байгаа нь илт. Яриа нэг л гунигтай тийшэ э хандаадбайгааг анзаарч- Би нээрээ, ядаж нэг хүүхэдтэй л болмоор байна гэж чин хүслээ хэллээ. Гэтэл Анхмаа- Хүнтэй суу. Бүр болохгүй бол хэний ч хамаагүй хүүхэд гаргачихгүй юү гэхэд нь би эгээтэй л “Харинтэгээд, би өчнөөн л оролдоод байхад болохгүй б айна. Хүнд, хувь заяа дутна гэж юу байдгийг та нармэдэх үү? Мэдэхгүй байж яах гэж ингэж байдаг юм” гэж хашгирсангүй. Биеэ барьж байлаа. Хэрвээгэртээ ганцаараа байсан бол муу “Бүжин” - гээ хоёр чихнээс зулгааж байгаад хашгирахсанж. Даанчгэрт биш юм даа. Гэтэл Сувдаа . . .

\*

\*

\*

Дахиад л хаалга тогшив. Ерөөсөө миний бичиж буй ажлыг хаалга тогших чимээ л таслах ажээ. Аргагүй дээ өвгөн бид хоёрт өөр ажил байх биш. Нүднийхээ шилийг авч тавиад хаа лга онгойлгоххооронд хурдан, хурдан тогшиж, сүүлдээ балбах маягтай болов. “Хүүхдүүд л яарч сандраад ингэжээрхэг тогшоо юм болов уу даа” гэж бодоод онгойлготол огт танихгүй залуу байв.- Сайн уу? Хүүхээ. Чи чинь айлын хаалга тогшиж байж жаахан аятайхан т огшиж болохгүй нь үү?- Би ажлаа хийж байна, эгчээ гэнэ. “Тэр нь тэгээд ямар хамаатай юм бол доо” гэж бодон зогстол- Энэ танайд өгч байгаа санамж. Та энд гарын үсэг зурчих- Юун санамж вэ? Манайх чинь яасан болоод сануулахдаа тулчихав, хүүхээ?- Танай байрыг мөдхөн нураана.

- Юу гэнээ?- За, за би яараад байна. Наад санамжин дээр чинь бүх зүйлс тодорхой байгаа. Та зүгээр энийгавсан гээд гарын үсгээ зур гэлээ. Үгийн солиогүй шахам загнуулан байж гарын үсгээ зурах гэтэл үзэгцаас нийлэв үү, үгүй юу цаасаа шувт татаад яваад өгөх нь тэр.- Үгүй чи . . . үзгээ . . . гэтэл эргэж ирээд сарвагас гээд авлаа. Тэр залуу ажлаа хийж байсан байж болно. Яарч байсан ч байж болно. Гэхдээ шинэ зууны залуу хүнгэхэд арай бишээ. Санамжийг хартал хотын захиргаанаас гарсан ш ийдвэрээр манай байрыг нураажоронд нь шинэ байр барих тухай, үүнтэй холбогдсон хорооны хуралд ирэхийг урьсан байлаа. Яг л манай хажуугийн байрныханд ирсэн шиг. Өвгөн бид хоёр иймэрхүү юм болно гэдгийг мэдэжбайсан боловч яг ингээд нүүрлээд ирнэ чинээ сан аагүй хэрэг л дээ. Монгол хүний л зан юм байхаадаа. Тэр бичгийг авах мөртөө одоо ингээд л нураачих гэж байгаа юм шиг санагдаад сэтгэл нэг л хэгхийгээд явчихлаа. Хүний сэтгэл гэдэг мөн ч амархан нугарч байгаа юм шүү. Өвгөнийгөө ирэхээр ихл сонин айдаст автсан мэт ярьмаар . . . Гэвч тэр алга л байлаа. Би аяга цай залгилчихаад ширээндээсуулаа.

\*

\*

\*

- Тэрэндээ тулах юм бол ч харин ч нэг сонголт хийх хэрэгтэй шүү. Цаагуур чинь сайн, сайхан генитэйзалуучууд зөндөө л байна даг. Явж, явж нэг хогийн юмны хүүхэд гаргачихвал хар төвөг

гэлээ. Надад их сонин санагдав. Малаар бол хээлтүүлэг маягийн юм яригдаад байхаар тэрбайх л даа. Гэсэн ч би бүр хошигномоор санагдаад

- Би ерөөсөө нэртэй хүмүүсийн үрийн шингэн зардаг бизнес эрхэлдэг юм бил үү? гээдгачигантал инээтэл Анхмаа хэзээний итгэчихсэн- Паах! Тэгээд дэлгүүр аятай юү?- Нээрээ тэгвэл ямар хүмүүсийн үр их зарагдах болоо? гэхэд Сувдаа- Манайхан бөх, бөх гээд л сүйд болдог хойно бөхчүүдийн үр л их зарагдах байлгүй гэвАнхмаа- Тэгвэл энэ гудамжаар дүүрэн тэнтийсэн, тэнтийсэн юмнууд болох байлгүй дээ гэхэд бидгурав жуумганав. Тэгтэл надад манай нэг эмчийн хөгтэй явдал санаанд ороод- Бөх гэснээс манай эмнэлэгийн нэг эмч байдаг байхгүй юү. Бө хөд их сонирхолтой. Ер ньбөхөөр амьсгалдаг гэхэд болно. Би заавал бөхтэй сууна гэж ярина. Түүрүү жил нэг хүнтэйсууваа. Тэгсэн чинь цагдаатай суучихаж. Манай нэг галзуу эмч, чи нөгөө бөх мөх гээдбайсан яасан бэ? гэж авдгийн. Тэгсэн чинь өнөө хүүхэн “Яадги йн, бөхийн өргөөний цагдааюм чинь” гэдэг байгаа. Бид гурав нулимсаа гартал инээлдэв. Сувдаа- Яанаа, хөөрхий бөх, бөх гээд бөхийн өргөө рүү гүйж яваад наана нь бүдрээд уначихсанбайна ш дээ гээд л гэдэн годон гээд инээд алдлаа. Тэгээд л яриад л байлаа, яр иад л байлаа.Нэг мэдсэн чинь вино маань ч дуусаж- Дахиад нэмэх үү? халуураа л даа гэж намайг хэлэхэд Анхмаа- Одоо оройтлоо. Болноо гэнэ. Гэтэл гаднаас бидний үеийн болов уу гэмээр залуу оржирснээ Сувдаа руу дохиж байна. Таньдаг л боллолтой. Сувдаа- Сайн уу? Ямар орой явж байх юм?- Харин тийм ээ. Жаахан юм хийгээд суугаад байсан чинь орой болчихож. Нэг мөсөнхоолоо энд идчихдэг юм бил үү? харин чи их жаргалтай харагдаж байх чинь?



- Өнөөдөр тусгай өдрөө. Танд үнэгүй үйлчлэнэ гээд Сувдаа үйлчлэгч рүүгээ- Миний дүү хэн ахдаа үйлчлээд тооцоог нь над дээр биччих гэж байна. Анхмаа бид хоёрСувдаагаас хэн болохыг асуусан янзтай харахад- Манай хөрш. Нотариатч. Яахав нэг дорын улс миний баярыг хуваалцаг гэхээр нь бидхоёр жоготой нүдээр хартал- Үгүй ээ, үгүй. Ёстой тийм юм байхгүй. Зүгээр л манай байнгын үйлчлүүлэгч байхгүй юу.Хэрвээ өөр харилцаатай хүн байсан бол шууд л манай ширээнд сууна биз дээ? Тэгээд чийм баярт өдөр болж байхад хуваалцаж л таарна. Надад та хоёроос өөр дотно хүнодоохондоо алга гэлээ. “Н ээрээ ч тийм юм даа” гэж бодож суутал цонхны цаанаАнхмаагийн нөхрийн машин ирж зогсов. Сувдаа угаасаа цонх руу харж таардаг тултүүнийг түрүүлж хараад ороод ир гэж даллав. Хариуд нь тэр бугуйн цаг руугаа заажбайна. Бодвол завгүй л гэж байгаа бололтой. Ан хмаа- За найз нь явья даа гээд гарлаа.- Эдний нөхөр чинь Анхмаагаас нилээн ахимаг байхаа гэхэд Сувдаа- Тийм гэсээн. Лав л арав гаран ах байх. Надмид гэдэг юм билээ. Архи тамхи хэргэлдэггүй,авгай хүүхэн гэхгүй, ажил ажил, алт алт гэсэн хүн байдаг гэсэн гэхэд энэ үг надад нэг лхудлаа мэт санагдав. Яагаад тэгснээ би ойлгоогүй л дээ. Гэхдээ л тэгж бодогдсон юм.- Худлаа, худлаа. Энэ бид хоёр авгай хүүхэн гэхгүй байхдаа яадаг юм. Манай Анхмаа гэжитгэмтгий амьтан энийг юу л гэж хэлнэв, тийм үү л гэж сууда г биз гэхэд- Анхмаагийн л үг шүү дээ. Гэр орондоо халуун дулаан, эрх дураараа сайхан л байдаг юмгэсэн. Бүсгүй хүн тэгж л амьдарч байвал болоо ш дээ. Найз нь Анхмаагаас арван саятөгрөг зээлчихсэн. Тэгээд өнөөдөр гэрчилгээгээ авчихсан байхгүй юу. Замаараа басшинжилгээ өгөөд амжчихаж байгаа юмаа гэж байна. Түрүүн чиний тус энэ тэр гээдбайсны учир энэ байж. Үүнээс цааш би тэр Надмидынх нь тухай муу хэлж чадахаа болив.Чадахгүй юу байхав дээ болохгүй болов. Харин- Юун шинжилгээ вэ? гэж асуулаа. Бодвол мини й мэргэжлийн өвчин биз.- Аан, сүртэй юм биш. Сүүлийн үед ар нуруугаар жаахан хөшөөд байгаа юм. Бодвол бөөрмөөрхөн л байлгүй. Гал тогооны цементэн шалан дээр өчнөөн жил зогслоо доо- Үзүүлж харуулж бай. Нэгэнт зорилгодоо хүрчихсэн юм чинь одоо нэг эзэн хү н шиг байгэж үнэн голоосоо хэллээ- Харин тиймээ. Манай энэ хэд ч гэсэн тэгээд л байгаа юм гэж өөрийн ажилчдаа хэлжбайхыг бодоход тэд хоорондоо их дотно байдаг бололтой.Тэр орой яагаад ч юм сэтгэл нэг л хөнгөн. Магадгүй, сексийг хүсэж байсан ч байж бол охюм. Хүсэл дагасан юм шиг утас дуугарлаа. Авсан чинь Хөөрхөн хүү маань байх юм.Гайхсан гэж яаваа . . .

\*

\*

\*

Түр завсарлаад оройн хоол бэлддэг юм билүү гэж санан өндийлөө. Хөрг өгчнөөс махгаргасан боловч яг ямар хоол хийхээ мэддэггүй. Заримдаа ингэдэг ш дээ. Нэг их олон хоолсолиод хийгээд байдаг юм шиг яг юу хийхээ мэдэхээ байчихдаг. Тийм өдөр бололтой.Эсвэл хоол хийхэд бас онгод хэрэгтэй юм болов уу. Ямартаа ч гэсэн миний өнө өдөр хоолхийнэ гэдэг лөөлөө юм шиг ээ. За за өвгөн нэг юм хутгачихна биз. Би ийн бодоод эргэжсуулаа.

\*

\*

\*



“Унтлагын том орон дээр эр эм хоёр бэлгийн ажил хийж, хүүхний тачаадан гинших дуухадна” Ооё! нэг их сүрхий зохиолч шиг маш эвгүй мөртлөө сонин эхэлж байна уу? Урд шөнө нь Хөөрхөн хүү манайд ирсэн юм. Тэгээд л . . . Орны дэргэдэх шүүгээн дээр нүдийг хөхний даруулгаар халхалсан Бүжин бидний хэмнэлээр хөдлөнө. Би Хөөрхөн хүүгийнхээ дээр суучихсан сексийг өөрийнхөө таалалд нийцүүлнэ. Тэгтэл Хөөрхөн хүү- Би дээр нь гаръя л даа . . . - Би ингэж л хиймээр байна- Үгүй ээ, би . . . гэхээр нь би түүний уруул дээр долоовор хуруугаа тавиад сексээ эзэрхэгээр үргэлжлүүлсэн. Тэгээд л мэдэхгүй, тэнгэр газар нийлчих шиг л болж байдгаараа орь дуу тавилаа. Бүх дууссаны дараа залуугийн дээрээс бууж хойшоо орны толгой налан суувал Хөөрхөн хүү маань учиргүй гомдсон аятай харснаа, санаа алдан босоход нь түүгээр жаахан тогломоор санагдаад шүүгээний булан дээр байгаа мөнгө рүү харцаараа дохисон чинь тэр- Та яагаад энэ асуудлаа (сексийн) ингэж шийддэг юм бэ? гэж байна.- Хэмнэх гэж . . .” Хөөрхөн хүү” минь. Арай хийж олсон мөнгөө хэмнэх гэж тэр . . . - Юу? Харин ч үрж байгаа юм биш үү? Ингэхийн оронд нөхөртэй болчихвол . . . үнэгүй шдээ . . . - Харин ч үнэтэй болно гээч. Нэг нөхөр шиг юм авчирна, хооллоно, ундална, хувцаслана. Тэгээд бас хүслийг нь хангана. Больёоо чи минь. Тэгснээс хааяа хааяахан “Хөөрхөн хүү” -тэйгээ уулзчихад л хангалттай. Тэг ээд ч чамд сайхан л байгаа биз дээ? Жаргана, дээр нь 7 хоногийнхоо хэрэгцээний мөнгийг олчихно. Айн?- Жаргах гэж дээ, би ерөөсөө хүссэнээрээ байж чаддаггүй дэг. Уг нь би дээрээс нь, арааснь . . . гээд хошуу нь цорвойж байна. Хөөрхөн гэж. Гэхдээ л би түүн д нүүр өгмөөргүй санагдаад явчихлаа. Миний ааш гэж угаасаа жаахан тиймхэн юм чинь одоо яахав. Тэгээд- Юу гээч? Үнэндээ бол би таашаал авах гэж л чамайг дууддаг. Түүнээс чамайг жаргаах гэж биш. Хүн талх худалдаж авчихаад худалдагчтайгаа хувааж идээд байвал онцгүй биздээ?- Өө, за за, би тэгээд талх юм биз дээ?- Худалдагч- Хэн ч байлаа гэсэн дахиж дуудахгүй байж болно ш дээ гээд ихэд уурлаж байгаа бололтой мөнгөө шүүгээн дээрээс аваад гарах гэнэ. Тэгэхээр нь- Хөөрхөн хүү минь, наадуулаа аваарай гээд о рны урд руу дохиж, хэрэглэсэн бэлгэвчний уут зэрэгхэн рүү харцаараа заагаад- Хөдөлмөр хийж хөлсөө авсан хүн чинь хэрэглэсэн багажаа авчихаж дөнгөнө биз дээ? гэвэл тэр хэсэг харж зогссоноо гартаа байгаа мөнгөнөөс нэг дэвсгэрт сугалж ор луу миньшидээд- Цэвэрлэгээний хөлс . . . гэж хэлчихээд гараад явчихав. Түүний энэ хариулт өөрт нь бараг зохиогүй юм шиг боловчөдий болтол Хөөрхөн хүүгээс гарч байгаагүй ухаалаг үйлдэл байлаа. “Бас овоо ш дээ” гэж бодсон хэдий өөрийн эрхгүй миний ихэмсэг царайд гуниг тодро хыг би өөдөөс туса хголинд олж харлаа. Өвдгөө тэврэн суугаад, орны дэргэдэх шүүгээн дээрээс Бүжинг авч- За Бүжин минь чи бид хоёр ингээд цалинтай болдог юм байжээ. Чи юу гэж бодож байна?

Чи сая шарвалзаад гарч яваа Хөөрхөн хүүг харав уу? Энэ залуу дахиж манайд ирэхээсээ өнгөрөв бололтой. Тийм үү? гэлээ.- . . .- Тиймээ, тийм. Чи хариулахгүй. Ер нь чамд ч тэр, саяын залууд ч тэр сэтгэл гэж байхбиш. Ямар ч сэтгэлгүй юм байж бас тэр муу таашаал авах гэнэ, гайгүй байлгүй. Мөнгөө лавбал барав. Надад юу дут аж, юу үгүйлэгдэж байгааг чи ямар мэдэх биш дээ. За, за. Хурдхан шиг усанд ороод явах минь. Ингээд ертөнцийн дахиад нэг долоо хоног эхлэх ньэнэ дээ, Бүжин минь гээд босож угаалгын өрөө рүү орлоо. Гэхдээ энэ надаас гарч байгааг авир боловч миний өмнөөс өөр хэн нэгэн гаргаад байгаа юм шиг санагдаад байлаа. Би Хөөрхөн хүүгээс залхаж байсан юм болов уу . . .

\*

\*

\*

Өвгөнийг ирэнгүүт л өнөө бичгээ үзүүллээ.- Тэгнээ тэр нэг л өдөр ирэх гээд байсан юм гэж байна. Бас л дотроо хүлээж байсан бололтой. Ийш тийш угас цохиж хүүхдүүддээ хэллээ. Ойрд ирээгүй байсан хүүхдүүд бөөндалим болгон орой бөөн бөөнөөрөө ирцгээлээ. Бид хоёрт ч гэсэн сайхан байв. Сувдаа- Харин ч зүгээр юм биш үү? Энэ байр чинь их хуучирчихлаа. Энэ байрлалдаа шинэбайранд давхар ахиулаад орчихно. Сувдаагийн энэ үг мэдээж хүн болгонд таалагдажбайгаа тул эсрэг бодол бидний дундаас гарсангүй. Гэхдээ юу ч юм нэг хар юм яланг уяаөвгөн бид хоёрыг дараад болдоггүй. Хий дэмий л том охи н руугаа сэм сэм харна. Манайтом, дүү шигээ хурдан ам нээнэ гэж үгүй. Нилээн бодож байгаад бас ч гэж зөрөөдбаймааргүй үг хэлдэг юм. Тэгтэл том охин маань сая нэг ам нээж- Тиймээ, тийм. Дүүгийн хэлдэг зөв. Одоо энэ байр үнэхээр хуучирсан. Чийг хөгцнөөсавхуулаад их юм бий. Гэтэл том хүргэн- Харин аав та энэ хуралд очихдоо хамгийн дээд давхрыг нь авъя гээрэй. Олон жил дооддавхарт амьдарлаа одоо дээд давхарт амьдарч үзэхэд яав л гэж гэхэд том охин- Хэрэггүй дээ. Хоёр юм уу гурван давхарт байхад л болно. Цахилгаан тасарвал явгандээшээ гарах гэж бөөн төвөг. Настай улс зүрх мүрхээ бодохгүй бол болохгүй. Даралт чөөрчлөгдөж мэднэ. Тэгээд ч дээшээ явах гэж яарахын хэрэг юун. Залуучууд нь л гүйцгээжбайг гэхэд өвгөн- За тэгье дээ, тэгье гэнэ. Харин би доод давхарт тоос шороо нь дийлдэхгүй юм гэж бодсонч юм хэлсэнгүй. Хэлж ч болсонгүй. Өвгөний даралт жаахан өндөрийг мэдэх болохоор тэр. За тэгээд анх сонсоход сүртэй юм шиг байсан энэ асуудал шийдэж ядаад байх зүйл бишбайв. Багачуул бужигнаад, охидууд ээжийн бичиж байгааг үзье гээд. Би арай болоогүйбайна гэсээр оройг барлаа. Тэднийг явсны дараа өвгөн бид хоёр хэвтлээ. Өвгөн хэвтрээянзлах зуураа- Миний охин ч ухаантай юм даа гэж их л бахдалтай хэлж байна. Би адар ширтэнхэвтгэхдээ өвгөний хэлснийг сайн ухсангүй. Хий дэмий л дараа нь юү гэхийг хүлээлээ. Угаасаа манай өвгөн ярихдаа гол оньсоо түрүүлж хэлдэггүй, үгээ нилээн зөөж, зажилжбайж хүний тэвчээр барахын алдад хэлдэг юм. Анхандаа энэ занг нь мэдэхгүй тэгээд юүгэж, хэл л дээ гээд л байж яддагсан. Миний бо длыг батлах гэсэн шиг өвгөн- Дээшээ явах гэж яараад юүхэв гэнэ шүү хэ хэ гээд бүр нэг хэг хэг инээв. Би мөн л сайнойлгосонгүй. “Тэрэнд чинь инээх юу байна” гэж бодтол өвгөн намайг бас ойлгосонгүй юүгэсэн янзтай харснаа- Бид хоёрыг тэр дээшээ, тэнгэр өөд явах гэж яараад юүхэв, бидэнтэйгээ хамт байж бай

гэсэн далд утга гэнэ. Би сая л нэг юм ойлгож- За яршиг даа, зүгээр л өндөр давхар руу гэсэн байлгүй. Чи зүгээр нэг их ухаантай хүнболох гэж. Хаашаа юм. Мангар юм ярьж хүний толгой эргүүлж, нойр үргээгээд- Өөрөө ойлгохгүй байсан нь үнэн л биз дээ? гэж шар малтаж байна. Дотор шатах шигболоод хартал шар өвгөн нэг их наалинхай царайлж хошуу цорвойх хэрнээ нүд ньжоотойгоод шоолоод байх юм. Уур хүрээд буруу хараад хэвгчихлээ. Гар нь өнөөх латгадгаараа явж байна. Гараа ч угз татаж авлаа. Тэглээ гээд яахав дээ. Ямар босоодявчихалтай биш. Бид хоёр бас хөгширснөө мэдэхгүй хааяа ингэнээ. Юү гээд л өдөр болгонналь, наль гээд байхав дээ. Тэр өдөр нь өнөөдөр болж таарах шиг боллоо .Нам унтаж орхиж. Хаа очиж хэвтсэн даруйдаа унтдаг маань хөгшин болсон хүнд зүгээр юм гээч. Хожмоо бодож байх нь ээ, миний охины хэлсэн үг бас ч гэж бодож байж хэлсэнүг болох талтай байсан шүү. Охин маань бид хоёрыг тэртээ алсад явчихалгүй ойрхон байжбайг гэж бодсон ч байж болох шүү дээ. Зүгээр л энгийнээр бодоход шатаар өгсөж яваадзүрх нь хаагдчих ч юм билүү, хэн мэдлээ. Угаасаа би өвгөнийхөө хэлж ярьсныг тэртээхойно ойлгодог хойно одоо яая гэхэв. Хэд хоног байр сав гэж сэтгэл догдлоод үзэг цаасаанийлүүлсэнгүй. Тэгж, тэгж нэг суулаа. Нэг үеэ бодвол би юм бичиж байгаа гэдэгтээитгэлтэй болжээ.

\*

\*

\*

Гэтэл Сувдаагийн сүртэй юм биш гээд байсан шинжилгээ нь жинхэнэ сүртэй юм байсан юм даа. Учир нь Сувдаа нэг өдөр над руу уйлчихсан ярьлаа.- Би баларчээ Болороо . . . гээд таг. Би ажил дээрээ байсан хэдий ч- Одоохон очлоо. Чи хаана байна гэтэл- Танай ажлын гадаа гэнэ. Хамаг юмаа хаяад ухасхийлээ. Өрөөнд байсан эмч нар гайхсанхарцаар үдэв. Хар эрчээрээ гараад иртэл гадаах сандал дээр том ууттай рентген зурагбарьчихсан сууна.- Яваа? Юу болов?- Надад хорт хавдар илэрчээ. Би ингээд өнгөрөх нь . . . - Байз, байз. Алив үзье гээд авч нарны гэрэлд харлаа. Санаа дагаад тэр үү энд тэнд н ьцагаан толбо ч харагдах шиг.- Байна гэсээн Болороо. Би сая эмчээс хариу аваад хаачихаа мэдэхгүй нэг л мэдэхэд эндирчихэж.- Үгүй, тэгээд тэр эмч чинь чамд юу ч болоогүй юм шиг шууд л хэлчихэж байна уу?- Гэрийнхэн чинь байна уу? Ах дүү хамаатан садан байвал дууд гэхээр нь үнэнээ л хэллээл дээ. Тэгтэл харин намайг тайван байгаарай гээд бүгдийг хэлж өглөө гээд хамагамьдралаа надад даатгачихаж байгаа мэт санаа алдлаа.- За миний найз ямар ч байсан тайван байж бай. Би энийг аваад үлдэе. Харин чи гэртээхариад гэснээ “Ганцаараа хямарчих нь” гэж санаад- Ажил дээрээ оч. Сэтгэлээ барь. Охиноо бод. Урдынх шигээ байхыг бод гэж бааханзахиад явууллаа. Өнөө шинжилгээний хариуг бариад профессор багш руугаа чавхадлаа. Зураг болоод дискийг нь багш үзэж, үзэж толгой сэгсрээд- Танай ойрын хүн үү?- Тийм. Бүр багын найз- Хэцүү л байна даа Болороо минь. Тунгалагын хавдар гэж яаж ч болдоггүй золиг байдаг юм. Яахав, шимэгдэж болдог талтай ч энэ бол үнэхээр хэцүү байна. Ер нь тавилангүй шүү.

Тунгалаг эд гэдэг маань бүх биеэр тархчихсан байдаг болохоор түүгээд авна гэсэн ойлголтбайдаггүй. Эндээс харах юм бол бусад эрхтэндээ ч үсэрхийлсэн байна. Чи энийг хардагээд өнөө олон цагаан толбонуудыг заалаа.- Ямар сонин юм бэ? Дөнгөж л гучин хэдтэй залуу хүн ш дээ.- Харин тийм. Хавдар гээч өвчин ингээд залуу хөгшин ялгахгүй болчихоод байгаа юм.Зөвхөн манайд ч биш бүр дэлхий нийтээр шүү- Одоо тэгээд яах вэ? Гадагшаа, дотогшоо явах боломж юу байна? Танд таньдаг мэддэггадны хүн байвал холбоо барьж тус болооч гэж гуйхад- Багшид нь ингэж гуйсан зуу зуун өвчтөн байна. Хамгийн гол нь үр дүнд хүрдэг боляахав. Би түүрүүн хэлсэн энэ чинь дэлхий нийтийн өвчин. Ямар ч оронд очсон иймөвчтөний дараалал мянга мянгаараа байна. Манайхан үүнийг ойлгохгүй юм. Тэгээд лбаахан мөнгө үрээд л явдаг, үр дүн байхгүй- Одоо энэ хүнд хэдий хэр хугацаа байгаа бол? гэхэд багш санаа алдаад- Тавилангүй дээ. Дэлхийн практикт ингээд газар авчихаараа 3 - 5 сар л болдог юм гэлээ.Энэ үгийг сонсоод миний хамаг л итгэл найдвар хөсөр уналаа. Учир нь энэ багш мааньманайдаа энэ салбарын хавдрын талаар мэргэшсэн хамгийн туршлагатай эмч. Үүндитгэхээс өөр арга байхгүй.Ажлаа тараад Сувдаа руу явж байхдаа ямар их өрөвдсөн гээ. Эцэг эх, хамаатаг саданбайхгүй. Ганц охиноос өөр санаж сарвайх хүнгүй энэ хүн анх сонс онгуутаа чухам юу убодоо бол? Одоо ч гэсэн. Тэгээд л санаанд нь байгаа ганц эмч, хамгийн ойрын хүн нь би.Хүн чинь жаахан юм болоход л эцэг эх рүүгээ гүйдэг шүү дээ гэж бодуут нулимс тэрчигээрээ асгарлаа. Ямар гээч гай дайрах нь энэ вэ? Саяхан л төрөлх гэр ээ авчихаадбаярлаж хөөрөн, ирээдүйдээ хачин итгэлтэй байсан бүсгүй ердөө алга хөмрөхийн төдийд лхувь заяа нь орвонгоороо эргэчих гэж. Тэр муу охин нь яанаа? гээд л түмэн бодол,харуусал зайгүй эргэж чухам яаж явснаа ч анзааралгүй тэдний кафед ирлээ. Тэгэ эд басшууд яваад орчихож чаддаггүй. Бүр хэд хэд оролдоод чаддаггүй. Тэгээд утсаа гаргаж түүнрүү залгав.- Найз нь өнөөдөр амжихгүй нь ээ. Манайд хөдөөнөөс хүнд хагалгаатай хүн ирлээ.Маргааш яваад очъё гэтэл Сувдаа нэг хэсэг чимээгүй болсноо- За, за тэгье дээ гээд утас тасарлаа.Тэр шөнө би Бүжингээ тэврэн шөнөжингөө шаналсан ч Сувдаад чухам юу гэж хэлэхээолоогүй юм . . .

\*

\*

\*

Яг энэ хүрээд би цааш нь бичиж чадахгүй гацлаа. Хичнээ н олон жил өнгөрсөн ч гэсэнэргээд бодохын цагт дурсамж амилж дөнгөж өчигдөрхөн болоод өнгөрсөн мэт санагданхарцаа ч хөдөлгөх чадалгүй болчихсон суутал ашгүй өвгөн орж ирлээ. Би ч ухасхийнширээнээсээ зугатах мэт холдоход өвгөн намайг нэг сүрхий харснаа- Хөгшөөн, хоёул цай ууя гэж дуудлаа. Өвгөнийхөө дууны зөөлнийг анх удаа л сонсох шигсанагдсан. Өвгөн цайгаа оочлох зуураа- Хурал их зүгээр боллоо. Их аятайхан яриатай уриалгахан хүүхэд юм. Яг өнөөмаргаашнаас биш энэ намраас байраа суллах юм байна. Өвлөө с өмнө нурааж цэвэрлэ хюмаа даа янз нь.- Хүний юмыг авах гэж байгаа улс сайхан л аашлаа байлгүй- Яг хэдэн өрөө байсан түүнийг нь хүссэн давхарт нь өгөх гэнэ. Зарим нэг томруулах

сонирхолтой улсад үнэ мөнгийг нь ярилцаж тохироод өгөх юм байх.- Аа мэдэхгүй. Нөгөө авахдаа бөхгөр, өгөхдөө гэдгэр гэдэг нь л болчихгүй бол- Гайгүй биз дээ хө. Манай ирээдүй, хойч үе маань улам л аятайхан болохдог шүү гэснээрбидний яриа барагдчихав. Би цааш нь бичиж чадахгүй бас нилээн хэд хонолоо. “Үүнийгингэж бичих шаардлага байна уу” ч гэж бодоход хүрсэн.

\*

\*

\*

Хагас бүтний аль нь байсан юм болдоо? Нэг л их сайхан дулаахан тогтуун өдөр байжбилээ. Сувдаагийн охин Хүслэнг паркад тоглуулж байлаа. Учир нь Сувдаа охиндоотоглуулна гэж амалсан юм байж. Сувдаатай хоёул ярилаа. Сувдааг уйлж унжаад сүйдболох болов уу гэсэн чинь тэгсэнгүй. Яг одоо миний бичих гээд шуударч байгаа шигСувдаа ер бусын хүчтэй байв. Би ч нэгэнт цайрсан хүний байдлаар багшийнхаа ярьсныгхугацаанаас бусдыг нь хэлээд тавьчихлаа. Сувдаа- Найз нь тэгж ийш тийш явж эмчлүүлэхгүй ээ. Миний санаа зовох юм бол энэ биш. Харинохин минь л байна. Охин маань өдрийн ангид явах юмсан. Тэгвэл би ээжтэйгээ өдөрболгон цуг байна гэж бараг сүүлийн хоёр сар ярьж байгаа юм. Хүүхэд зөнгөөрөө мэддэгюм болов уу? гэж Сувдаа зүгээр л эгэл жирийн юм ярьж байгаа юм шиг хүүрнэлээ. Сониншүү. Тийм энгийн, тийм амгалан болчихно гэж санаагүй. Эсвэл би түүнд илэн далангүйхэлсэн нь ийм болоход нөлөөлөв үү гэж бодож суулаа. Гэтэл Сувдаа- Чи миний асуултанд хариулсангүй гээд хариултаа нэхсэн харцаар харав.- Мэдэхгүй юм даа л гэлээ. Би үнэхээр мэдэхгүй байв. Хүүхэд зөнгөөрөө ямар нэгэн юмыгбоддог гэж би үнэхээр мэдэхгүй шүү дээ. Тэгтэл Сувдаа- Би уртаашаа ганцхан кафетай. Энийгээ зараад эмчилгээний хаана нь ч хүрэхгүй. Тэгэхээрби үлдэж буй ганц охиноо тэгж ёстой шалз шиг хаяж чадахгүй. Миний охин нададанхааруулаад байхад нь би цаг алдчихаж- Уг нь чадлаараа эмчлээд охиноо ядаж сургуульд орохыг нь харчихвал л гэж бодсон юм лдаа гэхэд Сувдаа учиргүй бухимдаж- Чи бол яах вэ? Болороо. Чи бол өөрийгөө бодоод охиноо тэр чигт нь хаях уу? гэснээминий хариултыг хүлээлгүйгээр- Магадгүй. Чи бол магадгүй. Чи ямар . . . гэснээ үгээ тасаллаа. Яг энэ мөч миний гол руухар зураа татууллаа. Сувдаагийн сүүлчийн хэлээгүй үг нь ойлгомжтой. Чи ямар эх хүнбиш гэж хэлэх гэснээ арай чадсангүй. Миний нүднээс нулимс өөрийн эрхгүй урсав.Сувдаа өөрөө ч зүгээр байсангүй уйллаа. Мэдээж түүний дотор шатаж байсан байж таараа.Нэг мэдсэн чинь охин нь гүйгээд ирж- Ээжээ, та нь яагаад уйлаад байгаа юм бэ? Юу ч болоогүй байхад битгий уйлж бай.Уйлвал муу ёр гэж та нь хэлсэн биз дээ? гэнэ. Бодвол охиноо уйлахаар тэгж хэлдэг байсанбололтой.- Тийм шүү охин минь. Ээж нь уйлаагүй ээ. Салхинд л нулимс гарч байна. Чи Болорооэгчийгээ харахгүй юу. Бас л нулимс нь гарчихаж гэхэд нь би худлаа үнэн мушиймараядлаа. Зүгээр үедсэн юм бол түүнд зүйргүй их гомдохсон. Даанч зүгээр биш ийм үе шүүдээ. Би эмч хүн, өвчтэй хүн ямар байдгийг, ямар бодолтой бай дгийг мэдэлгүй яахав.Гэхдээ тэр хүүхэдгүйн тухай яриа л хувь заяаны гашуун зураа байсым. Тэгтэл Сувдаа- За, за найз нь ажил руугаа явлаа гээд охиноо хөтлөөд гэнэтхэн явчихав. Надад гайхмаарзүйл олон байлаа. Сувдаа өөр болж байгаа нь анзаарагдав. Гэртээ харьж явахад надад хүнд

ХЭЛЭХЭЭС

санаа

зовмоор

бодол

гэнэт

\*

орж

ирснийг

яана

\*

.

.

.

\*

Тэнгэр уйлагнаж, бороо шаагисан өдөр байсан санагдана. Сувдаа бид хоёр ширээндээсууж байтал Анхмаа шүхэр барьсаар орж ирээд- Өдөржингөө уйлагнаад ямар муухай өдөр вэ? гэснээ үйлчлэгчид хандан- Эгчийнхээ авдгийг гэж хоолоо уух юмтайгаа захиаллаа. Өнгөрсөн хугацаанд юу болоодөнгөрснийг тэр мэдээгүй яваа. Намайг түүнд хэлэхийг оролдтол Сувдаа над руу дохинболиулаад- Танайх ингэхэд яагаад охинтой болдоггүй юм бэ? гэж түүнээс огцомхон асуулаа. Анхмаабид хоёр хоёулаа түүний энэ асуултанд гайхав. Анхмаа- Өө, манай Надмид шинэ хүүхэд гэхээр тийм ч таатай биш байгаа юм гэхээр нь би- Үгүй тэр одоо юундаа дургүйцдэг байнаа. Ямар өөрөө гаргах гэж байгаа биш гэхэдАнхмаа- Харин тийм. Хоол ундыг нь дийлэхгүй ч гэх шиг тэнэгтээд байдгийм- Мэдэгдэхгүй байж байгаад л гаргачихгүй юу. Яав л гэж- Тэгвэл хардаад сүйд болох байлгүй гэхэд Сувдаа- Гайгүй, томхон болсон охин өргөөд авчихмаар юм даа гэхэд нь л миний тархинд түүнийюу бодож эхэлж байгааг ойлгосон юм. Харин Анхмаа- За даа, мэдэхгүй. Хүний хүүхэд манайд гүйгээд байна гэхээр Надмидад байтугай надад чсонин санагдах байх гэлээ. Сувдааг харвал тэр юм хэлсэнгүй толгой дохиж байна. “Ашгүйдээ л” гэж бодов.- Манай Сувдаад хорт хавдар илэрчээ гэхэд Анхмаа- Юу уу . . .? гэж дуу алдлаа. Сувдаа над руу нэг ёозгүй харснаа- Харин ийм л юм болчихлоо гээд бид нэг хэсэг чимээгүй суулаа.Борооноос зугатсан хэсэг залуус охид бөөн дуу шуугиан болсоор орж ирээд шаагилдаадявчихлаа. Кафе тэр чигтээ дуу чимээ болов. Аргагүй дээ залуу улс гэдэг өөрсдөөсөөөөрийг анзаарах биш. Бидний яриа ч түр завсарлав. Ер нь ч тэгээд тэр оройны биднийуулзалт бөөн гуниг дунд өнгөрлөө. Мэдсэн юм шиг Надмидын машин урд урдынхаасааэрт ирлээ. Тэр мөн л машин дотроосоо гараа даллаж байна. Сувдаа хариуд нь нэг дохисонболов. Анхмаа тэгэсгээд явж, харин би явж төвдсөнгүй. Сувдаа охиноо Анхмаад өгөхсонирхолтой байгаа нь ойлгогдлоо. Надад яагаад ч юм уйт сэтгэл төрнө. Бидний хэн, хэнмаань дотор тэр гэх тэмдэггүй үл үзэгдэм хар хуй эргэлдсээр. Өвчний



процессийг бодохоор аймаар санагдана. Би түүнд- Одоо дархлаа тэтгэх эмчилгээ хийж эхлэх хэрэгтэй байна. Юу ч хийхгүй яваад байж болохгүй. Ажил төрөл гэж санаа зовохгүй байвал зүгээр дээ гэлээ. Сувдаа юм хэлэхгүй байхыг бодоход ашгүй зөвшөөрч байгаа бололтой. Юу ч хийлгэхгүй гээд цамнавал хэцүүшүү дээ. Зарим өвчтөн хэн нэгэнд эсвэл амьдралд тунирхаад тэгдэг талтай. Сувдаагийнхувьд бүр тэгэх магадлалтай тул айсан хэрэг.

Өдөр хоног өнгөрч нэгэнт өвчтэйгээ мэдэж, цаашдаа яах вэ гэдэг дээрээ тулсан болохооранхны шок бид гурвын хэн хэнээс нь арилсан үесэн. Сувдаа маань ахлах тогоочдоо хамагажлаа даатгаад гэртээ байх боллоо. Тэр өөрийгөө саатуула хын тулд ном их уншина. Энэнь бас нэг бодлын ядраах талтай. Нөгөө дуу хураагчаа биенээсээ салгана гэж үгүй. Надад эртээрхэн нэг удаа бодогдсон адын бодол эргэлдсээр одоо бүр цаг үргэлж тархитолгойг минь шаналгах болсон байв. Энэ бол “Сувдаагийн охиныг а вчих юмсан” гэсэн бодол байлаа. Хүн гэдэг ерөөсөө биелсэн чөтгөр юм байна гэдгийг энэ бодол анх оржирсэн тэр өдрөөс ойлгож эхэлсэн юм. Гэхдээ түүнийг охиноо надад өгчихөөсэй гэсэн хүслээ би хэзээ ч орхиогүйтэй адил би хэзээ ч Сувдаад хэлээгүй юм. Зуны намуухан орой байсан санагдана. Ажлаа тараад гэрээдээ явах гэж нэг такси барилаа. Тархинд Сувдаа эргэлдээд орчныг ер анхаарсангүй. Жолооч нь намайг толиндоо хараад л байх шиг байсан юм. Угаасаа жолооч болгон л тэгдэг хойно нэг их тоосонгүй. Тэгээд буухдаа мөнгөө өглөө. Тогтмол явдаг газраа хэдэн төгрөг гардагийг мэдэлгүй яахав. Жолооч мөрөн дээгүүрээ мөнгөө авлаа. Би буугаад явах гэтэл араас- Болороо мөн үү дээ? гэлээ. Бодолд дарагдсан би эргэж харахаас төвөгшөөсөн боловч яалт ч үгүй нэрээр минь дуудсан боло хоор эргэж харахаас өөр арга байсангүй. Тэгтэл тэр жолооч хэн байсан гэж бодно.

\*

\*

\*

- Хөгшөөн, хоолоо ид гэх дуунаар би сая өндийлөө. Би хичнээн энэ цаг үе рүүгээ орсон ч гэсэн бичиж байсан хэсэг маань хамгийн эгзэгтэй нандин үе дээр байсан болохоор салж чадахгүй байв. Яг л киноны эгзэгтэй мөчид реклам гаргадаг шиг. Гэвч яалт ч үгүй өвгөн маань дуудсан болохоор очихоос яахав. Өвгөн маань сайхан гурилтай шөл хийчихэж. Тэр намайг нэг зэрвэсхэн харснаа- За зохиол нь хэр явж байна даа? гэж байна. Ер нь яагаад ч юм манай өвгөнд намайг ойлгоход нэг их цаг ордоггүй байх.- Зохиол нь ч юу вэ. Гэхдээ өнгөрсөндөө уусан, бодол болон суух чинь дахин амьдарч байгаа юм шиг сайхан л байдаг юм байна. Бас ч гэж сонин амьдралаар амьдарсан байнашүү- Тэгнэ дээ хө. Ямар ч байсан чамд л аятай байвал болох нь тэр дээ. Тэгтэл цонхны цаана барилгачид хашгичаад явчихлаа.- Юу болов оо эд чинь? гэвэл- Аан, эд яахав ингэж л байдаг юм гээд өвгөн тоох шинж алга. Нээрээ, би гадаа хбарилгачидаа ч анхааралгүй хэд хоночихож.- Үгүй ээ, ингэхэд нөгөө хүүхдүүдээ харуулна гээд урваганаад байсан охидууд яасан бэдээ? гэж би бүр хэд хоног гэртээ байгаагүй хүн шиг асуувал- Мэдэхгүй л дээ хө. Чамайг юмаа бичиг гэж санаа юм болов уу?- За яршиг. Миний юм бичих гэж юу байхав дээ. Зүгээр л аваад ирвэл барав- Охидууд руугаа ярихгүй юу дээ гэнэ. Үгүй, тэгээд яг ярьчих гэхээр нэг л хүчлэхгүй

байлаа.

\*

\*

\*

Аль хүүхэд ахуйн анхны хайр. Өнөөх шар банди чинь жигтэйхэн өндөр шар залууболчихсон зогсож байх нь тэр. Түүнийг хараад “Цагаа олж таарсангүй дээ” гэж хамгийн түрүүнд бодогдсон ш дээ. Арай ч зүрх сэтгэлийн гүнд хүлээлт байгаагүй л байлтай. Гэсэнч энэ олон жилийн дараа тааралдаж байгаа хэрнээ надад мэдрэгдсэн анхны мэдрэмж уурбайлаа. Миний оронд ямар ч бүсгүй ийм ааш гаргах байсан байхаа.- Ямар сонин хүн бэ? Ингэж нэг таардаг юмаа- Арай л өдий болтол хайлаа гэх гэсэн юм биш биз дээ?- Энэ бүх хугацаанд биш л дээ. Гэхдээ л ямар хүн болсон бол? гэж бодоод байдаг юм.- За тэгээд харчихлаа. Одоо болов уу? гээд эргээд шууд гэртээ орчихлоо. Тэрэнд хачинмуухай, эвгүй санагдсан байх. Гэртээ орох мөртөө цонхоор сэмхэн харвал тэр машиныхаадэргэд зогссоор байв. Яагаад ч юм “Арай түргэдчихлээ дээ. Жаахан ярьж зогсдог байж уу” гэж цээжний гүнд харуусал үүсэх шиг болов. Түүнийг анхаарахгүй хүн болж хувцсаасолилоо. Гар нүүрээ угаалаа. цонх руу дахин очихгүйг хичээж, өөрийгөө л хуураад байгаахэрэг шүү дээ. Бүжинд- Чиний анхны чинь эзэн ирчихсэн, гадаа зогсож байна. Чамайг гаргаад өгчихдөг юмуу? гэсэн хариу алга. Тэр ямар ярих биш дээ. Нилээн байж байгаад тэсэлгүй хөшгөө сэмхэн ярьж харсан чинь явчихсан байв. Гол руу нэг юм татаад явчихлаа.- Еэ, тэнэг. Хогоо бариад ч болтугай гарах минь яав гэж өөрөө өөрийгөө зүхлээ. Үнэндээ би түүнтэй хэсэгхэн хугацаанд ч гэсэн ярилцмаар байсныгаа ойлгох шиг. Хувь тохиол, учрал бүр заавал нэг учиртай гэдэгт яагаад ч юм итгэж эхэллээ. Хүүхэд төрөхгүй, ээж болох боломжгүй бо лсон би хүний хүүхдийг горьдож, явах энэ агшинд намайг хүүхэдтэй болгож, бас хүүхэдгүй болгох шалтагийг тавьсан тэр залуутайгаа таарнагэдэг цаанаа нэг юм хэлээд байна уу, эсвэл хувь заяаны азгүй эрхшээлд орсон намайг шоолоод байна уу би ялгасангүй. Хий дэмий л Бүжингээ тэвэрсээр хэвтлээ. Нэг мэдсэн чинь нам унтчихаж. Утас жингэнэх дуунаар цочин сэрж, орны дэргэдэх цагаа харвал шөнийн 2:45 болж байв. Нойрондоо ухамсарт хөдөлгөөн хийлгүй манарч хэвтгэл дахиад л давчдах мэт чарлана. Дэлгэцэнд нь “Suvdaa” гэж гарчээ. Хурдхан шиг авбал- Болороо, би өвдөөд байна. Нуруугаар тасрах нь ээ. Яах вэ? гэсэн Сувдаагийн тамирдсандуу гарлаа. Энэ маань намайг шөнө дуудаж буй Сувдаагийн анхны дуудлага байлаа. Үүнээс хойш нилээн хэд дуудсандаа.- За одоохон. Би очлоо. Тайван бай гээд гадуур хувцасаа углаад шөнө дөлөөр гарч харайлаа. Зам дээр гараагүй шахам байхад хаанаас ч юм нэг тэрэг ирж зогсов. Хурдхан шиг суугаад- Их дэлгүүрийн арын байшин, яваарай, яваарай. Хурдлаарай тэнд хүн өвдөөд баларлаа гэж амьсгаагаа давхцуулан хэлвэл машин ч зам дээр бүтэн эргээд давхилаа.

- Жирэмсэн юмуу? гэж асуух жолооч харин орой таарсан нөгөө Сүхээ дүрээрээ байлаа.- Яахаараа . . . гээд дараагийнхаа үгийг хэлж амжаагүй байтал- Энүүгээр явж байгаад таарлаа гэнэ. Надад эргэлзэх, гайхах з ав байсангүй. Сувдаагийнгадаа удалгүй давхиад ирлээ. Би бууж хэд харайснаа эргэж- Чи байж байхгүй юү? Би аваад гараад ирье гээд хариу ч сонсолгүй хар эрчээрээ орлоо.Сувдаагийн хамаг биенийх нь хөлс цутгачихсан төрөх гэж буй хүн шиг яраглан ёолж байв.Хурдхан шиг хувцас өмсгөөд авч гарлаа. Сүхээ ашгүй байж л байна. Суулгаад хавдартынэмнэлэг рүү давхилаа.Энд л би эмнэлэгт ажилладагийнхаа хэргийг гаргав. Ийш тийш утасдан байж Сувдаагааарайхийн хэвтүүлээ. Жижүүрийн эмч нь өвчин намдаах тариа хийгээд - Ямар ч байсанөглөөнөөс химийн эмчилгээнд оруулах байх. Юутай ч гэсэн өглөө ирээрэй гэлээ. Намайггарахын алдад Сувдаа

- Өнөөдөр Хүслэнг авах ёстой. Чи авчих тэгэх үү? Би ийм байдалтай охиндоохарагдмааргүй байна. Охин маань өдрийн ангид орно гээд ээрээд ба йхаар нь ээж ньжаахан өвдөөд байна гайгүй болохоороо оруулна гээд гэчихсэн. Тэгэхээр одоо намайгхараад итгэл нь хугарчих байх. Гэрт өөрийнх нь нэг бор туулайн чихмэл байгаа түүнийгбитгий мартаарай тэвэрч унтдаг юм. Аа, тийм “ээжийн бүүвэйтэй хорвоо” гэд эг дууг аялжөгвөл дуртай байдаг юм гэлээ. Сувдаагийн охиныг хажуудаа хэд хоног байлгана гэхээрсонин ч юм шиг, сайхан ч юм шиг санагдана.Эмнэлэгээс гараад ирсэн чинь дөнгөж үүр хаяарч байлаа. Зуны өглөө шувууд жиргэж,модод сэрчигнээд цаанаа нэг сайхан. Нүдний угаар аргаж байхыг бодоход ядарсан юмболов уу. Гэхдээ олон удаа жижүүрт гарч, олон арван өвчтөнтэй зууралдаж явсан хүн чиньэнэ зэргийг даалгүй яахав. Сүхээ намайг хүлээгээд зогсож байх юм.- Чи яваагүй юм уу?- Чамайг дөхүүлээд өгдөг юмуу гэнэ. Би нэг их цааргалсангүй. Тэр намайг суулгаад өглөөэртийн хоосон шахуу гудамжаар давхилаа. Хараад байсан чинь манайх руу биш, урагшаачиглээд байх юм.- Манайх ийшээ биш л юмсан. Чи осолдохгүй өчигдөр орой хүргэж өгсөн, мэдмээр юмаагэж хэрэндээ дургүйцэнгүй хэллээ.- Би чамд юм үзүүлье. Одоо очоод чи унтана гэж байхгүй.Нээрээ ч тийм л байсан л даа. Гэртээ очоод тэгэс ингэсгээд л эргээд ажилдаа гарна.“Өнөөдөр Сувдаагийн охиныг цэцэрлэгээс нь авна. Тэр надтай ямар байх бол” гэсэн сонинхэрнээ сайхан бодол намайг хөглөж байв. Бид давхисаар Зайсан толгойн тал дээр гараадирлээ. Тэрнээс цааш машин явах биш. Бууцгаалаа- Хоёулаа дээшээ гарах уу? гэнэ- Ядарч байна- Би чамайг үүрье. Ажилдаа хоцорчихож магадгүй. Одоо хүн байхгүй юм чинь хэн л харавгэж- За яршиг байнаа. Хар өглөөгүүр хаа байсан бага насандаа хаяад явсан залуудааүүрүүлчихсэн Зайсан өөд мацаж явна гээд төсөөлөөд үз л дээ- Болохгүй нь юү байхав дээ гэнэ. Ингээд зогсоод байвал хэрэлдэх шинжтэй болохоор ньшатаар ганц нэг гишгэсээр дээшээ явлаа. Өндөрийг нь нэг их анзааралгүй гараад ирэх ньтэр. Сүхээ- Удалгүй нар мандана. Чамд үүнийг л үзүүлэх гээд хоцорчихож магадгүй гэсэн юм.

Яагаад ч юм би дөнгөж мандаж буй наранд их дуртай. Тэндээс нэг тийм сэтгэл ханамжирээд байх шиг байдаг юм гэнэ. Тун удалгүй тэнгэр зүүнээсээ улайрч байснаа томоо гэгчийн улаан нар гарч ирлээ. Байгальгэдэг хүний сэтгэлийг хөглөдөг ажээ. Тэр тусмаа гэрэл гэгээ. Нээрээ ч түүний хэлснээр ямар нэгэн эрч хүч ирэх шиг. Дуу аялмаар ч юм шиг. Цээжний гүнээс хөнгөн гунигхөндүүрлэх хэдий ч тэгтлээ муухай санагдсангүй. Тэглээ гээд жаахан охин шиг хөөрчдэвхцэлтэй биш. Өндөрт юм болохоор салхи сэвэлзэж байна. Сүхээ хүрмээ тайлж надад нөмрүүлэв. Нэг тийм эр хүний содон, эзэрхэг үнэр түүний хүрэмнээс үнэртэнэ. Хүсэл, сэрэл, мэдрэмж гэж чухам юу юм бол . . . ?

\*

\*

\*

Зөөлөн амьсгаа сэргэж, эр хүний үнэр үнэртэхэд дээшээ харвал өвгөн маань мойний жяваа хуруугаараа хацрыг минь илж, уруул дээр минь үнсэв. Бид чинь өтөлсөн л болохоосүхчихсэн биш дээ. Бичиж байснаа тэр чигт нь хаяв. Хөөрхий дөө, өвгөн минь намайг одоо ямар өргөж даах биш. Хөтлөлцсөөр унтлагын өрөөндөө орлоо. Хэсэг хугацааны дараа өвгөн маань нилээн амьсгаатай дээшээ харж хэвтээд- Бас ч гэж болж байна шүү гээд над руу эрэмшүү харж инээмсэглэх нь өөртөө баярлаад байгаа бололтой. Эрчүүдээ гэж хөгтэй ч улсаа даа та нар. Тэр өнөөх л зангаараа миний гарыг атгаж, дахиж нэг сайхан үнсээд хэвтэж байснаа унтаад өглөө. Өвгөнийхөө жигдхэнамысгааг сонсон хэвтэж байхдаа- Болж байна гээд байгаа юм шүү гэж амандаа хэлчихээд хэнээс ч юм ичмэглэнхөнжлийнхөө захаар амаа даран харанхуй шөнө нүдээ гялтгануулан айлгүйтлээ. Яахав дээ. Хажууд байгаа Бүжингээс өөр хэн л намайг харав гэж. Эмгэн ч гэсэн эм юм чинь хааяа нэг харанхуйд ч болов айлгүйтэж болно биз дээ, би . . . ?

\*

\*

\*

Орой нь би Хүслэнг цэцэрлэгээс нь авахаасаа өмнө гэрээр нь дайрч түүний туулайг авч очлоо. Тэгэхгүй бол ээж нь биш намайг о чихоор дургүйлхэж магадгүй гэж бодсон юм. Явах замдаа бас “Ээжийн бүүвэйтэй хорвоо” гэдэг дууг тархинаасаа хайж, олсон хэсгээ амандаа аялж үзлээ. Болж байнаа. Тэр их хөөрхөн юм. Би урд нь түүнийг өнөөдрийнх шигингэж шимтэн харж байсангүй. Дөрвөн настай бумбайсан охин шүү дээ.- Нөгөө, нөгөө . . . Та нь намайг авч байгаа юм уу? гэнэ. Тэр та нь, би нь, чи нь гэж ярьдаг юм байна. За тэгээд дуугай байна гэж байхгүй юм даа.- Нөгөө, нөгөө . . . Манай ангийн Анука их муу хүүхэд- Яагаад? Та нар чинь найзууд биш юм уу?- Нөгөө, нөгөө . . . Заримдаа л найзууд. Анука нь намайг аавгүй, аавгүй ингээд байдгийн. Ярихсан гэж яарах, асар олон нөгөө, нөгөө нь зэрэгцээд бүр амьсгаа нь давхцана. Хөөрхөнгөж яваа. Гараас минь атгаж яваа бяцхан гар нь аргалын цог шиг халуун. Хэрвээ бижинхэнээсээ ингэж охиноо хөтөлж яваа бол ийм мэдрэмж төрөх эсэхийг мэдэхгүй юм. Эртээрийн Сувдаагийн “Чи мэдэхгүй л дээ” гэж уурладаг үнэний хувьтай юм гэж бодож явлаа.- Нөгөө, нөгөө . . . та нь паркыг мэдэх үү? гэж амьсгаадна. Би бодолдоо бол оод нилээдхурдан алчихаж. Миний алхааг гүйцэх гэж шогшиход дээрээ хоёр

боосон үс ньсөөсөгнөж, тас тэвэрсэн туулайных нь хоёр чих далбаганана.

- Мэдэлгүй яахав. Эртээр бид гурав тэнд байсан шүү дээ. Чиний туулайг хэн гэдэг юм?- Нөгөө, нөгөө . . . Нэр байхгүй ш дээ- Манайд Бүжин гэдэг туулай бий- Нөгөө, нөгөө . . . Жинхэнэ үү?- Үгүй ээ, бас л чинийх шиг. Чи бас түүгээр тоглож болно. Чи парк явах тийм дуртай юмуу? гэхэд охины нүд цог шиг гялтганан толгой дохино- Хоёулаа маргааш очиж тоглоноо- Нөгөө, нөгөө . . . Ээж нь ирэхгүй юм уу?- Ээж нь ажилтай. Хөдөө явсан гэхэд түүний харц бүүдийж, хачин уруу царайлна. Хөөрхий дөө, ээжтэйгээ л уулзах гэж бүтэн тав хоног хүлээдэг байж таарна. Арай хийжтав хоногоо дуусгаад ирэхээр ээж нь байхгүй. Ийм жаахан охины хурууны үений чинээзүрхэнд ямар их харуусал хурж байгаа нь ойлгомжтой. Орой чухам яадаг болдоо гэж санаазовж байсан чинь Хүслэн их биеэ даасан хүүхэд байлаа. Хорин дөрвийн цэцэрлэгт явдаг болохоор тэр юм байна даа гэж бодов. Хоёр туулайтайгаа ярьсаар байгаад унтлаа. Түүнийг жаал ширтэж сууснаа орхин интернет рүү орж Сувдаагийн өвчний талаар жаал харлаа. Аргаа л барсан хэрэг л дээ. Миний барагцаалснаар Сувдаад 3 - 4 сар л үлдсэн байв. Шинжилгээнээс үзэхэд нойр булчирхайд нь хүртэл үсэрхийлсэн байлаа. Тэг эхээр багшийнхэлдгээр ёстой тавилангүй. Санаагаар болдог юм бол энэ бүгдийг хэлээд охиныг нь гуймаар. Гэвч хүн ёс гээч юм бидэнд байх ёстой шүү дээ. Утас дуугарангуут Сувдааг бодон сандруухан авгал Сүхээ ярьж байна. Сандарсандаа тэрүү жаахан дургүйцэв.- Маргааш та хоёр юу хийх гэж байна? гэнэ. Юу ч хийсэн түүнд юуны хамаатай гэж. Гэхдээ ингэж хариулж чадсангүй.- Парк явнаа л гэлээ. Ямар нэг их ярих юм байх биш. Тэгэсгээд тасарлаа. “Энэ нэг юм чинь одоо яах гээд л ойр, ойрхон залгаад байна даа” гэсэн бодол бодогдож байна. Маргааш нь амалсан ёсоороо Хүслэнг авч парк явлаа. Ээжийгээ ойр ойрхон ярих боловч хүүхэд юм болохоороо тоглоомондоо сатаарна. Тэгтэл хаанаас ч юм Сүхээ гараад ирлээ. Юу билээ гэж бодох зуур өчигдөр наашаа ирнэ гэдгээ хэлсэн санагдана. Гартаа бүх тоглоомын тасалбар атгачихаж. Яахыгаа бас мэддэг бололтой юмаа. Би Сүхээд- Чи бид хоёр одоо ингэж цагаа үрж, мартагдсан тоглоомоор тоглоод яахав даа. Чи явжганц нэг хүн авбал дээргүй юу гэж такси барьдгаар нь дайруулан наашаагаа битгийгүйгээд бай гэсэн чин санаагаа хэллээ.- Би өнөөдрөөс больж байгаа- Яасан? Өөр ажилд орж байгаа юм уу?- Би чинь цагдаагийн ахмад хүн шүү дээ.- Хөөх, Танайх чинь тийм муу цалинтай юм уу?- Үгүй дээ, Ганц бие надад хангалттай. Энэ манай дүүгийн түрээсийн тэр эг л дээ. Дүүмаань хоёр хоног явж чадахгүй болоод. Тэгээд л түрээсийнх нь мөнгийг олох санаатай явж байсан чинь чамтай таарсан хэрэг.- Жаахан хүчгүй л болохоос байж болох л шалтаг юм гэж намайг итгэж ядан байгааг ануулгүй хэлэхэд- Би хойшоо яваад тэндээ цагдаагийн сургуульд орсон юм. Тэр үед цагдааг сэргийлэх гэдэг байсан. Төгсөж ирээд Ховд, Увс, Баян - Өлгий гээд дандаа баруун аймгуудад ажиллаж байгаад хотод ирээд хоёр жил болж байна.- Авгай хүүхэд . . . ? гэснээ санаа зовж- Зүгээр л сонирхоод л асуучихлаа. Хариулахгүй ч байсан болно гэдэг нэвтрүүлэг байдаг

байхаа?- Уг нь нэг бүсгүйтэй суусан юмаа. Яагаад ч юм бид үр хүүхэдтэй ч болсонгүй. Минийажил гэж хөдөө их явах юм. Гэртээ ганцаараа байх хэцүү байсан биз дээ. Харин чи . . . ?- Суусаан суусан. Олон ч хүүхэдтэй болсон. Сайхан л байна . . . гэж түүнд тунирхажбайгаа юм шиг хэлээд- За, за худлаа солиорсон юм. Ямар сайндаа л хүний ганц үрийг саатуулж явахав дээгэчихээд “Би чинь одоо юугаа солиороод унаваа” гэхдээ амаа хамхилаа. Хэсэг чимээгүйсууцгаалаа.- Засаж болдоггүй алдааг л алдаа гэдэг юм гэж муу аав маань хэлдэгсэн. Тэр нь л болжбайх шиг байна. Тэртээ хаврын нэгэн өдөр яг л ингэж хэлсэн юм даа. Өдий болтол хүүхэдгаргасангүй. Үүнийг бодох тоолондоо би чамайг үзэн яддаг. Юугаа ч мэдэхгүй, учраа чойлгохгүй жаахан охиныг чи яалаа гэж хаяж явсан юм бэ? Тэгээд одоо гэнэтхэн хаанаас чюм гарч ирчихээд гэмгүй шувууны тухай үлгэр яриад . . . л. Яагаад би чамд итгэх ёстойгэхэд Сүхээ- Харин одоо бол би том болсон шүү. Хэлсэн ярьсандаа эзэн болно- Тэгээд тэр чинь хэнд хэрэгтэй гэж? гээд цааш нь үргэлжлүүлэх гэснээ тэвчлээ. Миний уур ч юмуу, гомдол ч юмуу нэг юм цээжинд хурж, хамрын уг руу огшиж байгаагмэдэрч байлаа. Уур ч гэж дээ дургүй хүрээд болох биш. Тэгээд- За, за чи бид хоёр одоо хэн хэнийгээ билүүдэж суугаад яахав. Ямар цаг хугацаа эргэжирэх биш. Хүслэн, явах уу? гэж охиныг дуудлаа- Ээжээ, ээжээ . . . гэж Хүслэн хашгирснаа царай нь хувирч- Нөгөө, нөгөө . . . - Юу гэсийн? Эгчдээ юм хэлэх гээ юү? Хэл л дээ . . . гэтэл Сүхээ хажуунаас- Хүслэн мөхөөлдөс идэх гэсэн байхгүй юү, тэ? Алив, гурвуулаа явья гээд түүнийг сэвхийтэл өргөж мөрөн дээрээ суулгаад түрүүлээд алхчихлаа. Ямар боль, боль гэлтэй бишдагаад л явав. Хүслэн тоглоомондоо ядарсан уу мөхөөлдөсөө хагас дутуу идээд унтчихлаа. Сүхээ түүнийг үүрсээр манайд авчрав. Хүслэнг орон дээр хэвгүүлчихээд миний Бүжинголоод харчихлаа. Тэр Бүжинг авч- Энэ чамд одоо болтол байдаг юмуу? гэхээр нь- Чи надад үүнээс өөр юм үлдээгээгүй ш дээ гэж хэлэхтэй зэрэг өдөржингөө барьж байсануур цухал нулимс болон гоожлоо. Сүхээ миний мөрөөр тэвэрч цээжиндээ наасан. Уйлсандаа болоод тэр үү би Сүхээг түлхсэнгүй. Гэнэт утас хангиналаа. Харвал “Нuurhunhuu” гэж гарч байна. Яаж зогсоогоо гэнэтхэн сэхээрч хүйтэн өнгөөр- За, за яв гэвэл- Тэгье ээ, сайхан амраарай гээд Сүхээ гарлаа. Би өөрийн эрхгүй цонхон дээр очиж түүнийараас харж зогссон юм. Яг л хүүхдээ унтуулаад нөхрөө юунд ч юм үдэж өгч буй бүсгүйшиг. Тэр үед гэр бүлийн амьдралын хамгийн энгийн зүйл ч гэсэн гоё байдаг юм байна даагэж бодогдсон. Дахиад л утас дуугарахаар нь Хөөрхөн хүүг шууд тасалж орхилоо. Нэг дэхь өдрийн өглөө Хүслэнг хүргэж өгөхдөө хоцроочихож. Гүйсээр байж, “24 - ийнцэцэрлэг” гэсэн хаягтай байшингийн хаалгыг нүдлээ. Цэнхэр халаадтай бүдүүн эмэгтэйбагш хаалга онгойлгоод- Долоо хоногт ганцхан өдөр авчирч өгч байж та нар хоцроохгүй байж болохгүй нь үү?гээд охиныг татаж оруулаад хаалга хаагдав. Хүслэнг цэцэрлэгт нь хүргэж өгсөн өдөр



Сүхээ бид хоёр Сувдааг эмнэлэгээс нь гаргаж авсан юм. Химийн эмчилгээ гурав дөрөвхөнхоногт хийдэг болохоор тэр. Сувдаа надаас харцаараа Сүхээг хэн болохыг асуугаад байгаабололтой бүлтгэнээд байна. Сүхээ биднийг оруулаад явсны дараа Сувдаа- Охин гайгүй юү?- Гайгүй ээ, Их биеэ даасан хүүхэд юм- Энэ залуу юун залуу вэ?- Яагаав, нөгөө Сүхээ. Танай дараа нүүж ирсэн гээд Анхмаа бидний яриад байдаг. Иймзалуу болчихсон байна.- За, за Болороо ч гараад өгч гээд бас намайгаа шоолохтойгоо. Тэгтэл Сувдаа- Өнөөдөр хэдүүлээ манай кафед очъё- Чи яаж болохов дээ.- Зүгээрээ, би сууж л байя. Нэг очиж нөгөө хэддээ бас босс царайлахгүй бол болохгүй.Ядраад байвал гэртээ хүрээд л ирнэ биз гэлээ. Тэгэхгүй гээд яахав.Орой нь Анхмаа жигтэйхэн уруу царайтай, нүд нь бүлцийсэн юм ирэв.- Чи яагаа вэ? Наад нүд ам чинь. Бас арай өвдөөгүй биз дээ? гэж Сувдааг асуув. Уг ньАнхмаа л Сувдаагийн биеийг асуумаар. Анхмаа хэсэг түгдэрснээ- Урд шөнө нойр муутай хоноод оо. Надмидын уурхайд нэг хүн нас барчихаж. Тэгээд л . . .гэлээ. Анхмаагийн харц нэг л худлаа юм шиг санагдсан ч хүний үхэл ярьж байхадитгэхгүй гээд яахав. Тэнд хүн нас барахад гэртээ суудаг Анхмаа нойргүй хонодог юу лбол. Үгүй тэгээд байж болох ч нэг л сонин.Биднийг цуглаад удаагүй байтал цонхны цаана Надмидын машин ирж зогслоо. Дотроос ньчихэр, вино барьсан Надмид нүүр дүүрэн инээсээр бидэн дээр ирлээ. Урд нь ерөөсөөуулзах нь байтугай даллаад байхад ирдэггүй хүн гэнэт ингэхээр гайхахаас өөр аргагүй.Анхмаагийн царай улам л гунигтай болж хувирав. Энэ өдөр би Надмидыг өөрийн эрхгүйновш гэж бодсон юм. Тэр юу ч юм ярьж худлаа инээх нь нэг л зэвүүн. Би- Танай үйлдвэр дээр таагүй юм боллоо гэсэн гайгүй юү? гэтэл Надмид Анхмаа руу нэгхарснаа- Аан, тэр зүгээрээ. Аль дээр болсон юм явдал гэнэ. Анхмаа тэр хоёрын аль нэг нь худлааярьж байв. Надмид- Би ч охин хүсээд, хүсээд манай Анхмаа гаргаж өгдөггүй ээ. Гэрийнхээ ганц эрх дагинабайх гээд л тэр байх гээд учиргүй хуурай инээлээ. Нэг л авцалдаагүй. Анхмаа түүнийгнүдний булангаар ёозгүй харахыг би анзаарчихав. Харин Сувдаад Надмидын ярьж байгаатаалагдаж байгаа бололтой. Миний дургүй хүрч- Анхмаагийнхаа альхан хөлд нь суумаар юм дээ. Ямартаа ч гэсэн номхруулж авсан ньдээр байхаа гэхэд- Аль ч хөлд нь суусан тангараад болохгүй байгаа юм. Ямар сайндаа охин хүүхэд өргөөд чболтугай авдаг юмуу гэж бодож байхав. Охин гэдэг чинь өр нимгэн хөөрхөн ш дээ гэжхачин нирваан дүр гаргахад бид бүгд чимээгүй боллоо. Өнөөдөр чухам ямар зорилгоорирсэн нь одоо л нэг ойлгогдов. Анхмаа яг юу бодож буй нь мэдэгдэхгүй ч ямартай чдуртай биш байна гэдэг нь харагдаж байлаа. Яагаадыг бол харин мэдсэнгүй. Дээх нь нэг

өдөр ярьж суухад гэрт нь айлын хүүхэд гүйгээд байвал нэг их дуртай биш тухай ярьжбайсан. Гэтэл ахиад нэг хүүхэд төрүүлнэ гэхээр дургүй байсан Надмид охин хүүхэд өргөжавах дуртай болж хоцорсныг бас ойлгосонгүй. Надад зөвхөн мэдрэгдэж байсан мэдрэмжбол Надмидыг үзэн ядаж байлаа. Сувдаа угаасаа эднийхийг элэг бүтэн сайхан гэр бүл гэжүздэг. Тэгэхээр охиноо боломж гарвал эднийд өгөх дуртай байх нь мэдээж. Тэгэхээр биялагдах болж байлаа. Миний бодлыг батлах гэсэн шиг Сувдаа- Хөөрхөн, ухаан орчихсон охин авчихад болохгүй ч юмгүй л дээ гэхээр нь би өөрийнмэдэлгүй- Юу ярьж байгаа юм? Ийм сайхан залуу, ийм сайхан хүүхэн хоёроос сайхан охинтөрөлгүй яадаг юм гэж цэхвэлзлээ. Бодвол би ч гэсэн тэдэнд ойлгомжтой харагдсан байх. Үүнийг анзаарсан Анхмаа гэнэтхэн ам нээж- Энэ яриагаа больё оо. Ямар манай тухай ярих гэж ирсэн биш. Тэгээд ч оройтлоо. Явцгааягэхэд би уухайн тас- Харин тийм. Сувдаа ч гэсэн ядарлаа. Дөнгөж өнөөдөр эмнэлэгээс гарсан хүн гэж хэлээдхариу ч сонсолгүй босцгоолоо.Надмид Анхмаа хоёр ч явав. Би Сувдааг аваад гэр лүү нь т аксигаар явлаа. Машинд явжбайхдаа бид хоёр хэн хэн нь дуугарсангүй. Гэтэл Сувдаа чимээгүйг эвдэж- Болороо, би тэднээс гуйвал яах бол? Надмид ч хүүхдэд сайн байж мэднэ шүү, тэ? гэв- Анхмаа хүний хүүхдэд дургүй гэж урд нь ярьж байсныг бид хоёр хоёулаа со нссон доогээд тавьчихлаа. Сувдаа тэгэсгээд юм хэлсэнгүй . . .

\*

\*

\*

Нэг мэдсэн чинь Сувдаа маань ороод ирчихэж.- Та ч аймаар завгүй сууж байгаа юмаа даа. Намайг ирснийг ч мэдсэн гүй. Алив би уншьягээд нэг хуудас шүүрэхээр нь- Байг чи. Нэг мөсөн дуусахаар нь уншихгүй юү гээд булааж авлаа. Өвгөн тэндээс- Миний охион, дараа бол. Ээж нь өгөхгүй л гэсэн бол өгөхгүй. Чи ямар занг нь мэдэхгүйбиш гэж Сувдаад хандан хэлж байна.- За, за болье болье. Хэзээ дуусахыг нь л хүлээж байхаас- Чи хүүхдүүдээ авчирч харуулах юм яриад байсан яав? гэхэд- Эцэг нь гэж нэг өвчтэй юм ээжид садаа болно яршиг, эндээ байж байг гээд байх юмбайна ш дээ гээд шарвалзав. Өвгөн- Болж дээ. Өрхийн тэргүүн гэдэг чинь тиймэрхүү л байдгийм ш дээ гэж бага хүргэнээсүрхий магтаж байна. Сувдаа- Хн! Яршиг л байна ш дээ. За, за би явлаа- Чи ядаж хоол . . .- Идэхгүй ээ, идэхгүй гээд гарч одов. Санаа нь бид хоёртоо л эрхэлж байгаа ухаантай.Өвгөн над руу толгой сэгсэрч- Мундаг охин шүү. Чи бид хоёрын нэгийг л дуурайсан байгаа даа гээд над руу нүд

буландаж харснаа арсайтал инээж байна. Намайг давж байгаа ухаатай. Дотор шатаадявчихлаа.- Тэгээд, тэгээд чи хэнийг гэх гээв? гээд ширэв татчихаад угаалгын өрөөнд яваад ор чихов.Өвгөний хүг, хүг инээх дуу битүүхэн сонсогдсогдоход нь би нүүрээ хурдан, хурданшударч угаав.

\*

\*

\*

Бодвол Сувдаа надад хэлэх хэрэггүй гэсэн зүйлээ хэлчихлээ дээ гэж бодож байсан байх.Хүүхдээ надад өгөх болов уу гэсэн горьдлого үндсэндээ тасарч эхэллээ. Үнэндээ бол би лбодоод, горьдоод яваа болохоос энэ бодлоо түүнд хэлээгүй юм чинь. Эх нь амьд байхадийм юм бодож байсан гэхээр хүн үнэмшмээргүй. Үнэмшсэн нэг нь намай г үзэн ядмаарбайгаа биз? Гэхдээ л хүн гэдэг хэдийд ч, юуг ч бодож чаддаг юм билээ дээ. Нэгэнтнайдваар багассан учир би аргаа барсандаа- Одоо асрах газар чинь ямархуу журмаар ажилладаг юм бэ? гэж би Сувдаагаас ч юм шигөөрөөсөө ч юм шиг асуулаа. Асуух ч г эж дээ Сувдаад ингэж хэлээд өөрийнхөө тухайбодуулах арга олж байгаа ухаантай. Сувдаа над руу нэг сүрхий харснаа- Чи миний охиныг асрах газар өг гэх гээд байна уу? Та нар яахаараа хүүхэд өнчрөхболохоор асрах, асрах гэж байдаг юм гээд намайг үзэн ядсан ха рцаар харлаа. Ингэнэ чинээбодоогүй байсан би- Үгүй ээ, үгүй. Би яалаа гэж тэгж бодох юм бэ. Хэрвээ намайг буруу юм хэлсэн болуучлаарай гэхэд- Би яаж ч байсан охиноо асрах газар өгч өөрийнхөө араас оруулахгүй. Тэнд ямар байдгийгчи мэдэх үү. Мэдэхгүй ш дээ гээд намайг харснаа бодлоо цэгцлэх мэт хэсэг дуугаа хураав.Тэгээд намуухан дуугаар- Манайд дуу хөгжим ордог нэг залуухан багш байдаг байлаа. Эр юм байж үсээ шалчийталсамнаж үнэртэй ус түрхсэн хөгийн амьтан. Хаанаасаа ч олдог юм печень, чихэр нададөгнө. Бүр байнга шүү. Хүүхэд юм болохоор авчихна. Чи намайг багшаа гээд хэрэггүй.Ахаа л гэж бай гээд л . . . нээрээ ч миний ах ч юм шиг санагдах үе бас байна. Өнчинөрөөсөн хүнд чинь наашаа гэсэн болгон сайн хүн шиг санагдана. Ялангуяа хүүхэд байхад.Намайг төгсөх ангид байхад шинэ жилийн үдэшлэг шиг юм болсон юм. Тэр орой намайгүнсчихэв. Ахаа гэж бодож, бүр итгэж явсан хүн чинь гэнэт тэгэхээр айх ч шиг, гайхах чшиг. Түүнээс хойш зугатаж эхэлсэн. Нэг өдөр өрөөндөө сууж байсан чинь ороод ирсэн . . .гэснээ Сувдаагийн дуу цаашаа орчихлоо. Тэгээд яасан юм бол? гэж бодтол тэр цааш нь- Муу новш чинь хүнтэй ноцолдсоор байгаад . . . Би нус нулимстайгаа хутгалдаад уйлаадбайдаг, уйлаад байдаг. Бузрын амьтан чинь дуусчихаад бас аргадах гэж янз, янз болсноосүүлдээ чамд өөрийн гэх хүн байхгүй шүү. Амаа мэдээрэй. Хэрвээ чи хэлэх юм бол энэбайрны бүх эрчүүл чамайг шившиглэх болно шүү. Орчлонгийн шившиг болов чи гэжзагнасан гэлээ. Би Сувдааг одоо л уйлах болов уу гэсэн чинь тэгсэнгүй. Харин чхөмхийгөө зуугаад

- Би тийм газар охиноо үлдээх гэж үү? Чи тэрийг хүсэж байна уу? гэлээ. Энэ удаа би- Чи надад үүнийгээ яриагүй ш дээ. Санаж байгаа биз дээ? Хэрвээ ярьсан бол би юуболлоо гэж асрах газрын чинь тухай дурсах юм бэ гэж ширүүхэн хэллээ. Тэртэй тэргүй биялагдаж байсан болохоор тэвчээр барагдаж байсан байх л даа. Сувдаа юм хэлсэнгүй. Түүнийг дуугай байх тусам би байгаа байдалдаа, гаргасан аашиндаа гэмшиж байлаа. Тэгээд- Уучлаарай Сувдаа, би муухай аашилчихлаа гэхэд тэр- Одоо надад ялгаагүй дээ гэж хөндийхөн өнгөөр хэлэв. Миний зүрх цөмөрчих шиг лболсон. Өнчин өрөөсөн жаахан охин хүнд, тэр тусмаа багшдаа хүчиндүүлчихээр чухамямар байдаг бол гэхээс дотор арзайж байлаа. Түүний дэргэд миний зовлон юу ч биш байв. Тэгээд цаашдын хувь тавиланг нь мэдэж байгаа нэгд эмч, хоёрт найз хүний хувьд түүнийгчадлынхаа хэрээр хайрлаж асарч байгаад дуусгая гэж дотроо хатуу шийдэв. Би энэшийдвэртээ хүрсэн юм шүү. Өвчиндөө зовиурлаж, хорвоо ертөнцөд гомдсон бүсгүй хүнийавир гэдэг дэргэд нь байхад ч халгамаар байдаг юм билээ. Гэхдээ би тэссэн л юм даа. Гэхдээ энэ тухай одоо бичихгүй ээ. Сувдааг хэн нэг нь харах хэрэгтэй болж байсан үе. Хэн нэг нь юу байхав. Анхмаа сүүлийнүед утас шөрмөсөө ч авахгүй, дуу муутай болчихсоныг хэлэх үү, эртээрхэн Надмид бидгурав дээр ирснээс хойш бүр ч чимээгүй болсон байлаа. Тэгэхээр би л үлдэв. Ажилдаахэлж байгаад хоёр сарын чөлөө авлаа. Сувдаа Анхмааг байнга асууна. Ямар сайндаа Анхмаа руу утасдлаа . . .

\*

\*

\*

- Хөгшөөн Анхмаа ярьж байна гэх өвгөнийхөө дуунаар би ширээнээсээ бослоо. Яг түүнийтухай бичиж байх үед тэр утасдаж байгаа нь сонин ч юм шиг- За сайн уу? Юу л хийж байна даа? тэтгэврийн мисс минь гэх түүний дуу цовоо цойлгонсонсогдоно. Хэд дүү юм гэсэндээ намайг шоолж байгаа нь тэр.- Юу хийхэв дээ. Өвгөн тэтгэврийн босс тэгэхээр би юу болох нь мэдээж шүү дээ. За тэряхав. Манайхаар нэг ирээч дээ. Өвгөн бид хоёртой жаал хуучлахгүй юм уу?- Би ойрд нэг хот орохоороо заавал очноо. Том хүү маань доктор болсон гэнэ. Сая Австралиас ярьлаа. Тэгээд л баярлаад, хүнд хэлмээр санагдаад болдоггүй. Ямар сайндаа тахоёрлуугаа залгаж байхав- Өө тийм үү? Болж дээ. Эрдэм ном хөөхөөр ингэж л үр дүнд хүрч байгаа юм даа. Бага хүүчинь хаана байгаа билээ?- Эндээ энд. Хүнтэй суудаггүй нэг хүн. Намайг эргүүлдээд байж л байна. Уг нь санаагаарболдог бол нэг хүүхэн бараадаад надад ачийг минь үнэрлүүлвэл зүгээр байх юм. За, занайз нь тэгж байгаад дараа ярья гээд утас тасарлаа. Хөөрхий дөө, муу Анхмаа минь их лбаярлаж дээ. Овоо л доо. Хүү нь сургууль соёл гээд гүйгээд байсан гайгүй л яваа юм байнагэж бодоод эргээд суух гэсэн чинь нэг л болдоггүй. Тэгэхээр нь нэг даавуун тор бариад гарлаа. Гадаа барилгын дуу хадсан хэвээрээ. Нар ч

голлох маягтай. Манай байрны үйлчилгээнийхэн бүгд хаагаад нүү чихсэн тул эль хульхан. Аргагүй дээ, мөдхөн энэ байрыг нураах юм чинь эртхэн шиг нэг газар олж бизнесээ үргэжлүүлэхийг бодолгүй яахав. Дэлгүүрээс нэг дал дөрвөн өндөр авлаа. Өнөө орой нэгсайхан гурилтай шөл хийж иддэг хэрэг ээ.

\*

\*

\*

Намайг залгахад Анхмаа утсаа авч байна. Дуу нь ихээ сул байна шүү.- Чамд боломж байвал Сувдаа дээр нэг ирээч хө. Цаадах чинь чамайг өдөр болгон л сурах юм гэтэл их л зовиуртай дуугаар- Найз нь өнөөдөр амжихгүй нь ээ. Хэд хоногоос больё гэнэ. Гэнэтхэн уур хүрэв. Найз, найз л гэх. Яг цагаа тулахаар иймэрхүү үед ганц удаа ирэх нь байтугай ярих ч үгүй юм гэж бодоод утсаа аваад өрөөнөөс гарлаа. Сувдаагаас холдож байгаа ухаантай.- Чи одоо энэ хүн дээр нэг ирчихэд яадаг юм. Хэдэн төгрөг зээлсэн гэсэн тэрэндээ голцохиод байгаа юмуу? Авч болсон юм, өгч болох байлгүй гээд л би баахан аашилж өгсөн. Ямар ч авцалдаагүй мөнгө төгрөг гээд уурласан шалтгаан бол мэдээж өөр. Яагаад ч юмнадад Надмидтайгаа нийлж эдний охиныг авах гээд тэрнийгээ өөрөө хүсээгүй нөхөр нь хүсч буй мэт болгон надад жүжиглээд байгаа нь таалагдаагүй юм. Тэгээд л тэр өдөр Анхмаад уурлах шалтагаа нэгд ирэхгүй байгаатай нь, хоёрт мөнгөтэй холбосон хэрэг. Анхмаа утасны цаанаас уйлах нь л сонсогдсоноос өөр юм хэлсэнгүй. Би ч нэг их үнэнийг хэлчихсэн хүн гэж өөрийгөө бодно.- Удахгүй эмнэлэгт хэвгэнэ. Дараагийнхаа химийн тариаг хийлгэх ёстой гэж Сувдаад нилээн ойр байж, бүх юмыг нь мэдэж, асарч тойлж байгаагаа тодорхойлж хэллээ.- За мэдлээ. Би заавал очноо гээд утсаа салгалаа. Сувдаа- Юу гэж байна? Ирнэ гэнэ үү?- Ирэх нь ч ирнэ гэнээ. Гэхдээ өнөө маргаашдаа амжихгүй гэнэ. Дуу нь жаахан сулхан байна, яагаа юм бол? гэхэд Сувдаагийн харц илт буугаад явчихлаа. Тэр өдөр Хүслэн ирлээ. Ээжийгээ ч их санасан бололтой.- Та нь эдгэнэ гэсэн яасан бэ?- Удахгүй ээ, охин минь удахгүй Ээж охин хоёрыг үлдээгээд гарлаа. Учир нь намайг Сүхээ дуудаад болдоггүй. Сувдааг хараад ойрд гадагшаа гараагүй. Бага зэрэг уйдах ч аястай. Сүхээтэй хоёул гудамжааралхаж хуучин байраараа очлоо.- Сувдаагийн кафед орж үзэх үү? гэхэд тэр- Тэгье л дээ. Хоол ч идье. Кафед ороход ажилчид нь намайг таниад сүйд.- Бид гурав үргэлж энд суудаг юм.- Дандаа юу?- Тийм. Сувдаа энд, Анхмаа тэнд- Яг гадны хүмүүс шиг юм. Гадаадад бас хүмүүс нэг л ордог уушийн газраа орж, нэг уудаг

юмаа уудаг юм билээ. Би түүнд энэ байр танайхыг нүүж ирэхээс өмнө Сувдаагийнх байсантухай, Сувдаа хэрхэн өсөж том болоод хэрхэн энэ байраа өөрийн болгосон тухай товчхоньярьж өглөө. Сүхээ биширсэн янзтай толгой дохиж, хуучин гэрээ тойруулан харна. Тэгснээ- Чи бид хоёр аав ээжийн эзгүйд их тоглодог байж билээ. Нүдээ боогоод л . . . өөр тоглоомбайдаггүй л байсан юм байх даа гэхэд надад тэр үе нүдэнд зурайтал харагдав. Сүхээнамайг хурдхан барьж аваад л үнсэхийг боддог байсан байх. Би ч гэсэн дээ нэг их удалгүйбаригддаг байсансан. Тэрийг бодож байснаа би- Өөр тоглоом байсаан байсан. Чи тэнд байсан өрөөг санаж байгаа биз дээ? гээд унтлагынөрөө байсан буланг заахад- Тиймээ, тэнд л би чинийхээ хамаг нандин бүхний г авсан. Яалаа гэж мартахаа дээ.Одоогоороо санаж явдаг шүү гээд Сүхээ гараа явуулж миний гарыг атгав. Эр хүнд иймөнгө аясаар гараа атгуулна гэдэг ямар сайхан, сэтгэл хөдлөм болохыг ингэж атгуулжсуугаа бүсгүй л ойлгоно. Гэсэн ч би гараа угз татан авч- Үнэн юм уу? Нэг туулай тэврүүлээд л үлдээх чинь билээ. Амьдралд мартаж болохгүй юмгэж байдгийм шүү гэлээ. Сүхээ намайг гайхаж байгаа нь илт. Би тэр өрөөг бодоодөнгөрсөн бүхэнд Сүхээ ямар ч байсан буруутай юм шиг санагдана. Учир нь би өдийболтол эх хүн болж чадахгүй байна шүү дээ.- Ерөөсөө явцгаая гээд эрсхэн бослоо. Гэнэтхэн хувирч эвгүй аашилсанд Сүхээ гайхажбайсан ч би нүүр өгөлгүй шууд явсаар Сувдаагийн ирлээ. Хүнд хийсэн бүхэн нь эргэнирдэг гэгчээр Сувдаа ч гэсэн намайг ааштайхан угтлаа. Тэр Хүслэн гийн хоёр туулайтэвэрч авхуулсан зургийг үзэж суусан бололтой, хажууд нь байна. Намайг ороод ирэнгүүтХүслэн гүйж ирээд- Болороо эгчээ, Болороо эгчээ . . . нөгөө, нөгөө . . . Бүжин нь ганцаараа сууж чадахгүйбайна гэхэд нь түүнийг удаан гэгч нь тэвэрч үн сээд- Хүслэн миний дүү Бүжиндээ чи томоотой суу гээд эвтэйхэн зөөлөн хэлвэл тэр суудаг юмгэхэд Сувдаа ширэв татаад өрөө рүүгээ орлоо. Гэм хийсэн хүн шиг түүний араас сэмхэнгишгэсээр орвол тэр цаашаа хараад таг дуугүй- Найз нь хурдхан шиг нэг шөл хийчихье гээд эргэтэл- Хэрэггүй. Ер нь чи надад цаг заваа зараад хэрэггүй. Тэгж байснаас амьдралаа бодЦаашдаа амьдрах хүн- Яасан бэ? Сувдаа. Бие нь таагүй байна уу?- Чамд хүнтэй суух боломж гараад байгаа юм биш үү? Чи чинь хүнтэй сууж хүүхэдгаргахын бөөн хүслэн биз дээ? Манай хүүхдэд нэг л туулай байхад хангалттай гээд хоолойнь зангирав- Яагаад байгаа юм дээ? гэж цөхөрсөн өнгөөр асуухад- Өөрөөсөө асуу. Чи намайг нэг усан шөлөөр, энэ охиныг энэ чихмэлээрээ аргалж дөнгөнөгөж бодоод байна уу? гэж улаан галз уу хэллээ. Тэгтэл Хүслэн гүйж орж ирээд- Болороо эгчээ, нөгөө, нөгөө . . . Бүжин нь суучихсан гээд инээхэд Сувдаа- Чамайг хэн орж ир гэсийм? Миний нүднээс далд тогло, тэр туулайтайгаа. Ор цаашаа.Хүний туулай өгөөрэй чи. Би чамайг хүний юм авч бай гэж хэ лсэн үү? Айн? гэж Хүслэн

бид хоёрыг цочтоол хашгирлаа. Охины царай нэг хачин болж, ам нь өмөгнөөд гарлаа.Намайг- Сувдаа . . . гээд юм хэлэх гэтэл тэр огт сонсолгүйгээр яриаг минь тасалж- Би арай үхчихээгүй байна. Эцсийн шийдийг чи биш би гаргана гээд цэ эжээ балбахад ньнүднийх нь ухархай нулимсаар дүүрээд ирлээ.- Тайвшир даа. Тайван байхгүй бол наад бие чинь хямарчихна гэхэд түүний нүд хачинэвгүй болсноо- Чи үүнийг л хүлээж байгаа биз дээ? Тэгээд ч чи эмч хүн. Намайг хэзээ үхэхийг ч мэдэжбайгаа. Энэ чинь миний охин. Яс махаа уран байж би төрүүлсийм гэж багтран хашгирав.Би түүний хажууд байж тэссэнгүй. Гарахад араас- Тэр туулайгаа манайхаас аваарай гэж хашгирлаа. Харин одоо миний нүдний ухархайгаарнулимс яах ийхийн зуургүй дүүрээд ирлээ. Хурдхан ш иг л гармаар. Энэ бүхнийг сонссонболлолтой Хүслэн Бүжинг авчирч өгөв. Бүжингээ шүүрээд гараад иртэл хэсэгхэн салхиогцомхон үлээж орчныг хуйрагнуулаад намдав. Би гомдохын дээдээр гомдож байлаа.- Тиймээ, тийм. Чинийх . . . Чиний охин гэж хэлээд ам руугаа орсон нулимсыг залгижявсым. Үнэн үгний амт тийм гашуун байдгийг мэдэрч явсан даа.

\*

\*

\*

Цааш нь бичиж чадсангүй. Тэр үеийн сэтгэлийн зовлон одоо нүүрлээд байх шиг санагдаадтүр болихоор шийдлээ. Сэтгэл сэргээх гэсэн юм шиг өвгөн маань хонины ганц хаабарьчихсан орж ирлээ.- Махны үнэ гэдэг тойм алга. Байрны хэдэн хөгшчүүл нийлж ганц хонины гулууз хуваажавлаа. Өнөө маргаашгүй наадам болох гээд байдаг. Ганц хавирга ч болтугай буцалгажиднээ гэж байна. Өвгөнөө өрөвдөх шиг болов.- Урд нь бол бүтнээр нь аваад л болдог байсансан. Одоо ч ганц мөч аманд ч үгүй, хамарт чүгүй гэдэг л болох байхаа даа гэхэд- Хажуугаар нь ногоо гурил хийгээд болноо болно. Тэгээд ч одоо хүүхдүүд нэг их өөх махгэхээ больж. Энэ их мах иддэг үе биднээр дуусаж байгаа байлгүй.- За тийм ч байхаа даа. Үгүй, тэгээд хүүхдүүд бас жаал жуул юм дөхүүлэх байлгүй дээ.- Тийм дээ тийм. Ер нь ч тэгээд идэж ууна гэдэг ч нэг л хэрэг дээ гэж өвгөн маань хэллээ.Манай өвгөн тэгж байгаад их аятайхан дүгнэж хэлдэг юм. Нээрээ л бодоход, амьдралдидэж уух нэг л асуудал болохоос амин чухал юм биш шүү дээ.Би ширээндээ сууж чадахгүй эргэцсээр наадамтай залгалаа. Яагаад ч юм өвгөнийгөө л хэдхоног харж суув. Хөөрхий хүүхдүүдтэйгээ бужигнана. Бөхөө үзнэ. Эр хүн байхын идхавын тухай сэдэвтэй л бол юм болгонд дуртай. Хоёр хүргэн ганц шил виски өгснийгөдөр, өдөрт бага, багаар уун уусаар наадмын гурав хоногтоо дуусгав. Уусан үедээ шингэнцарай нь ухаа ягаан болчихно. Хааяахан над руу их эергүү х арчихаад

- Өвгөн нь ч жаргаж байна даа гэх. “Болоо доо өвгөн минь, чи минь л жаргалтай байвал” гэж би бодно. Өвгөн гэлтгүй надад ч гэсэн сайхан байлаа. Үр хүүхэд эрүүл саруул, идэж

уухаар дутахгүй л бол үүнээс илүү юм хүнд тэгтлээ хэрэг болох уу? Амьдралын сайхныг мэдрэхийн тулд хамгийн эхлээд амьд байх хэрэгтэй юм даа гэж бодлоо. Тиймээ, амьдбайх. Хэд хоног ойртоогүй өнөө бичих ажилдаа наадмын дараа орлоо. . .

\*

\*

\*

Сүүлд нь бодоход Сувдаагийн хувьд хэзээ мөдгүй үхнэ гэж бодох. Дээр нь ганц охиндоосанаа зовох, ерөөсөө амьдрал, хувь заяандаа гомдож цөхөрсөн цөхрөлөө надад гаргажбайгаа нь тэр юм билээ. Сэтгэл зүйн асар их дарамтанд орсон хүн тэгэхээс ч өөр яах билээдээ. Тэр шөнөө миний утас дахин дуугарлаа.- Болороо найз нь өвдөөд байна гэнэ. Би түүний дууг сонсонгуут түүнд гомдсон гомдолалга болов.- За найз нь одоохон . . . - Охин, охин . . . гээд үгээ гүйцээж чаддаггүй.- Санаа зоволтгүй. Тайван бай. Найз нь одоохон очно гээд Хүслэнг гэртээ түгжээд сэмхэнгарлаа. Шөнө дунд таг харанхуй. Энэ өвчин угаасаа шөнө дөлөөр өвддөг ёрын өвчин. Ямар юмаа хийж хажууд нь байхгүй энд ирдэг байнаа гэж өөрийгөө зүхэв. Сүхээ рүүзалгалаа нойрмог байна- Чи Сувдаагийнх руу шууд очооч. Би бас очиж байна- Тэгэлгүй яахав, одоохон Яарсан сандарсан үед уриалгахан үг сонсох хичнээн сайхан байдгийг хүн болгон мэдэхбиз ээ. Надад ч гэсэн сайхан санагдлаа. Сүхээ бид хоёр тэднийд зэрэг шахам ирцгээв. Сувдаа хүнд, хүнд амьсгаадна. Хурдхан шиг өвчин намдаах тариа хийгээд эмнэлэг авчявлаа. Эмнэлэг дээр очуут Сүхээг Хүслэнтэй үлдээлээ. Сувдаа- Найзынхаа тэр жижиг цүнхийг гэнэ. Тэр бас хэзээ ч хэвтэж магадгүй гээд ойр зуурынхаа юмыг бэлдсэн бололтой.- Ариун цэврийн хэрэглэл, бүх юм чинь байгаа юу?- Байгаа, байгаа. Тэр зураг гээд охиныхоо жаазтай зургийг авлаа. Эмнэлэгт яаран сандран ортол эмч- Одоо хөнгөвчлөх эмчилгээнд оруулахаас аргагүй болжээ гэлээ. Дотор палхийгээ дэвчихав. Эмч хүний хувьд би ойлгож байгаа юм. Түүнээс Сүхээ Сувдаа хоёр мэдэхгүй лдээ. Сувдаа бол өвчин намдаах тариа л бодож байгаа. Сувдааг хэвтүүлчихээд эмчтэй нь хурдхан уулзлаа. Эмч- Чи мэдэж байгаа шүү дээ. Дотор хавдар нь одоо томроод хамаг эрхтэнээ дарчихсан байгаа. Үндсэндээ зарим эрхтэн нь ажиллахгүй. Өнөөдрөөс морфинд оруулна. Ер н ьтэгээд уулзах ёстой хүмүүс байвал уулзуулаарай гэж эрсхэн хэллээ. Хөөрхий дөө, түүнд хэн ч байх билээ. Анхмаад л хачин дургүй хүрэв. Гэлээ гээд яахав. Хэлэхгүй л бол болохгүй. Анхмаад, мөн ажлынханд нь бас ирж уулзаач, байдал эвгүйтлээгэж хэллээ. Анхмаа удалгүй гүйгээд ирлээ. Би түүнийг “Үгүй ерөө цаг нь тулахаар иржбайх шив дээ” гэсэн харцаар угтсан бол Сувдаа “Ашгүй дээ, амжлаа” гэсэн янзаар хүлээж авсан юм. Одоо надад Хүслэнгийн талаар горьдох, найдах юмгүй болсон тул тэр хоёрыг горхихоор шийдсэн юм. Тэднийг надгүйгээр ярих зүйлээ чөлөөтэй яриг гэж бодоод- Найз нь гарчихаад ирье дээ гээд Анхмаад- Хорин минутын дараа энэ тариаг сувилагчид хэлээд хийлгээрэй. Өөрөө ч мэдэж байгаагээд гарлаа. Гэрт Хүслэн Сүхээ хоёр байгаа болохоор “хэсэгхэн хугацаанд ч гэсэн Хүслэнтэй хамт байя” гэж бодов.



- Болороо эгч ээ, нөгөө, нөгөө . . . Хүслэн нь Сүхээ ахтай нь хоол идсэн- Өө тийм үү? Ямар хоол?- Өндөг бас нөгөө каш- Оо ёо ёо, Сүхээ ах нь ямар мундаг юм. Каш чанадаг- Нөгөө, нөгөө . . . Бүжинг би бас санасан ш дээ- Чи бүр авч болно шүү- Нөгөө, нөгөө . . . ээж нь уурлана.- Одоо ээж нь уурлахгүй ээ гэж хэлэхтэй зэрэг миний нулимс урслаа. Сүхээ тэр хоёрхоёулаа гайхан харав. Сүхээ асуусан харцаар харна.- Үгүй ээ, үгүй. Чиний бодож байгаа биш. Гэхдээ л . . . Сүхээ миний мөрөөр тэвэрч, ар нуруун дээр зөөлхөн, зөөлхөн алгадна. Миний утасдуугарч би ухасхийн авлаа. Анхмаа байв.- Найз нь энэ шөнө сахиад хоноё доо гэнэ.- Тэгээ тэг гээд хариу ч сонсолгүй утсаа салгалаа. Яагаад би биш тэр гэж? Надад ялагдалмэдрэгдэж, гомдол, цөхрөл зэрэг сүлэлдэнэ. Дахиад утас дуугарахаар нь шууд авч- Бас юу гэсийн? гэж цухалдуухан хэлтэл Анхмаа биш Сувдаагийн ажлынхан байв. Тэд Сувдаагийн тасгийг асууж байна. Тэдэнд давхрыг нь өрөөтэй нь хэлж өгөөд- Та нар гарахаа дөхүүлээд эгчдээ хэлээрэй. Анхмаа эгч нь тэнд байгаа гэвэл- Бид нар өнөөдөр амжихгүй ээ. Маргааш очно. Гэлээ ч гэсэн бид уулзчихаад явахдаа хэлнээ гэнэ. Намайг хэрхэн тогтворгүй байгааг Сүхээ хөндлөнгөөс ажаад байгааг гэнэт мэдрэв. “Нээрээ, тэр манайд байгаа ш дээ”- Чи одоо яв гэж ширүүхэн хэллээ. Тэр- Яаралтай хэрэг болвол намайг дуудаарай гэхэд нь хариу хэлсэнгүй. Зөвхөн толгой л дохилоо. Түүнтэй ярих ч дур хүрэхгүй байв. Хүслэн- Сүхээ ах нь явж байгаа юм уу?- Тиймээ, Хүслэн- Нөгөө, нөгөө . . . Сүхээ ах нь энд байдаггүй юм уу?- Байдаггүй юмаа. Тэр одоохон явна. Сүхээ ч удалгүй явлаа.

\*

\*

\*

Нэг мэдсэн чинь миний хуруу хүртэл хөшчихжээ. Цаг харвал их орой болж. Өвгөнийхөө хажуугаар орж хэвтлээ. Тэр түмэн үрчлээт гараа цээжин дээрээ тавьсан байх юм. Ингэжунтахаараа зүүдэлдэг гэдэг тул гарыг нь зөөлхөн буулгалаа. Тэр мэдсэнгүй. Би унтахаасаа өмнө үргэлжлүүлэн бодлоо.

\*

\*

\*

Хүслэнд үлгэр уншиж, зүүрмэглээд ирэхээр нөгөө дуугаа аялан унтууллаа. Эх хүн байх, тэр тусмаа хүүхдээ бүүвэйлэх гэдэг ямар сэтгэл уярам байдгийг мэдрэх шиг. Харин бибараг унтаж чадсангүй. Яагаад гэвэл хацраа бумбайлган унтаж байгаа энэ охин хамгийн сүүлчийн өдрөө надтай хамт байгаа байж магадгүй. Одоо тэд тариан завсраа, охиноо яаж өгч авалцахаа ярилцаж байгаа. Амь гэдэг хором мөч бүрээр Сувдаагаас минь холдож байгаа. Ээ, Сувдаа минь, Сувдаа минь ямар гээчийн гай дайрчих нь энэв дээ гэж Сувдааг нэг бодовч, яагаад чи намайг нэг нүдээр үздэггүй юм бэ? Энэ өвчний сураг сонсогдсоноос хойш би л чамд хамгийн ойрхон байсан шүү дээ. Үнэн сэтгэлээсээ чамд туслахыг хүсч

байсан. Тусалж ч байгаа. Охиныг чинь авахын тулд биш ш дээ. Зүгээр л найзын хувиар, хүний ёсоор тусалж байгаа. Би хүүхэдтэй болохыг хүсдэг. Чи үүнийг мэдэхийн дээдээрмэдэж байгаа. Ингэж бодоод аньсаган завсраар урсах нулимсаа арчлаа. Өөрөө өөрийгөөороосон бодолдоо боомилогдон байв. Тэдэн рүү утасдмаар, ямар нэгэн худлаа шалтагхэлээд залгамаар санагдана. Тэгэвч чадсангүй. Унтах гэж хэвтлээ. Миний хажууд Хүслэнбулцгар гараа дэрлээд хамар нь шуухитнан унтана. Түүнийг өрөвдөхийн дээдээрөрөвдөнө. Ямар хэцүү орчлон бэ . . .

\*

\*

\*

Хамраа тачигнуулан хурхирах өвгөнөө тохойгоороо ёворлоо. Тэр амаа тамшаалан ямарнэгэн юм шивнээд цааш эргэв. Үсээ засуул гэж хэлэхгүй бол муу буурал үс нь жигтэйхэнургачихаж гэж бодлоо. Нэг мэдсэн чинь унтжээ. Өглөө эртлэн босов. Учир нь урд шөнөбодсон бүхнээ бичих гэж яарсан хэрэг. Анх удаа би барилгачидаас түрүүлэн шуудширээндээ суув.

\*

\*

\*

Маргааш өглөө нь босонгуутаа тэсвэр алдан Анхмаа руу залгатал тэр утсаа авсан хэрнээцаашаа ярих нь сонсогдоно. Тэд инээлдэж байв. Анхмаа- Тэгье л дээ. Би тэр нотариатчийг дуудчихъя. Танай кафены хажуугийн хаалга бил үү? гэснээ сая нэг юм наашаа анхаарч- Байна уу? Болороо юу? гэв. “Бүр нотариатчдаа тулчихсан байх шив дээ” гэж бодсон би юу гэхээ мэдэхгүй хэсэггацсанаа тасалж орхилоо. Зүрх гэдэг цээжиндээ багтахгүй дэлсэнэ. Надад ярих тэнхэлбайсангүй. Утас эргээд хангинав. Дэлгэцэнд нь “Anhmaa” гэсэн нэр гарна. Би авсангүй. “Тэд инээлдэж байсан” гэж бодохоор л гол зурна. Би баахан бөглөр ч суугаад, Хүслэнгцэцэрлэгт нь хүргэж өглөө. Яагаад ч юм Хүслэнг сүүлийн удаа үнсэж, сүүлийн удаахүргэж өгч байгаа юм шиг санагдана. Энэ өглөө надад машины чимээ, шувуудын жиргээ, навчисын сэрчигнээн аль алиныг нь сонссонгүй. Зөвхөн Хүслэнг л ширтэж байл аа. Ингэжтэгсээр байгаад бас хоцорчихож. “24 - ийн цэцэрлэг” гэсэн хаягтай байшингийн хаалгыгдахиад л нүдлээ. Цэнхэр халаадтай бүдүүн эмэгтэй багш хаалга онгойлгоод- Долоо хоногт ганцхан өдөр авчирч өгч байж та нар хоцроохгүй байж болохгүй нь үү? гэхэд Хүслэн-Багшаа, манай ээжийн нуруугаар өвдөөд . . . гээд ярих гэтэл багш нь охиныг татажоруулаад хаалга хаагдав. Намайг нэг амьсгаа аваад эргэтэл хаалга дахин нээгдэж багш нь- Хүүхдийнхээ хоолны мөнгийг өгөөрэй гэж хахир дуугаар хэлээд хариу хэлэхийнзавдалгүй хаалга дахин хаагдав. Хаалганы цаана- Муусайн баячууд хүүхдийнхээ хоолны мөнгийг ч цагт нь өгчихгүй гэх багшийн дууссонсогдоно. Хүн хүндээ ямар дээрэлхүү юм дээ гэж тэгэхэд бодогдсон. Одоо энэ охинөнчрөх юм бол . . . гээд цааш нь бодохоос аймшигт ай санагдаад больчихлоо. Хүслэнг өгчихөөд шууд эмнэлэг явах гэсэн бас л чадсангүй. Юу ч юм нэг юм минийөмнүүр хөндөлсчихөөд болж өгөхгүй юм. Эв нь таарвал би уйлах гээд л байх шиг байна. Намайг дуудтал нь байж байя гэж өөртөө шийдвэр гаргалаа. Гэртээ очво л нэг л

хонхиоргиод болохгүй. Хэвглээ, бослоо, усанд орлоо, зурагт асаалаа, унтраалаа . . . Байн, байнутсаа ширтэнэ. Хорвоо дээрх хамгийн тамтай өдөр тэр л байх гэж одоо бодогдоно. Яг

үнэндээ энэ бүх хугацаанд Сувдааг яаж байгаа бол? гэж санаа зовсон гэх ээсээ илүүтэй ,Сувдаа охиноо яахыг хэрхэн шийдэж байгаа бол? гэсэн бодол миний санааг зовоож байсангэвэл болно. Хүн гэдэг тийм л байдаг юм билээ. Одоо би юуг нь нуухав дээ. Зөвхөн энэбодлынхоо төлөөнөөс ямар нэгэн нүгэл үүрэх ёстой бол үүрэхээс яахав.Гэтэл ашгүй нэг юм утас дуугарлаа. Би ч юманд цохиулсан юм аятай ухасхийн авлаа.Сувдаагийн ажлын тогооч байв.- Сайн уу? Болороо эгчээ, Бид нар ирээд явлаа. Яанаа Сувдаа эгч ямар аймаар болчиховэ? Бид нар ерөөсөө ийм байгаа гэж бодоогүй гэж байна. Энэ яриа надад нэг их сонинсанагдсангүй. Тэгсэн хэдий ч- Харин тийм ээ. Хэцүү л байна. Анхмаа яасан бэ? Яагаад над руу ярихгүй байна? гэтэл- Биднийг ирсэн чинь Анхмаа эгч гараад явсан. Харин сая биднийг гарах гэж байхадАнхмаа эгчийн нөхөр нь ирж байсан. Бодвол тэр хоёр ээлжээ сольсон байхаа гэлээ.Би энэ үгийг сонсоод тархин дундуураа татуулчих шиг л болов. Үг ч хэлж чадсангүй.Зүгээр л санаа алдлаа. Надад одоо элдвийг бодох тэнхэл ч алга. Би ядарчээ. Зүгээрцөхөрчихөж.Утас дахиад л дуугарлаа. Харвал дэлгэцэнд “Нuuгhун huu” гэж гарав.

Утсаа таслав. тэр дахиад залгав . . . Таслав . . . Залгав . . . Тэсэхээ байгаад, утсаа авангуутаа- Чи яах гээд байгаа юм бэ?- Хэ хэ, та жаргахгүй юм уу? Надад мөнгө хэрэг болоод . . . - Битгий хуц. Дахиад залгаад үзээрэй. Тэгвэл чиний тухай сургуульд чинь бүгдийг ньдэлгээд түмний шившиг болгоно шүү муу биеэ үнэлэгч минь гэж хашгирлаа. Дүүд . . . дүүд . . .Утас дахиад л дуугарлаа. Авахгүй тэсээд байлаа. Дуугараад л байна. Харвал “Suhee”байна. Би утсаа аваад л чимээгүй уйлж гарлаа. Бүр цурхирлаа.- За тайван байгаарай. Одоо нэгэнт . . . бид нар мэдэж байсан юм чинь . . . тайван бай . . .Тэр Сувдааг өнгөрчихлөө гэж бодсон нь илт.- Үгүй ээ . . . би гэртээ байна . . . дахиад л уйлав.Нэг мэдсэн чинь Сүхээ манайд ирчихсэн байлаа. Би нулимсаа урсган байж сэтгэл дотрообайсан хамаг бүхнээ ярилаа. Хамгийн сүүлд тэр гурав охиноо хэрхэн өгч, авалцаж байгааг.Одоо Надмид Сувдаа дээр ирсэн байгаа. Анхмаагаар нотариатчийг дууд уулсан гээдбүгдийг давхцуулан байж яриад- Энэ бүгд чамаас болж байгаа юм. Чамаас . . . чамаас . . . Чи л намайг үргүй болгосон гэжхашгираад тамир муутай гараараа түүний том цээжийг хэд балбасан болж цурхирлаа.Үүнээс илүү би яах юм бэ? . . .Сүхээ харин хаа очиж нэг ч үг хэлсэнгүй. Хэрвээ ганц үг хэлсэн л бол би галзуурах байлаа.Тэгээд нэг юм хэсэг тайвширч, нилээн удаан чимээгүй сууцгаалаа. Над руу утасдалгүйбараг үдийн хойно болгочихлоо. Одоо би тэдэнд хэрэггүй бололтой. Сая л нэг амьгаа авчсанаа алдаад- Одоо л нэг гайгүй боллоо. Яая гэхэв дээ Сүхээ минь. Би ийм л хувь тавилантай юмбайлгүй. Орчлон надад өгөхгүй юмаа өгөхгүй юм байна. Гэхдээ надад хүн чанар гэж нэгюм бий. Би найзыгаа эцсийн замд нь найз шиг нь үдэх болно. Би эмч хүн. Гэхдээ эмчиддийлддэггүй өвчин гэж байдаг юм. Баатарт ч гэсэн үхэл ирдэг шүү дээ гэж хэлээд биеэчангаллаа. Тэгээд- За, за ингэсгээд эмнэлэг явья гэхэд Сүхээ сая нэг ам нээж- Чи одоо л нэг эргээд Болороо боллоо гэв. Намайг сэтгэлээр дэмжиж байгаа нь тэр. Тэгтэл

утас дуугарлаа. Дэлгэцэнд нь миний өчигдөр орой, өнөөдөржи н хүлээсэн хүний нэрбайлаа. Тэр бол “Suvdaa”- Миний найз хаачиваа? Хүслэнг хүргээд өгчихсөн биз дээ?- Тэгсээн Сувдаа. Тэр цэцэрлэгтээ байгаа.- Чи хүрээд ирээч. Би ганцаараа болох нь- Өө тийм үү? тэгэлгүй яахав. Би одоохон.Сүхээ бид хоёр давхиж о члоо. Яг тасгийнх нь үүдэнд ирээд сэтгэлээ чангалж уртаарамьсгаа авахад Сүхээ мөрөн дээр минь зөөлхөн алгадаж зоригжууллаа. Биднийг ороходнэгэн эрэгтэй хүн- За ингээд бүх юм боллоо. Хурдан эдгэрч надад үнэгүй хоол хийж өгөөрэй гээд гарав. Энэбол нотариатч байлаа. Миний хүсэл мөрөөдөл нэгэнт өнгөрчээ. Яагаад ч юм доторхөнгөрчих шиг. Одоо надад хямраад, бачуураад байх юм нэгэнт үгүй болжээ. Тэгээд чминий хүүхэдгүй байх нь миний л хэрэг. Энэ хүн хүүхдээ хэнд үлдээх нь энэ хүний лхэрэг шүү дээ.Харин найз минь нүдэн дээр минь муудаж, өдөр хоног биш хором мөчөөр охиноосоо, энэамьдралаас, биднээс холдож байгааг мэдрэх хэцүү байлаа. Өөрөө ч гэсэн өрсөх гэж,бүхнийг амжуулах гэж суугаа нь энэ шүү дээ зайлуул. Сувдаагийн царай ядрангуй, нилээншарлаж ногоорсон харагдана. Тэр өвөр дээрээ байгаа дугтуйгаа дэрэн доогуураа хийгээдих л хөнгөнөөр- Өө, Болороо хүрээд ирэв үү? Би чамайг өглөөнөөс хойш яачихваа гэж бодож байсан юм.Чамайг харалгүй их удах шиг боллоо гэснээ хойшоо налан хагас суугаа байдлаар хэвтлээ .- Чи яаж байна? Жаахан ядраа юу даа?- Сүүлийн энэ нэг хоногт чухам юу болоод өнгөрөв дөө бүү мэд. Охин маань гайгүй юу?- Өнөө өглөө цэцэрлэгтээ явсан. Нааш нь нэг авчрах гэснээ арай л төвдсөнгүй.- Ээ, аваад ирэхгүй дээ. Ухаантай байгаа дээрээ охиноо нэг үнсчихмээр байна.- Сүхээг явуулчих уу? Хүслэнг аваад ирэг . . . гэхэд- Тэгээч Болороо. Чөлөө авчих гээд амьсгаадлаа. Сүхээ надаар хэлүүлэлтгүй гараад гүйлээ.Сувдаа дэрэн доогуураа гараа шургуулж том дугтуйг арай гэж гаргаж ирээд надад өглөө.Би гайхаж- Сувдаа, би үүнийг яах ёстой вэ? Анхмаад өгөх юмуу? гэтэл- Дээр нь биччихсэн байгаа. Харвал “Дараа нь задлаарай” гэсэн байв.- Анхмаадаа битгий муу юм бодоорой. Цаадах чинь энэ бүхэнд буруугүй гэв. Доторчичрээд л явчихлаа. Тэр түүнд охиноо өгсөн юм байна гэдэгт би бүрэн итгэлээ. Дараа ньгэдэг нь юү гэсэн үг юм бол? Юуны дараа гэсэн үг байх билээ? Өөрийгөө өнгөрсний дараагэж байгаа юм байна гэж ойлгосон хэдий ч лавлаж асууж хэрхэн чадах билээ. Хий дэмий лтүүн рүү харвал тэр “Тиймээ тийм” гэх шиг н үдээ алг уурхан анивчлаа. Хоёр нүднээснулимс урсаад ирэв. Түүнд харуулахгүй гэсэндээ дугтуйг тэвэрсэн чигтээ цонх руу эргэжхарлаа.“Охиноо тэдэнд өгсөн юм байна. Нотариатчаар батлуулсан баримтаа надад өгнө гэжбайхгүй баймаар. Охиндоо захиас үлдээсэн бол надаар дамжуулахгүй нь мэдээж. Хариняагаад надад охиноо өгөөгүй учраа тайлбарлаж уучлалт гуйсан захиа л байж болох юм”гэж би бодож зогсов. Тэрнээс зайлахгүй. Мэдээж дугтуйг нээх хүсэл хязгааргүй их байвчби өмнө нь нээхгүй. Өмнө нь гэдэг нь түрүүний дар аа нь гэдгийн эсрэг утга шүү дээ.Ашгүй Сүхээ нэг их удалгүй Хүслэнг дагуулаад ирлээ. Хүслэн орж ирүүтээ- Ээжээ, ээжээ . . . Би нөгөө, нөгөө . . . концертонд дуу дуулна. Нөгөө . . . нөгөө . . . ээжийнбүүвэйн энэ дуу . . . гэдэг таны дандаа дуулж өгдөг дууг

- Өө тийм үү? Ямар мундаг охин бэ? Миний охин дандаа дуулж яваарай- Дандаа концерт болдог юм уу?- Тийм, тийм. Дандаа болдог юм- Ээжээ би нь нөгөө, нөгөө . . . Болороо эгчийн туулайгаар тоглохгүй байгаа- Одоо миний охин тоглож болно. Алив нааш ир. Ээж нь чихэнд үг хэлье. Энэ чи бидхоёрын нууц шүү гэхэд Хүслэн хэвтэж байгаа ээжийнхээ аманд чихээ наалаа. Сувдаа юу ч юм хэлж, Хүслэн- За . . . за . . . гэж толгой дохиж, бас завсраар нь намайг үе үе харна. Би яриаг нь сонсохгээд байгаа юм шиг анаад байлтай биш гэж бодоод тэр хавийг янзалсан болов. Сүхээнамайг ойлгоод байгаа бололтой харцаараа надад дэм өгнө. Сувдаа- Миний охин хэзээ ч битгий мартаарай- За . . . - Заа, ээж нь охиноо үнсье гээд удаан гэгч нь үнслээ. Сувдаагийн шанх даган ганц дусалнулимс урсана. Сая харах нь ээ түүний санчиганд буурал орсон байлаа. Тэгээд Сувдаа- Одоо миний охин Сүхээ ахтайгаа яваад гэртээ байж бай гэж эрсхэн хэлэв. Сүхээ Хүслэнхоёр гарахаар явтал Хүслэн эргэн гүйж ээждээ дахин үнсүүлээд- Ээжээ, та хурдан зүгээр бо лоорой гээд эргэцэн, эргэцэн гарлаа. Хаалга хаагдсаны дарааСувдаа хамаг биеэ сул тавьж амьсгаадав. Тэр их хүчилж байсан бололтой. Сувдаа- Найз нь хэзээ ухаан алдах вэ? Болороо гэж тэр нилээн нухацтай гэхээсээ илүү хэзээухаан алдахаа хүлээж буй байдлаар асуулаа. Намайг яг таг мэдэж байгаа гэж тэр бодсонбайх. Би мэдэж байсан хэдий ч түүнд төдийд, өдийд гэж хэлж чадсангүй.- Гайгүй дээ. Тэгэсгээд үдээс хойш Хүслэнг дахиад аваад ирье гэлээ. Сувдаа намайг харжгунигтай нь аргагүй инээмсэглэснээ “нааш ир” г эж гараа над руу сарвайв. Түүний гарыгатгавал хурууны үзүүрээс бусад нь бүлээн байв.- Болороо, би чамд үргэлж итгэдэг гэлээ. “Намайг эмчлээрэй гэж байна” гэж би ойлгов.Даанч найз нь дийлэхгүй өвчний өмнө яаж ч чадахгүй юм даа гэж бодоод “Сувдаа миньнамайг уучлаарай” гэж хэлэх гэснээ арай чадсангүй. Дуугай л аргаа барсандаа доошоохарлаа. Сувдаа миний гарыг элгэмсүү зөөлхөн алгадаад- Бүх юм сайхан болноо Болороо минь гэв. Уг нь энэ үгийг би л хэлж баймаар. Би дугтуйруу харц шидээд- Тиймээ, Сувдаа минь бүх юм сайхан болно гэлээ. Энэ бол тэрний сонссон сүүлийн үгбайлаа. Сувдаа маань тун удалгүй шоконд орж ухаан алдлаа. Тэр дахиж сэрсэнгүй. Тэрдахиж охиноо үнсээгүй. Тэр минь нүдээ ч нээлгүй гурав дахь хоног дээр хорвоог орхилоо.Хэн нэгэн ирлээ ч, хэн нэгэн явлаа ч энэ орчлон бахь байдгаараа л байж байдаг нэгэнбодлын хаашаа ч юм дээ гэмээр. Гэхдээ иймдээ ч сайхан байдаг байж болох юм.Сувдаагийн маань ажил явдалд нэг их олон ч хүн ирсэнгүй. Кафены ажилчид, Сүхээ, би,аан бас нотариатч ирсэн юм байна. Анхмаа нэг их том нарны шилтэй, маск зүүчихсэнирээд, яагаад ч юм надтай ч нэг их юм ярилгүй яваад өглөө. Би яахаа мэдэхгүй байлаа. Ёсюм болохоор Сувдаагийнхаа зургийг гэртээ авчирч тавьлаа. Хүслэндээ бүгдийг хэлжойлгуулсан.- Ээж нь бурхан болоод тэнгэрт явчихсан. Чамайг тэндээс харж байгаа- Ээж нь ирэхгүй юм уу? Би яах юм бэ? гээд уйлсан. Тийм жаахан зүрх тэгтлээгашууддагийг би анх удаа мэдэрч билээ. “Хүүхэдгүй хүн гэдэг хорвоогийн тэн хагасыгхардаггүй юм байна даа” гэж анх удаа бодсон доо. Миний бо дсон үнэн байхаа . . .

\*

\*

\*

Би бичиж буй, бодож буй, дурсаж буй зүйлийнхээ хамгийн хүнд хэсгийн ард нь гарчбайгаага мэдэрч байлаа. Надад энэ хэсгийг даван туулах ямар хэцүү байсныг өвгөн мааньсэтгэлээрээ мэдэрч байх шиг санагдсан. Яагаад гэвэл тэр энэ хорвоо дээрх намайг бүрэндүүрэн ойлгодог ганц хүн байв. Хүнийг үнэн сэтгэлээсээ хайрлахаар тэгж ойлгодог байхгэж би боддог юм. Хүүхдүүд маань бид хоёрын шинэ байр баригдт ал байх байрны тухайярьж байсан үе.Наадмын дараа намар гэдэг шиг зуны халуун цаагуураа намсаж, сэр сэр салхи нэмэгдсэнбайлаа. Моддын навчис хүртэл байдгаараа томорч, харлаж ногоороод хөгшрөх янзандааорчихож. Сонин юм шүү хүний сэтгэл гэдэг. Нэг юм руу шунаглаад орчихоороо орчноо чанзааралгүй хэдэн сарыг ч өнгөрөөчихсөн байх жишээтэй. Миний хувьд тийм л зун өнгөрчбайгаа юм байна.

\*

\*

\*

Надад бүх юм хоосорчихсон юм шиг мэдрэмж төрнө. Сувдаагийн ажил явдлаас хойшнилээн хэд хоносон ч Анхмаа Надмид хоёр яриагүй, ирээгүй байлаа. Тэднийг ирж Хүслэнгавах байх гэж бодно. Гэтэл байдаггүй. Гэхдээ тэр хоёр луу утасдаж бас чаддаггүй. Шуудирээд л Хүслэнг аваад явчихвал бас яах юм. Дугтуйг яагаад ч юм би ганцаараа задлахёсгүй юм шиг бодогдоод болохгүй.- Чамд л өгсөн юм чинь чи л задлах ёстой гэж Сүхээ надад хэлсээр байлаа.Тэр орой Хүслэн хоёр туулайгаа тэврээд унтлаа. Сүхээг дуудлаа. Ядаж тэр миний хажуудбайг гэж бодов. Тэгээд өвөр дээрээ том дугтуйг гаргалаа. “Дараа нь задлаарай” гэсэн бичигхарагдана. Одоо сайн харвал хөөрхий минь их л хүч гарган байж бичсэн бололтой их лчичирхийлсэн харагдана. Дугтуйн дотор гар утас шиг нэг бондгор юм байх юм. Задлахгэсэн нэг л эвгүй.- Намайг задлаарай гэсэн үнэн биз дээ? гэж Сүхээгээс өөрийгөө зоригжуулах гэсэндээлавлан асуулаа. Тэр миний мөрийг зөөлөн цохиж байна. Тэгээд амьсгаагаа нэг гүн аваадзадаллаа. Тэндээс юу гарч ирсэн гэж санана . . .

\*

\*

\*

Том охин маань хоёр сүү, нэг уут боов барьчихсан сүр сархийсээр орж ирэв.- Ээж, аав хаачаав?- Мэдэхгүй л дээ. Ойрхон гараа байлгүй. Гадаа, сүүдрэвчинд алга уу?- Аан, би та хоёрыг байлгах байр олчихлоо. Түр ээс нь хямдхан юм.- Яахнав дээ. Танай хоёрын нэгнээр л байвал болох биз. Тэгж мөнгө үрж яадаг юм. Эртээрдүү чинь манайд бай гээд байсан- Өө тэр бүтэхгүй. Хүүхдүүд шуугилдаад та хоёрыг амраахгүй. Тэднийх бол бүр бүтэхгүй.Дэжигнүүлээд өгнө. Ямар мэдэхгүй биш. Цаадах чинь та хоёроор хүүхдүүдээ харуулахгээд л тэгж байгаа юм. Манай Сувдаа нээрээ . . . гэснээ хэлэх үггүй мэт толгой сэгсрээд- За, за ээж би явлаа. Цайны цагаар явж байна. Үнсье гээд өөрөө ч үнссэн юмгүй надаарүнсүүлчихээд гараад өглөө.“Үгүй энэ маань салхи шуурга шиг юу болчихов доо. Гайгүй л тайван хүнсэн. Нээрээ чбодохноо том охины зөв шиг” гэж бодоод эргэж суулаа . . .

“Өөрийн ганц охин Хүслэнгээ хамгийн хайртай найз Болороодоо үрчилж үлдээснээгэрээслэв” гэсэн байв. Би нүдэндээ итгэсэнгүй. Нотариатчийн тамга ч харагдах шиг. Сувдаагийнхаа зургийг тэврээд уйлж гарлаа. Ийм юм гэж байдгаа бас . . . Еэ, тэнгэр минь гэж . . . Бурхан минь гэж . . . сад тавьсан нулимс маань усаж, эрүүнээс дусалж байсныг чмэдэлгүй нэг хэсэг л уйлж суулаа. - Баярлалаа Сувдаа минь, баярлалаа. Би охиныг чинь хүний зэрэгтэй хүн болгоно. Нүднийхээ цөцгий мэт хайрлана. Би амлаж байна гээд л өөр юу юу гэсэн юм бүү мэд. Үглээд л, амлаад л, Сүхээг тэврээд л уйлаад байлаа. Энэ бол өөрийгөө бодохоор баярын, Сувдаагаа бодохоор харамслын уйлалт байсан юм. Энийг нь эртхэн мэдсэн бол би хамгийн сүүлчийн үгээ арай өөр үг хэлэх байсан юм. Энэ амлалтаа түүнийг ухаантай байхад нь амлах байсан юм. Юм гээч яагаад ингэж өнгөрсөнхойно хоцорч ойлгогддог байнаа. Хорвоо гэдэг хожимдож ухаарахын харууслаар дүүрэнбайдаг ажээ. Хэсэг тайвшраад дугтуйгаа дахиад үзвэл бас нэг цаас гарч ирсэн нь кафегаа охиндоо үлдээсэн гэрээслэл байлаа. Тэгэлгүй яахав дээ. Тэрний төлөө л өөрийгөө эмчлүүлээгүй юм чинь. Мөн дотроос нь ганц нэг ээмэг зүүлт, мөн цаг үргэлж барьж явдаг дуу хураагч нь гарч ирэв. Энийг би бүр мартчихсан байв. Болороод гэсэн зурвас гарч ирлээ. Энийг би унших эрхтэйгээ батлах гэсэн шиг Сү хээ рүү дахин харав. Тэр харцаараа зөвшөөрч байна. *Болороод Найз минь. Яаж ч болохгүй хорвоогийн тавилан гэж байдаг юм байна. Би чамд сүүлчийнүгээ захиж байна. Аливаа бүхэн сүүлчийнх байна гэдгийг мэдрэх их сонин юм. Сүүлчийн үг, сүүлчийн захиас, сүүлчийн уулзалт ийм байгаа юм чинь надад хамгийн сүүлд харагдах зүйлтэр ч байтугай сүүлчийн амьсгаа хүртэл их л сонин байх байхаа. Ялангуяа ганц охиноосүүлчийн удаа харцандаа үлдээх ямар хэцүү байх бол? Гэхдээ тэртээх ор мөргүй хоосонертөнцөд охиноо инээсэн чигээр нь харж явахын тулд би хичээх болно. Найз нь өөрийгөө явцгүй болчихож гэдгээ тэр нэг өдөр эмчээс сонссондоо биш, чамайг манай кафены гадааирчихээд орж чадахгүй эргэлдэж, над руу “Өнөөдөр очиж чадахгүй нь ээ” гэж утсаархэлэхэд чинь бүрмөсөн итгэсэн юм шүү дээ. Би чамайг цонхоороо хараад зогсож байхдаа “Би чинь ийм л найзтай шүү дээ” гэж бодож, чиний сэтгэл хэрхэн зовниж буйг ойлгож байсан юм. Найз нь өнгөрсөн амьдралдаа өөрийгөө зовсон гэж бодохгүй байна. Гэхдээ амьдралын төлөө бусдаас илүү, магадгүй чамаас ч илүү тэмцсэн гэдгээ сайн мэддэг. Чи чмэднэ. Даанч үр дүнд хүрсэнгүй. Яалт ч үгүй хувь заяаны төөрөгт ялагдаж байна. Яаж ч хичээгээд хүч хүрэхгүй хувь тавиланг би яалтай билээ. Миний өмнө өглөө оройгүй зурайхтэр нарийхан цагаан жимээр би явах л ёстой юм шиг байна. Түүний цаана юу гээч ньнамайг хүлээж байгааг бас мэдэхгүй. Амьдралд хоргодох юм ганц охин минь л байна. Одоояа гэхэв. Би яаж ч цахлаад энд, охиныхоо дэргэд үлдэж чадахгүй нь. Тийм болохоор би алгын чинээхэн ганц охиноо хамгийн хайртай найздаа ихийн их итгэл найдвар тээнүлдээж, “Миний охиныг хүний дайтай хүн болгож өсгөж өгөөч гэж бас гуйж байна” Бихэрийн юмыг энэ амьдралаас гуйж яваагүй. Одоо л . . . Энэ эцсийн мөчид ганц охиныхоотөлөө гуйж байна. Болороо минь, миний төлөө хичээгээрэй. Энэ миний сүүлийн үг шиг санагдаж магадгүй. Гэхдээ найз минь чамайг насан туршдаа миний энэ гуйлтыг сонсож явах болно гэдгийг мэдэж байна. Болороо минь, би чамд үргэлж итгэдэг Сувдаа нь . гэсэн байлаа. Би захиа бичсэн цаасан дээр нулимсны ганц ч толбо хараагүй юм шүү. Тэгэхээр манай Сувдаа үнэхээр чанга эмэгтэй байсан байгаа биз. Харин миний нулимс л сул асгарч байлаа. Сүхээ миний нурууг зөөлөн, зөөлөн илнэ. Намайг тайвшруулж байгаа*



нь тэр. Би дуу хураагчийг нээх гэснээ Сүхээ рүү харвал Сүхээ санаа нь з овсон янзтай- Би гал тогоонд байж байя гэхээр нь- Үгүй ээ, үгүй. Чи энд байж болно гээд түүний гарыг атгав. Дектафон жаахан шажигнаж байснаа. . . Хоол хийхэд хамгийн амт оруулдаг зүйл бол сэтгэл . . . гээд цааш нь баахан хоолныжор, хоол хийх заавар явав. Түүнийг чагнаж хоолоо хийдэг байсан бололтой. Сувдаагийндууг сонсоход тийм ч амар байсангүй. Хөөрхий минь яг дэргэд байгаа юм шиг цовоосэргэлэн тэр л хэвээрээ. Тэгээд цаашаа сонслоо. . . Болороогийн эрчүүдтэй харьцдаг харьцаа надад таалагддаггүй. Ти йм зуршил эмэгтэйхүнд байх нь бусдад тийм ч сайхан сонсогдохгүй байгааг Болороо өөрөө мэдэрдэгүй юмбайх даа . . . . .

Анхмаагийн гэр бүл маш халуун дулаан гэр бүл байхаа. Анхмаа ч гэсэн аливаадхандахдаа нэг л сайхан юм. Яг манай ээж шиг . . . . . Анхмаагаас өнөөдөр арван сая төгрөг зээллээ . . . . .

Охин маань 24 - ийн цэцэрлэгт дургүй болж эхэллээ. Өдрийн ангид оруулна гэхээр энэкафеныхаа ажлыг яах вэ? За яахав. Кафегеа өөрийн болгочихвол охиноо заавал өдрийнангид оруулнаа . . .хөөрхий минь охиныхоо төлөө л амьдарч байсан нь илхэн. Цааш нь чагнавал. . . Ааваа, ээжээ та хоёр охиноо харж байна уу? Өнөөдөр охин нь төрж өссөн гэрээбуцаагаад авчихлаа. Та хоёр минь надаар бахархаж байгаа гэдэгт итгэж байна . . . . . Би өвчтэй болчихож. Найдваргүй. Удахгүй юм гэнэ. Муу охин минь яанаа (уйлав) . . . . . Охиноо хэнд үлдээх вэ? Болороо асрамжийн газрын тухай ярьлаа. Яагаад ч асрамжийнгазар үлдээхгүй . . .гэх мэтээр сонсож байтал гэнэт эрэгтэй хүний хоолой орж ирлээ. Би энэ сонссон хэсгээбүхлээр нь бичихийг хичээе. Яагаадыг уншсан хүн ойлгох биз ээ. Надмид эмнэлэг дээрирсэн үе байлаа. Эхлээд Надмидын нялуун дуу гарч баахан юм ярьж байснаа

Надмид. . . Цаадах Анхмаа чинь ичдэг үү, нэрэлхдэг үү ямар ч байсан та нарт хэлдэггүй юм. Үгүй,тэгээд бид 2 хоорондоо ярьж байгаад танай Номинг . . .

Хүслэн

.

.

Сувдаа.

НадмидАйн? . . . Аа, тийм л дээ. Хүслэнг өргөж авдаг юм билүү гэж . . . Үгүй ээ, авдаг юм уу ч ю убайхав ерөөсөө л авья гэж шийдээд. Тэгээд л би ирж байгаа маань энэ. Бид чинь томхүмүүс, нөхцөл байдлыг сэтгэл хөөрлөөр биш арай өөрөөр харах хэрэгтэй юм болов уугэхдээ шулууха н хэлчихлээ.

Анхмаа

яагаад

ирээгүй

Сувдааюм?

НадмидХэ хэ. Цаадах чинь харин жаахан санаа нь зовоод байх шиг байнаа. Тэгээд л . . . хэ хэ, эрхүн байна чи хэл, чи хэл гээд намайг бүр суулгадаггүй. Би ч бас дуртай л байгаа л даа

СувдааХарамсах юмгүй гэдэг утгаар гэх үү, эсвэл мөдхөн үхэх гэж байна гэдэг утгаараа гэх үү бичамд шуудхан хэлье. Ер нь ч чи бид хоёрын яриа тиймэрхүү байгаа болохоор. Минийхоины талаар санаа тавьж байгаа Анхмаа, ялангуяа чамд маш их баярлалаа. Даанч бихүүхдээ аль хэдийн өөр хүнд өгөхөөр шийдчихсэн. Тэгэхээр би чамд уучлаарай гэдэгүгийг хэлэх болох нь . . .гээд Сувдаагийн амьсгаадах дуу сонсогдоно. Тэр их хүнд амьсгалж байв. Хэсэг хугацаандараа Надмид шал өөр шүд зуусан өнгөөр

НадмидЮу гээч . . . ? Чи үхэж байна. Чамайг хаа нэг тийшээ арилсны дараа энд бүх юм чинийбодсоноос эсрэг байх болно. Чамд бас ч гэж сонголт ч байна, цаг ч байна. Үхэх гэж бүүяр. Сайн бод. Оройтоогүй дээрээ Номинг, үгүй ээ н өгөө . . . за хэн ч байсан яахав хүүхдээнанад өгсөн нь дээр. Тэгэхгүй бол . . .

Сувдаа

Тэгэхгүй бол юу гэж?

НадмидЭцэг нь гэж нэг яргачин амьд байгаа шүү. Солгой Аюуш өнөө мөдгүй суллагдана.Шоронгоос гарсан хулгайчид юм юм л хэрэгтэй болно доо . . .Үүнийг сонсоод би Сүхээ рүү айсан нүдээр харлаа. Сувдаагийн амьсгаа улам хүндэрчбайгаа нь илт. Өндийх гэж байна уу гэлтэй орных нь пүрш дуугарна.

НадмидТээр хараа биз? Цээжин дээр чинь ганц хуруугаа хүргэхэд л чи наад хэнд хэрэггүй болсонзовлогоо даахгүй байна шүү дээ.Тэр Сувдаагийн цээжин дээр нь хуруугаараа дараад байгаа бололтой. Хөөрхий минь яаждийлэх вэ дээ. Хий дэмий л хүчлэн амьгаадна.

СувдааЧи . . . чи ийм болсон хүнийг ингэж дарамталж байдаг адгийн шаар юм даа

НадмидХүнд, ганц хуруу ч хүнддэх үе ирдэг юм, үхдэл минь. Ийм өдрүүд охинд чинь хичнээнудаа ирэх бол?, сайн бод. Хэрвээ охин чинь манай хаяанд хэвтэж байвал цаад Аюуш гэдэгзолбин чинь хэзээ ч мэдэхгүй гэдгийг би амлая. Би чинь бас ч гэж хүн шүү. Надад бассэтгэл бий . . . Сайн бод. Гэхдээ үхэхээсээ өмнө амжиж шийдэх хэрэгтэй гэдгээ мартав даа,үхэж буй ээж минь . . .гээд бас амьхандаа хариу хүлээгээд байгаа бололтой хэсэг удав. Тэгтэл

СувдааЧи чадвал хүлээ л дээ. Чамайг мянган жил хүлээсэн ч би чиний өмнө амь тавихгүй. Хүсвэлби чамтай хамт явж ч дөнгөнө шүү. Итгэхгүй бол чи наанаа үхдэл сахисан хар хэрээ шигсууж л бай.

гэхэд Надмидын хөлийн чимээ хурдан хурдан гишгэлсээр гарах нь сонсогдохыг бодоходтэр айсан байх. Мэдээж Сувдаа түүнийг ямар л олигтой харцаар харав гэж.

- Ямар зэвүүн, заваан . . . гэж намайг хэлэх үгээ олж ядахад Сүхээ- Тэр заавал үүнийхээ горыг амсах ёстой. Гэхдээ хуулийн хүрээнд гэж шүд зуун хэллээ. Сая л би түүнийг “Нээрээ, Сүхээ чинь цагдаа ш дээ” гэж саналаа. Би гэдэг амьтан хэдхэн хормын өмнө баярлаж, хайлж уярч байсан бол одоо үзэн ядалтынманан дунд нүдээ эргэлдүүлэн зогсож байв.- Энэ хорвоо яагаад ийм Надмид шиг юмнуудыг дааж байдаг юм байнаа? гэхэл Сүхээ- Болороо минь одоо тайвшир. Эхлээд Анхмаатай уулзах хэрэгтэй. Энэ бол хөдлөшгүйбаримт. Яагаад тэр Надмид гэдэг этгээд охиныг авах гээд байсны учрыг олж болно. Харинодоо охиноо хар даа. Чиний хүсэл мөрөөдөл болж байсан охин чинь одоо орон дээр унтажбайна шүү дээ гэхэд нь сая нэг сэхээ авч- Сувдаа минь баярлалаа. Би охиноо яг чиний хүссэн шиг сайхан хүн болгож өсгөнө. Амлаж байна гэж шивнэлээ. Тэр үед Сувдаа намайг тэнгэрээс харж байсан бай хаа. Охиныхоо гарыг очиж үнслээ. “Намайг хүүхдээ надад өгсөнгүй гэж гэртээ бачуурч суухадхөөрхий минь охиноо надад өгөх гэж Надмидтай хэрээрээ л тэмцэж байсан байна шүү дээ” гэж бодохоор дотор нэг юм шатна. Охин минь тайван унтана.

\*

\*

\*

Хананд өлгөөтэй хоёр туулай тэвэрсэн охиныхоо зургийг өөрийн эрхгүй харлаа. Эвийминь гэж энэ өчүүхэн амьтан өөртөө ирж буй хувь заяагаа хэрхэн мэдэрч байсан бол? гэжбодсон чинь яагаад ч юм хамар шархирч, нулимс цийлэгнэж ирэв. Яг юу бодож байсанбол?Ээж маань намайг орхиод явчихлаа . . .Би нь Болороо эгчийн хүүхэд болох ёстой . . .Ээжээ та нь эдгэнэ гэхихээд худлаа хэлчихлээ ш дээ . . . гэсэн үү? Ямар ч байсан өөртөөтаарсан нэг л юм бодож л байсан байж таарна даа гэж бодохоор өр зүрх маань өмөрчихшиг л санагдлаа. Би урд нь охиныхоо талаар ерөөсөө ингэж бодож байгаагүй юм байна. Биохиныхоо зургийг хананаас авч харжээ суутал шилэн нүүрэн дээр нь юу юугүй нулимсдусахаар нь хурдхан шиг арчлаа. Тэгээд зургаа элгэндээ тэвэрч бүүвэйлж байгаа юм шигганхан, ганхан хэсэгхэн суув. Нүдний буланд нэг юм хөдлөх шиг болохоор нь харталөвгөн маань над руу хошуу цорвойж харагдана. Тэр минь намайг ойлгохын дээдээрйлгож байгаа нь тэр.

\*

\*

\*

Маргааш нь Сүхээ бид хоёр Анхмаа дээр очлоо. Тэр дүүгийн дээ ирсэн байв. Дүүгийн д нгуулзах гэснээ больж түүнийг авч гарлаа. Нүүр ам нь хөхрөөд, эдгэж байгаа бололтой шарногоон юм болчихож.- Анхмаа, талийгчийн үлдээсэн бичгээс чиний тухай там тум ойлголоо. Чи минь иймэрхүүюмаа бидэнд хэлэхэд яадаг юм дээ. Ингэж гэр бүлийн хүчирхийлэл дор хэдэн жил амьдрах юм бэ? Би чинь чамайг маш сайхан амьдардаг гэж ойлгож байлаа.- Харин тийм ээ. Эхэндээ бидний амьдрал сайхан л байлаа. Сүүлийн үед уурхай энэ тэргээд энэ алттай холбогдсоноос хойш Надмидын зан ааш, хүсэл шунал нь хэрээс

ХЭТЭРСЭН.

Бүхнийг өөрийнхөө санаснаар болгох, бүгдийг өөрөөсөө дорд үзэж, гар хөлийнхөө дорбайлгах гэдэг болсон. Ууж идээд байг аа нь харагдахгүй хэрнээ юм л бол мөнгө, эрх мэдэл, алт ярьдаг болсон. Хүний сайхан сэтгэл энээ тэрээг бол бүр мартсан. Тэр ч бүү хэлорчлонд тийм юм гэж байдаггүй юм гэж хэлдэг болсон. Хоёр хүүгээ харцаараа хөдөлгөнөгэснээ гэнэтхэн бид хоёрыг харж өөрийг өө зөв буруу эсэхэд эргэлзэх мэт болсноо- Би та хоёрт ингээд хамаг байдгаа ярьж, баахан зовлон тоочих нь дээ.- Зүгээр, зүгээр сэтгэлээ жаахан онгойлгоод ав гэхэд тэрээр шийдэв бололтой- Энэ жил Надмидын үйлдвэрт хүн нас бараад. Мэдээж ар гэрийнхэн нь х эл ам хийлгүйяахав дээ. Түүнээс болоод тэр их бухимдуу байх болсон юм. За тэгээд талийгаачийн биемуудсан тухай сонсогдсоноос хойш намайг ээрээд болохоо байлаа.- Юу гэж? - Охиныг нь авна гэнэ

- Хүслэнг үү?- Тийм. Гол нь охиндоо ч биш. Кафед нь болоод ба йгаа байхгүй юу Охиныг нь үрчлээд авчихвалтэрний эзэн болно гэж тооцоолсон хэрэг.- Тэр том үйлдвэртэй хүн тэр муу жаахан кафегаар яах гэсэн юм болоо?- Үгүй ээ, харин тийм л шуналтай болсон байхгүй юу. Бүр авах идэхийн дон. Би түүнд зөвшөөрөөгүй юм. Анх талийгч кафегаа өөрийн болголоо гээд бид хэд сууваа даа. Тэгээд дараа нь би Надмидадманай Сувдаа мөн сүрхий юм. Өөрийн гэсэн хөрөнгөтэй болчихлоо. Тэгээд бид гурав жааханхөөрөөд суучихсан гэсэн чинь л юун сүртэй юм. Тэрийг ямар хөрөнгө гэдэг юм. Миний машин ямарүнэтэйг мэдэх үү? Ийм хоёрхон машины мөнгө цуглуулчихаад хөрөнгө гэлээ гээд л баахан ихэрхэв. Тэгэхээр нь ийм юм ойлгохгүй байхдаа яадаг юм. Чи ямар тэглээ гээд хоёр машинаа зэрэг унажчадах биш гээд хэлчихсэн чинь уурлаад тэр шөнө намайг ээрч өдсөөр байгаад хэрэлдэж байгаа юмдаа.- Ямар ичдэггүй юм бэ?- Ичих ч бүр өнгөрсөн. Сүүлдээ охиныг нь авья гэж хэл гээд, би үгүй гэсний төлөө зодуулав. Зодохдоо аль хүн харахгүй суга цавь, гарын дотор талаас чимхэж, базна. Тэгээд намайг хашгирахгэхээр ам таглаад дарчихна. Хоёр хүүхдэдээ сонсохгүй гэж тэр.- Аан, тэгээд чи бүр нэг хэсэг хачин болчихсон юм байна ш дээ.- Сүүлдээ бүр та нартай уулзахаас халшираад, хоёр хүүдээ ч хэлж чаддаггүй. Гэрийнхэндээ хэлэхгэхээр манай хоёр дүү Надмидаас хэдэн төгрөг зээлчихсэн байдаг. Ёстой дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу гэдэг л болсон. Та нар бод л доо. Нарийн бичгээ хүртэл талийгчийн кафе рууявуулж судлуулсан байгаа юм даа.- Зэвүүн муу новш вэ?- Тэр ч бүү хэл нөгөө солгой Аюуш гэдгийг хүнээс асуулгасан гэсэн.- Аан тийм, дуу хураагч дээр нэг тийм юм байсан шүү. Ингэхэд тэр яаж Аюушийг нь мэддэг юм? гэжнамайг асуухад- Би л нэг удаа хэлчихгүй юу дээ. Хөөрхий, Сувдааг маань тэгж зоддог байсан гэнэ. Тийм балиар хүнэнэ орчлонд бас байдгаа гээд түүнд яриад байсан чинь харин яг хажууд байж байсан байдагбайгаа. Тэгээд сүүлд талийгаач дээр өөрөө очно гэхээр нь би түрүүлж очиж битгий өгөөрэй Сувдааминь. Манайд л охиноо өгч болдоггүй юм шүү. Надмид кафег чинь үгүй хийгээд охиныг чиньгудамжинд хаячихаасаа сийхгүй хүн гэж хэлэхэв дээ. Талийгаач бүр итгэддэггүй. Тэгэхээр нь хамагхувцасаа тайлж бүр хөх няц болсноо үзүүлсэн ш дээ гээд Анхмаа уйлах гэснээ нулимсаа цааш ньзалгилаа. Тэр сүүлийн хэдэн сарын дотор нулимсаа тэвчиж сурсан бололтой. Энэ бүхнийг сонсож суухдаа өнгөрсөн хугацаанд хоёр найзын минь амьдралд чухам юу болоод өнгөрснийг ойлгож зогсохдоо өөрийгөө мөн ч өчүүхэн байна даа гэж бодлоо. Би ер нь ямаргээчийн амьтан юм бэ бүү мэд. Би тэдний хажууд үнэхээр юу ч үзээгүй байлаа. Зөвхөн талийгаачийгөөртөө хүүхдээ өгөхгүй нь гэж гол гонсойсондоо Сүхээг үзэн ядаж, орчлонд ганцхан өөрийгөө аз

заяагүйд тооцон ганихарч, өөрөө өөрийгөө л өрөвдөж, өөрөө өөртөө зовлон зохиож явсан байлаа. Гэтэл найзууд минь нэг нь үхэлтэй, нөгөө нь амьдралтай тэмцэж явсан байна шүү дээ. Анхмаа үнэхээр гайхалтай тэвчээртэй бүсгүй юм. Хүслэнгийн төлөө, түүний ирээдүйг буруу хувь тавилан руу оруулчихгүйн төлөө бараг шөнө болгон зодуулж, нүдүүлж, зулгаалгаж байсан байх юм. - Наад нүүр ам чинь бүүр . . . - Одоо овоо гайгүй болчихоод б айгаа нь энэ. Талийгаачийг өнгөрсөн орой намайг бүр нэвширтэлбалбасан ш дээ. Овоо хүнд харагдахгүй газар зоддог байснаа тэр орой хамаагаа алдсан. Бодвол эцсийн боломж нь ингээд дууслаа гэхээр тэгсэн байх- Чи яаж тэсэв ээ?- Тэсэх ч гэж дээ. Би чадахгүй ээ, чадахгүй араатан минь гэж хэлснээ л санадаг. Нэг сэрсэн чинь хоёрхүү маань нүүрэн дээр нойтон алчуур тавьж байсан. Бас болоогүй ээ хүү маань манай дүү нар лууярьсан байсан. Тэр хоёр ирж бид гурвыг авсан.- Ирсэн үү? тэр араатан, чиний араас . . . - Ирсэн. Ажил дээр хүний амь яригдаад байхад чи энүүгээр ингэж маяглалаа. Дүү нарыг чинь өрөнд бариулж, шоронд хатааж дөнгөнө шүү би гээд өнөө л хэлдэгээ хэлж байсан гэтэл Сүхээ саянэг ам нээж- Тэр одоо тэгж чадахгүй. Чи сална гэж шийдсэн бол шүүх эмнэлэгт очиж акт гаргуул. Тэгээд гомдол гаргаж салах өргөдлөө өгч болно. Харин би тэр ажлынх нь хүний ар гэрийнхэнтэй уулзана. Болороо Хүслэнгийн ээж болж байгаагийн хувьд талийгаачийн өмнөөс гомдол гаргаж болно. Дуу хураагчид бичсэн хэсэг нь хуулийн өмнө нотлох б аримт болохгүй ч үндэслэл болж чадна. Ер нь тэгээдий мэрхүү хүмүүс ихдээд ирвэл бид яаж тайван амгалан амьдрах юм гэлээ.

\*

\*

\*

- Хөгшөөн! Хэд хоног наад бичиг цаасаа завсарлахаас болохоо байлаа гэж өвгөн хэллээ.- Юу . . . ? Яагаад билээ? Мөдхөн дуусах гэж байхад . . . - Манайх нүүх боллоо. Дараагийн долоо хоногт. Манай байрныхан аль хэдийн нүүгээд эхэлчихсэн шүү дээ. Одоо бидний ээлж болоод байна. Гэр орныхоо юмыг эмхлүүлэхгүй бол болохгүй нь. Манай новш гэж яасан ч их юм гэж байна. Нээрээ, манайх нүүх болжээ. Тэгээд л нэг жаахан ухаан орж гэр орноо янзаллаа. Нэг байрандаа удсан болохоор айлын новш гэдэг өдөр хоногоор хураагдаж байдаг юм хойно манайх хэрэгтэй, хэрэггүй юмаар дүүрсэн байв. Хэдэн өдөр ноцолдоод, хүргэдүүд машин олж ирэх тэр өдөр л арай гэж гайгүй болов. Хүүхдүүд бужигналдан юмаа зөөсөөр байр маань хоосорлоо. Хоосон болохоор бараг амьсгаа хүртэл цуурайтна. Гадаа нарны элч хариад намрын шинж бүрнээ орж. Мөдхөн моддын навч хаялах шинжтэй. Цаг нь ирж байгаа хойно тэгэхээс яахав. Машинд суун явахдаа хуучин байраа эргэн, эргэн харсаар булан тойрлоо. Цээжинд үл мэдэг гуниг хуйргансаар байх ажээ.

\*

\*

\*

Удалгүй бид Хүслэнгээ өдрийн цэцэрлэгт өглөө. Хүслэн маань баярлаж байгаа гэж учир алга. Өдөр болгон гэртээ харьдаг байх нь охины минь мөрөөдөл байсан шиг байгаа юм. Гэтэл тэр мөрөөдөл нь биелэх агшинд өдөр бүр хамт байхыг хүссэн ээж нь байхгүй болчихсон байдаг. Орчлон хорвоогэдэг угаасаа нэг хүслийг биелүүлэхдээ нөгөө хяслыг бий болгодог

юмаа даа янз нь. Гэхдээ би Хүслэндээ яг ээж шиг нь байхыг хичээсээр ирсэн. Тийм ч байж чадсан гэж боддог юм. Энэ нь нэгд, найзынхаа өмнө хүлээсэн үүрэг, хоёрт гэвэл Хүслэн маань миний охин шүү дээ. Одоо энэ том охин маань юм шүү дээ. Нэг өглөө би охиноо цэцэрлэгт нь хүргэж өгөхөөр алхаж явтал Хүслэн- Нөгөө, нөгөө . . . Сүхээ ах нь ирж байна гэлээ. Хартал Сүхээ гудамжны нөгөө талаас гүйсээр иржамьсгаага дараад надад нэг хайрцагтай юм гаргаж өгсөн нь сүйн бөгж байсан юм. Амьдралдаа

ийм юм авч үзээгүй. Кинонд л ийм юм байдаг гэж бодож явсан би бүр сандарч орхив. Сүхээ- Аав чинь байсан бол өдийд “Засаж болдог алдааг, алдаа гэдэггүй юм” гэж хэлэх байсан байх. Тэгэхээр Болороо минь надад нэг боломж өгөөч гэсэн юм. Яг л кино шиг. Би бөгжийг шууд авчадсангүй. Цээжинд нэг л сайхан гэгэлгэн цагаан аялгуу хадах шиг. Баяр ч төрөх шиг. Гэхдээ би юүгэхээ хэлж мэдэхгүй байв. Хүслэн намайг харж зогссоноо- Болороо эгчээ авчихаач, Сүхээ ах нь гуйгаад бай на ш дээ гэхэд нь сая нэг ухаан орж- Ямар сонин газар, ямар сонин цагаар өгдөг юм бэ? гэхэд тэр- Харин ч зөв үе. Одоо яг өглөө болж байна. Бидний амьдрал өглөө шиг эхэлж, нар шиг мандвалсайхан. Энэ гудамжаар ажилдаа яаран, яаран яваа хүмүүс шиг амьдрах чин хүсэл бид гуравтгурвууланд минь байгаа гэсийм. Тэр ухаалаг мөртлөө сэтгэлийг минь урвуулах увидастай үг хэлжзогссон залуу чинь одоо энэ манай өвгөн шүү дээ. Энэ өдрийг хэзээ ч мартдаггүй юм. Яаж ч мартахбилээ дээ. Бид гурав цааш хөтлөлцөн алхлаа. Хүслэн цангинасан дуугаар- Тэр манай хуучин цэцэрлэг гэж замын эсрэг тал руу заав. “24 - ийн цэцэрлэг” гэсэн хаягтай тэрбайшин руу нэгэн ээж хүүгээ хөтлөн хоцорсон бололтой гүйж ирснээ хаалга балбаж байв. Цэнхэрхалаадтай бүдүүн багш хаалгаа тайлж байгаа харагдана. Тэр бас л уурлаж байсан байх. “Ганц Сувд” кафе маань онгойж үйлчлэгч үүднийхээ хогийг цэвэрлэнэ. Хажуугийн нотариатч үүдээ нээчихсэнбидэн рүү даллаж байв. Тэр өглөөг би ямагт бодож явдаг. Нэг л тийм амьдрах итгэл, сэтгэл, хүсэлнэгдсэн өглөө байсым. Ер нь бол бид гурвын өглөө байсан даа. Сэтгэл цадах гэдэг сайхан юмбилээ. Хүслэн- Нөгөө, нөгөө . . . шинэ ангийн хүүхдүүд намайг аавгүй, аавгүй гэж шоолохгүй тэ? гэхэд Сүхээ- Үгүй дээ охин минь, Одоо чамайг хэн ч дахиж тэгж шоолохгүй гэхэд Хүслэн- Бас ээжгүй гэж дуудахгүй. Яагаад гэвэл ээж миний чихэнд “Миний охин Болороо эгчийгээ “Ээжээ” гэж дуудаж болно гэж хэлсэн” гэлээ. Миний хамрын угаар шархираад явчихлаа. Тэр, сүүлийн өдөр талийгаач Хүслэнтэй уулзахдааохиныхоо чихэнд тийм л юм шивнэж байсан байж шүү дээ. Эх хүний сэтгэл гэдэг ямар агуу юм бэ? Өвгөн бид хоёр охиндоо хачин их хайртай. Хайргүй байхын ч аргагүй. Бид хоёрын амин зүрх юмшүү дээ. Тэгж их хайрласны хариу юмуу, Хүслэн минь булган сүүлтай байж ерөөсөө зургаахансарын дараа бага охиноо олсон юм. Ёстой гайхамшиг гэж л тэр байлаа. Хувь заяа гэдэг тийм, иймгээд хэлчихэж болдоггүй зураг юм шиг байгаа юм. Магадгүй би зөвхөн энэ хүнээс л хүүхэдтэй болох хувьтай байсан байх л даа. Энэ охиноо би бурханы хишиг гэж боддог. Ер нь ч тийм. Харин өвгөн маань түүнийгээ талийгаачийн сүнс хэмээн бодож “Сувдаа” гэдэг нэр өгсөн дөө.- Яагаад ийм нэр өгвөө? гэж асуухад- Чи биднийг дуусан дуустал манай гэрт энэ нэр дуудагдаж байг гэсийм. Тиймээ, энэ нэр манайд дуудагдсаар л байна. Хэдэн жилийн дараа каф егаа буцааж орон сууцболгосон. Ахлах тогооч маань яг ижилхэн үйлчилгээтэй кафег өөрөө нээсэн байсан. Тэр, энэбүгдийг Сувдаа эгчээсээ сурсан юм шүү дээ гэж хэн хүнд хэлж, ярьж явдаг гэсэн. Хүслэн маань тэрүеийн миний байранд, Сувдаа маань тэр үеийн өвгөн ий байранд тус тусдаа амьдарцгааж байна. Харин энэ байрандаа өвгөн бид хоёр өдий хүртэл амьдарч байна даа. Одоо л хэзээ мөдгүй нураахболчихлоо. За за өөрийнхөө амьдралд тохиолдсон хамгийн эмзэг, хамгийн сайхан, хамгийн торгонхэсгээ бичлээ.

\*

\*

\*

Өчигдөр бид Хүслэнгийн олсон түрээсийн байранд нүүж ирлээ. Өнөөдөр өвгөнтэйгээ очиж байрыгминь нураахыг харлаа. Дээрээс нь эхлээд тракторын том шанагаар татаад



нурааж байна лээ. Тоосшороо бужигнуулан нурж байгаа байшин маань яг л уйлж байгаа юм шиг санагдсан. Манайх нэгдавхар болохоор хамгийн сүүлд нурж таарав. Цонх нь наранд гялтганаад яг л надаас нэг юм

гуйгаад байгаа харц шиг өрөвдөлтэй. Нэг мэдсэн чинь өвгөн маань- Хөгшөөн! одоо уйлаад яахав. Оронд нь цоо шинэ байшин барьчихна гэж аргадлаа. Тийм дээ. Тэнд цоо шинэ байшин баригдаж, цоо шинэ амьдрал, цоо шинэхэн түүх эхлэнэ. Битүүнийг гарцаагүй мэдэж байна. Гэхдээ мэдээж хүний л түүх байх болно. Эртээдхэн нэг өдөр намайг- Шинэ байраа яах вэ? гэж асуухад өвгөн- Тэр чинь эзэнтэй шүү дээ гэсэн. Тийм л дээ. Энд Хүслэн минь амьдарна. Сувдаа минь охиноо ямархүн болж, үр удам нь ямархан түүхтэй, эцэг эхийнхээ гал голомтон дээр хэрхэн амьдарч байгаагтэндээс харж байгаа. Хэзээ нэгэн цагт би ч гэсэн тэнд очно. Тэгэхдээ найз нь чамдаа бүгдийг ярьжөгнөө . . .

\*

\*

\*

Би дурсамжаа бичээд дуусчихлаа. Гэхдээ хүүхдүүддээ бараг уншуулахгүй байхаа. Тэд маань өөрсдийнхөө жамаар амьдарч, өөрсдийнхөө дурсамжийг бий болгох болно. Бидний дурсамжаартэд маань амьдрахгүй шүү дээ. Тэгэхээр энэ бичсэнээ урчих л байхаа даа . . . Би амьдралд хайртай. Гэр бүлдээ, хүргэд, охидууддаа, зээ нартаа бас өвгөндөө хайртай. Тэр дундаа энэ бүгдийг надад бэлгэлсэн найз Сувдаадаа бүр ч их хайртай. Хүмүүн бид хайраас хайр дамжин амьдардаг юм байна. . .

Тэтгэвэрт

гарсан

жилийн

хавар,

зун,

намар.

Төгсөв. Зохиолч Түмэнбаярын Бум - Эрдэнэ 2012 он